

Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хөгжлийн төлөвлөлтөнд нэгтгэн тусгах нь:

МАЛАЙЗ УЛСЫН ЖИШЭЭ, ТУРШЛАГА

Профессор, доктор Датук Ноор Азлан Газали
Малайз улсын Үндэсний их сургуулийн дэд захирал

Профессор, доктор Датук Жон Антони Завиер
Малайз улсын Үндэсний их сургууль, Бизнесийн сургууль

Энэхүү судалгааг НҮБХХ-ийн Бангкок дахь бүсийн төвөөс санаачлан хийлгэж, НҮБХХ-ийн Монгол улс дахь Суурин төлөөлөгчийн газраас “ТХЗ-ыг Монгол улсад хэрэгжүүлэх бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх нь” төслийн хүрээнд 2017 оны 9 дүгээр сард орчуулав.

<i>Нөхцөл байдал: НҮБ-аас Мянганы хөгжлийн зорилтуудын дараагийн шатны зорилгуудыг дэвшүүлэв</i>	5
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО, ИНСТИТУЦ, ҮЙЛ ЯВЦ	7
1. Алсын хараатай сэтгэлгээ ба хөгжлийн бодлогын нөхцөл байдал	7
<i>Нийгэм, эдийн засгийн ерөнхий бодлого нь хөгжлийн тэргүүлэх чигийг заана</i>	9
<i>Дунд хугацааны бодлого төлөвлөлт: Эдийн засгийн шинэ загвар</i>	10
<i>Урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө, тэргүүлэх чиглэл</i>	11
<i>Хэтийн төлөвлөгөөг Таван жилийн хөгжлийн төлөвлөгөө болгон буулгах нь</i>	11
<i>Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих нь</i>	13
<i>Үндэсний шинэтгэлийн хөтөлбөр</i>	14
2. Төлөвлөлтийн тогтолцоо	16
3. Төлөвлөлтийн үйл явц ба холбогдох байгууллага	17
<i>Дээрээс доош чиглэсэн макро төлөвлөлт</i>	18
<i>Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах удирдамж</i>	19
<i>Хөгжлийн төлөвлөлтийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг</i>	19
<i>Доороос дээш буюу дунд хугацааны төлөвлөлт</i>	21
<i>Доороос дээш чиглэсэн богино хугацааны төлөвлөлт: хоёр жилийн төлөвлөгөө, жилийн хөгжлийн төсөв</i>	22
4. Төлөвлөлтийн хүрээ	22
<i>Цэнхэр-далай аргыг ашиглан хэрэгжүүлэх төслөө тодорхойлох нь</i>	26
<i>Жилийн төсвийн төлөвлөлт</i>	26
5. Хяналт шинжилгээ, үнэлгээ	28
6. Орон нутгийн төлөвлөлт	29
<i>Мужийн захиргааны бүтэц, зохион байгуулалт</i>	29
<i>Мужуудад зориулсан хөгжлийн санхүүжилт</i>	31
<i>Орон нутгийн төлөвлөлтийн байгууллагууд ба төлөвлөлтийн үйл явц</i>	32
<i>Хяналт шинжилгээ, үнэлгээ</i>	33
7. Түншлэл ба оролцоо	34
ХОЁРДУГААР ХЭСЭГ: 2030 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ МАЛАЙЗ УЛСЫН	34
ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТӨНД НЭГТГЭН ТУСГАХ НЬ	34
ТХЗ/2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлал ба төлөвлөлт	34
<i>МХЗ ба Тогтвортой хөгжил</i>	35
<i>21 дүгээр зууны хөгжлийн зорилго</i>	35

ТХЗ/2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг төлөвлөлтөнд нэгтгэн тусгаж буй байдал

.....35

2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх засаглалын бүтэц, замын зураг36

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫГ НЭГТГЭН
ТУСГАЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ГАРСАН СУРГАМЖ, ЗӨВЛӨМЖ39

Дүгнэлт43

Товчилсон үгс

SDGs	Sustainable Development Goals	ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилгууд
MDGs	Millennium Development Goals	МХЗ	Мянганы хөгжлийн зорилтууд
OPP	Outline Perspective Plan	ХТ	Хэтийн төлөвлөгөө
NEP	New Economic Plan	ЭЗШТ	Эдийн засгийн шинэ төлөвлөгөө
NVP	National Vision Policy	ҮАХБ	Үндэсний алсын хараат бодлого
NDS	National Development Strategy	ҮХС	Үндэсний хөгжлийн стратеги
NEM	New Economic Model	ЭЗШЗ	Эдийн засгийн шинэ загвар
ETP	Economic Transformation Programme	ЭЗШХ	Эдийн засгийн шинэтгэлийн хөтөлбөр
NKRA	National Key Results Areas	ҮХҮД	Үндэсний хүрэх ёстой гол үр дүн
EPP	Entry Point Projects	ГТ	Гарааны төслүүд
EPU	Economic Planning Unit	ЭЗТГ	Эдийн засгийн төлөвлөлтийн газар
SEPU	State Economic Planning Unit	МЭЗТГ	Мужийн Эдийн засгийн төлөвлөлтийн газар
NDPC	National Development Planning Committee	ҮХТХ	Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хороо
NDPC	National Development Planning Council	ҮХТЗ	Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн зөвлөл
IAPGs	Inter-agency Planning Groups	БХТХ	Байгууллага хоорондын төлөвлөлтийн хэсгүүд
TWGs	Technical Working Groups	МАХ	Мэргэжлийн ажлын хэсгүүд
ICU	Implementation Coordination Unit	ХЗГ	Хэрэгжилт зохицуулах газар
NAC	National Action Council	ХХҮЗ	Хэрэгжилтийг хангах Үндэсний зөвлөл
NAWC	National Action Working Committee	ХХҮХ	Хэрэгжилтийг хангах Үндэсний хороо

Нөхцөл байдал: НҮБ-аас Мянганы хөгжлийн зорилтуудын дараагийн шатны зорилгуудыг дэвшүүлэв

2015 оны 9 дүгээр сарын 25-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэд баримтлалыг албан ёсоор баталж, илүү сайн сайхан дэлхий ертөнцийн төлөөх Тогтвортой хөгжлийн шинэ зорилгуудыг (ТХЗ) баталсан билээ.

2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь МХЗ-ыг хэрэгжүүлэх явцад учирч байсан сул талыг арилгаж, дутууг нөхөхийн зэрэгцээ хүмүүс, эдийн засаг, хүрээлэн буй орчныхоо сайн сайхан нөхцөлийг улам бүр дээшлүүлэхийн тулд дэлхий нийтийн өмнө тавигдаж буй гол зорилгыг тодорхойлсон. ТХЗ нь 17 зорилго, 169 зорилттой бөгөөд ядуурал, өлсгөлөн, тэгш бус байдлыг арилгах, үүр амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, байгаль орчноо хамгаалах, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар хүчирхэг институци, түншлэл бий болгохыг зорьж байна. Энэ бүхэн нь хөгжлөөс хэн ч орхигдон хоцрох ёсгүй гэсэн үндсэн зарчимд тулгуурлаж байгаа болно.

ТХЗ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд засгийн газрын нэг цул бүхэл болж, нэгдмэл арга барилаар ажиллах шаардлагатай. Мөн хөрөнгө санхүүжилт босгох, инноваци, мэдлэг мэдээллээ хуваалцах хэрэгцээ шаардлага гарахаас гадна төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэний нийгэм, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, бүс нутгийн болон олон талт байгууллагын идэвхтэй түншлэл хэрэг болно. Мөн төлөвлөлт үр дүнтэй, бодлого ба хууль эрх зүйн орчин зөв, эрүүл, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, институци хүчтэй байх хэрэгтэй байна.

Малайз улс МХЗ-д хүрэхэд мэдэгдэхүйц дэвшил гаргасан

Энэ хэсэгт Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ)-ыг хэрэгжүүлэх явцад гарсан ололт амжилтын талаар өгүүлнэ. Бусад улс орны нэгэн адил МХЗ нь улс орны хөгжлийн нэг тэмүүлэл, байгаль орчноо хамгаалах бодлогын чухал хэрэгсэл болж чадсан.

Эдийн засгийн өсөлт бол ард түмний сайн сайхан амьдралыг хангахын төлөө л хийгддэг, түүнд л зориулагдах ёстой гэдэгт Малайз улс итгэдэг. Энэ итгэл, гүн ухаанаа "тэгш бололцоо олгосон өсөлт" гэдэг урианд шингээсэн бөгөөд 1970-аад оноос хойш Малайз улс хөгжлийн бүхий л үйл ажиллагаандаа баримталж иржээ. Ингэсний хүчинд нэн ядуурлыг арилгаж, ядуурлыг 0.6% хүртэл бууруулж чадсан.¹ Мөн орлогын тэгш бус байдал огцом багасч, Жини коэффициент 2002 онд 0.46 байсан бол 2014 онд 0.4 болсон байна.²

Малайз улс үндэсний хөгжлийн зорилгоо тав, таван жилийн хөгжлийн төлөвлөгөөгөөр хэрэгжүүлж байна. Өмнөх төлөвлөгөөнүүд болон одоогийн хэрэгжиж буй таван жилийн төлөвлөгөө болох Малайз улсын 2016-2020 оны 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд МХЗ-тай адил төстэй зорилтууд орсон, зарим талаараа ТХЗ-тай адил төстэй зүйл ч бий. Малайзын 2016-2020 оны 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний зорилго ТХЗ-тай тун төстэй. Сүүлийн 15 жилд Малайзын эдийн засаг тууштай өсч, ард иргэдийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг мэдэгдэхүйц өөд татсан. Тухайлбал, дараах амжилтыг дурдаж болно (2016 онд ТХЗ-ын Симпозиум дээр Ерөнхий сайдын албаны Сайдын хэлсэн үгнээс авав):³

- Нэн ядуурал, өлсгөлөнг устгасан. Малайз ядуурлыг бууруулах анхныхаа стратегийг 1971 онд буюу МХЗ батлагдахаас 30 жилийн өмнө хэрэгжүүлж эхэлсэн.

¹ Ядуурал, хөгжлийн судалгааны төв 2016: Ядуурлын тайлан, Хураангуй – Малайз. Малаяа Их сургууль. х. 1. http://cpds.um.edu.my/wp-content/uploads/2016/08/Poverty-Summary_Malaysia_270516.pdf

² Лий, Х.А, Мухаммед А.К (2016). Малайз улсад тэгш бус байдал үнэхээр буурч байна уу? Шийдлээ олсон нь. Хөгжлийн судалгааны багийн Куала Лумпур семинарын цуврал, 2016 оны 10-р сарын 13, Сасана Кижанг, Куала Лумпур. х. 6. <http://pubdocs.worldbank.org/en/285151475547874083/Is-Inequality-in-Malaysia-Really-Going-Down.pdf>. ЭЗТГ (2016). Малайз улсын 11 дүгээр 5 жилийн төлөвлөгөө (2016-2020). Путражаяа. х.77.

³ Сенатор Дато Сри Абдул Вахид Омар (2016). Ерөнхий сайдын албаны Сайд, ТХЗ-ын Симпозиум: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нь, ТХЗ-ыг хэрэгжүүлэх Малайз улсын амлалт ба Хүнээ дээдэлсэн Асеан. 2016 оны 2-р сарын 26. Путражаяа. х. 1-15. <http://www.epu.gov.my/sites/default/files/sdgsymposium.pdf>

- Ядуурлыг 0.6% хүртэл бууруулсан. Энэ нь 2009 онд 3.8% байсан.
- МХЗ-ын бүх нийтээр бага боловсрол эзэмших зорилтыг биелүүлсэн, чингэхдээ зөвхөн хамран сургалтаар төдийгүй бага боловсрол эзэмшсэн хүүхдийн тооны хувьд ч уг зорилтыг хангасан. 2014 онд бага сургуульд хамрагдалт 98%-д, төгсөлт 99%-д хүрсэн.
- Боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, удирдах болон шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангахад ахиц гарсан. Жишээ нь, 2013 онд дунд боловсрол эзэмшиж буй охидын тоо хөвгүүдээс 7%-иар, дээд боловсрол эзэмшиж буй охидын тоо хөвгүүдээс 31%-иар өндөр байв. Хэдийгээр ЭЗХАХБ-ын дундаж болох 61%-иас доогуур байгаа ч эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 2014 онд 54%-д хүрч өссөн. Удирдах болон шийдвэр гаргах түвшинд буюу төрийн албанд ажиллагч эмэгтэйчүүдийн тоо 2014 онд эрэгтэйчүүдийнхээс давж гарсан. Тэд одоо удирдах албан тушаалтнуудын гуравны нэг хувийг эзэлж байна. 2014 онд бүртгэлтэй бүх компанийн захирлуудын зөвлөлийн 30% нь эмэгтэй байв.
- Хуухдийн эндэгдэл буурч, эхийн эндэгдлийг бусад хөгжингүй орнуудын түвшинд хүртэл бууруулсан. Тав хүртэлх насны хуухдийн эндэгдэл 2012 онд 1000 амьд төрөлтөд 7.7 байна. Энэ нь 1990 онд 1000 амьд төрөлтөд 18 байсан юм. Эхийн эндэгдэл суулийн 15 жилийн туршид жилд дунджаар 2.7%-иар буурч байв.
- Байгаль орчны тогтвортой байдал, байгалийн нөөцийн менежмент, ногоон эрчим хүч, биет дэд бүтцийн төлөвлөлт, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах зэрэгт амжилт гаргасан. Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн бодлогын арга хэрэгсэл гэвэл уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх бодлого, ногоон технологийн бодлого, биологийн олон янз байдлын талаарх бодлого, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих болон эрчим хүчний хэмнэлт гаргах санаачилга, ногоон байгууламж хөгжүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, ой хамгаалах, нөхөн сэргээх зэрэг олон чиглэлийг дурдаж болно. Биологийн олон янз байдлын талаарх үндэсний шинэчилсэн бодлого нь дэлхийн биологийн олон янз байдлын зорилтоос илүү өргөн хүрээг хамарч байгаа юм. Малайз улс 10 дугаар Таван жилийн төлөвлөгөөний хүрээнд байгаль орчны тогтвортой байдал, байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр дараах гол үр дүнд хүрсэн. Үүнд:
 - 2013 онд 2005 оны түвшинтэй харьцуулахад ДНБ-д ногдох хүлэмжийн хийн ялгарлын эрчим 33%-иар буурсан
 - 2010 онд өрхийн дахин хэрэглээний түвшин 5% байсан бол 2015 онд 15% болсон.
 - 2013 онд түлш хэрэглээний стандарт Евро4 болсон.
 - Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг 2011 оноос хэрэгжүүлж, сэргээгдэх эрчим хүчийг буцаан нийлүүлэх тарифын механизм бий болгосон.
 - Үерээс хамгаалах 194 төсөл хэрэгжүүлснээр нэг сая хүн үерийн эрсдэлээс хамгаалагдсан.
 - Үерийн аюултай 34 газрыг тодорхойлж, зураглал боловсруулсан.
 - 2010 онд ойн бүрхүүл 56,4% байсан бол 2014 онд 61% болж нэмэгдсэн.
 - Ойн нэгдсэн төв сангийн хүрээнд 23,260 га талбай бүхий ойг Байнгын хамгаалалттай ойн нөөцөд авсан.
 - Сабах дахь Крокерын бүс нутгийн Паркийг ЮНЕСКО-гийн Хүн ба шим мандлын дархан газарт бүртгүүлсэн.

Малайз улс хөгжлийн туслалцаа хүлээн авдаг орон байхаа больж, бусад оронтой эдийн засаг, нийгмийн салбарт мэдлэг, туршлагаа солилцдог хөгжлийн албан ёсны түнш орон болохыг зорьж байна. Тухайлбал, Засгийн газраас 1980 онд Малайзын Техникийн корпорацийн хөтөлбөрийг (ТКХ) бий болгож, Өмнөд-Өмнөдийн түншлэлийн хүрээнд бусад хөгжиж буй оронд чадавхи бэхжүүлэх туслалцаа үзүүлэв. ТКХ-ийн 79 сургалтын байгууллагын дийлэнх нь мэргэшсэн сургалтын жишиг төв бөгөөд богино хугацааны сургалтын 100 гаруй төрлийн тусгай хөтөлбөртэй. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 140 улс орны 25,000 гаруй суралцагч МТКХ-ийн төрөл бүрийн хөтөлбөрт хамрагджээ.

Малайз улсад Мянганы хөгжлийн олон зорилт амжилттай хэрэгжсэн нь сайшаалтай. Малайз улс нь олон үндэстний улс бөгөөд хүн амынх нь дунд амь бөх оршиж байсан нийгмийн тэгш бүс байдлын улмаас

ядуурлыг бууруулах, хөдөөгийн хөгжилд зориуд анхаарахаас өөр аргагүй байв. Энэ нь хөгжлийг хурдасган манлайлах улс төрийн хүчин зүйл, хөшүүрэг болж байсан бөгөөд бусад улс оронд улс төрийн ийм хүчтэй хүсэл эрмэлзэл ховор ажиглагддаг билээ.

Ийнхүү ахиц дэвшил гарч байгаа ч цаашид шийдвэрлэх шаардлагатай тогтвортой хөгжлийн асуудал олон байна. Тухайлбал, бүс нутгийн хөгжил тэнцвэргүй байгаа нь анхаарал татаж байна. Сабах, Саравакийн уугуул иргэд хөгжил цэцэглэлтийн үр шимийг хүртэж чадахгүй байна. Боловсролын стандартыг сайжруулах хэрэгтэй. Мод огтлох, нүүрсийг түлшний гол эх сурвалж болгон хэрэглэх нь хэвээр байгаа, уулын энгэрийн ой устгах зэрэг байгаль орчны асуудал тулгарсан хэвээр байна. Авлига зэрэг засаглалын зарим асуудал эдийн засагт тээг болсон хэвээр, ард иргэдээ хямд төсөр орон сууцаар хангах асуудал ч шийдэгдээгүй байна. Бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, арилгахад цаашид илүү их хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Малайз улсын далайн эрэг хавийн газрын менежментийг сайжруулж, далайн болон эрэг хавийн биологийн олон янз байдлыг хамгаалах, далайн нөөцийн тогтвортой менежментийг сайжруулах зорилт тавигдсан хэвээр байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх ажлыг 2030 он хүртэлх ТХЗ-ыг хэрэгжүүлэх ажилтай хамтруулан эрчимжүүлэхийг зорьж байна.

Хавсралт 1-д Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний хөгжлийн зорилтууд болон Тогтвортой хөгжлийн зорилгуудын (ТХЗ) ижил төстэй байдлыг үзүүлээ. 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний олон зорилт 2015 онд батлагдсан дэлхий нийтийн ТХЗ-ын 17 зорилгын утга санааг дотроо агуулсан байдаг. Мөн ТХЗ нь 2015 онд батлагдсан ч ТХЗ-ын үзэл санаа, агуулга, зорилго, үзүүлэлт нь Малайз улсын хөгжлийн төлөвлөлтөд энэ зууны эхэн үеэс тусгалаа олсоор иржээ. МХЗ-ыг хэрэгжүүлснээр Малайзын хөгжлийн төлөвлөлтөд үнэтэй ахиц нөлөө үзүүлсэн, харин ТХЗ нь тус улсын хөгжлийн төлөвлөлтийн зорилтуудтай адил төстэй гэхээс өөрөөр хөгжлийн үйл явцад шууд ямар хувь нэмэр оруулж, ямар ул мөр үлдээх вэ гэдэг нь нээлттэй байна.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО, ИНСТИТУЦ, ҮЙЛ ЯВЦ

1. Алсын хараатай сэтгэлгээ ба хөгжлийн бодлогын нөхцөл байдал


Энэ хэсэгт Малайз улс хөгжлийн төлөвлөлтөндөө баримталж буй алсын хараатай сэтгэлгээ ба түүнийг бодит үйл хэрэг болгож буй бодлогын арга хэрэгслийн талаар өгүүлнэ. Үүнд тус улсын хөгжлийн Алсын хараа, урт хугацааны бодлого, төлөвлөгөө, дунд хугацааны (таван жилийн) төлөвлөгөө зэрэг хамаарна. Мөн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох өөр нэг үндэслэл болох Засгийн газрын шинэтгэлийн хөтөлбөрийн (ЗГШХ) талаар өгүүлнэ.

Эдийн засгийг тогтвортой тууштай хөгжүүлэхэд хүчирхэг, төлөвшсөн хувийн хэвшил зайлшгүй шаардлагатай ч Малайз улс хөгжилд хүргэх зах зээлийн жам ёсны хүчинд найдаж орхиогүй. Хөгжлийг төлөвлөгөөтэй хийх идэвхтэй арга барил баримталж байна. Ядуурлыг арилгах, орлогын тэгш шударга хуваарилалт зэрэг нийгэм, эдийн засгийн асуудлыг зах зээлийн хүчинд итгэж зөнд нь орхих аваас эцэст нь шийдвэрлэх боломжгүй болох талтай.

Ийнхүү МХЗ-ыг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшил нь алсын хараатай улс төрийн манлайллын үр дүн байсан гэдэг нь төлөвлөлтөнд тогтвортой хөгжлийн зарчмыг тууштай тусган хэрэгжүүлж ирснээс ил харагддаг. 2020 он хүртэлх Алсын харааг боловсруулах үйл явц, МХЗ-ын хэрэгжилт, хөгжлийн бодлого, таван жилийн хөгжлийн төлөвлөгөөг дэмжсэн эдийн засгийн орчин ч энэхүү алсын хараатай улс төрийн манлайлал хэрэгжиж ирсний илрэл юм.

Тус улсын тусгаар тогтносон үеэс хойшхи урт, дунд хугацааны төлөвлөгөөг **Зураг 1-д** харуулав. Төлөвлөлтийн цаг хугацааны хамрах хүрээг **Шигтгээ 1-ээс** харна уу.

Зураг 1: Хөгжлийн төлөвлөлт, жилээр



Шигтгээ 1: Төлөвлөлтийн цаг хугацааны хамрах хүрээ

Урт хугацааны төлөвлөлт

- 2020 хүртэлх Алсын хараа
- Анхдугаар Хэтийн Төлөвлөгөө ба Эдийн засгийн шинэ бодлого - 1971-1990
 - Малайз улсын 2 дугаар Таван жилийн төлөвлөгөө (1971–5)
 - Малайз улсын 3 дугаар Таван жилийн төлөвлөгөө (1976–80)
 - Малайз улсын 4 дүгээр Таван жилийн төлөвлөгөө (1981–5)
 - Малайз улсын 5 дугаар Таван жилийн төлөвлөгөө (1986–90)
- 2 дугаар Хэтийн Төлөвлөгөө ба Үндэсний хөгжлийн бодлого – 1991-2000
 - Малайз улсын 6 дугаар Таван жилийн төлөвлөгөө (1991–5)
 - Малайз улсын 7 дугаар Таван жилийн төлөвлөгөө (1996–2000)
- 3 дугаар Хэтийн Төлөвлөгөө ба Үндэсний алсын хараат бодлого - 2001-2010
 - Малайз улсын 8 дугаар Таван жилийн төлөвлөгөө (2001-2005)
 - Малайз улсын 9 дүгээр Таван жилийн төлөвлөгөө (2006-2010)
- Эдийн засгийн шинэ загвар – 2010 – одоо хэрэгжиж буй
 - Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө – 2011-2015
 - Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө – 2016 -2020 болон Үндэсний хөгжлийн стратеги

Дунд хугацааны төлөвлөлт

- Таван жилийн төлөвлөгөөнүүд, 11 дүгээр 5 жилийн төлөвлөгөө (2016 -2020) гм.
- Таван жилийн төлөвлөгөөний биелэлтийн дунд хугацаанд тавих хяналт
- Засгийн газрын шинэтгэлийн хөтөлбөр
- Эдийн засгийн шинэтгэлийн хөтөлбөр

Богино хугацааны төлөвлөлт

Жилийн төсөв

Урт хугацааны төлөвлөлт: 2020 он хүртэлх Алсын хараа

1991 онд боловсруулсан 2020 он хүртэлх хөгжлийн Алсын хараа нь ёс суртахууны үнэт зүйлсээ дэмжсэн итгэл төгс Малайзыг бий болгохыг зорьсон. Малайз улс ардчилсан, хүлээцтэй буюу харилцан хүндэтгэлтэй, орлогын тэгш хуваарилалттай, эдийн засгийн хувьд хөгжсөн улс болно гэж ирээдүйгээ тодорхойлсон. 2020 он хүртэлх Алсын хараа нь эдийн засгийн хөгжил цэцэглэлт, нийгмийн сайн сайхан байдал, халамж, энэрэх сэтгэл, мөн дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролд суурилсан инновац, улс төрийн тогтвортой байдал, сэтгэл санааны тэнцвэртэй байдал зэрэг хүний амьдралын бүхий л асуудлыг хамарсан. Иймээс тус Алсын хараа нь тогтвортой хөгжлийн асуудлыг өөртөө агуулж байгаа юм. Тус Алсын хараанд 2020 он гэхэд Малайз улс хөгжингүй, чинээлэг орон болсон байна хэмээн заасан. Түүнд дараах гол зорилт буюу эрмэлзэл багтсан байна. Үүнд:

1. Малайзын нэгдмэл үндэстэн болж төлөвших
2. Сэтгэл санааны хувьд чөлөөтэй, аюулгүй, хөгжсөн Малайзын нийгмийг бий болгох
3. Боловсронгүй, төлөвшсөн ардчилсан нийгмийг дэмжин, бүтээн байгуулах
4. Ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээг бүрэн төлөвшүүлсэн нийгмийг бий болгох
5. Төлөвшсөн, либерал, хүлээцтэй буюу харилцан хүндэтгэлтэй нийгмийг бий болгох
6. Шинжлэх ухаанч, дэвшилтэт нийгмийг бий болгох
7. Бүх талын халамж анхаарал тавьдаг нийгэм байгуулах
8. Эдийн засгийн хувьд шударга нийгмийг баталгаажуулах
9. Хөгжиж цэцэглэсэн нийгмийг байгуулах гэх мэт.

2020 он хүртэлх Алсын харааны дуусгавар болох хугацаа дөхөж байгаа тул Засгийн газраас түүнийг залгамжлах тогтвортой хөгжлийн шинэ үзэл баримтлалыг төлөвлөлтөндөө тусгах ажлыг эхлээд байна. Ингээд 2016 оны 10 дугаар сард Парламентаар 2017 оны Төсвийн төслийг хэлэлцэх үед улс орныхоо 2050 он хүртэлх хөгжлийн шинэ хөтөлбөр болох **Үндэсний шинэтгэл 2050**-ийг боловсруулж байгаагаа зарласан билээ.

Үндэсний шинэтгэл 2050 төслийн шатанд байгаа тул 2030 он хүртэлх ТХЗ-ыг түүнд тусгана гэж үзэж байна. Үндэсний шинэтгэл 2050-ийг залуучууд, спортын асуудал хариуцсан сайдын тэргүүлсэн хороо боловсруулж байна. Уг ажил одоо ид өрнөж байгаа бөгөөд 2020 онд танилцуулна. Үндэсний шинэтгэл 2050-ийн төсөлд санал авах зорилгоор залуучуудын төлөөллийг Малайз улсын Ерөнхий сайдтай уулзах уулзалтыг 2017 оны 1 дүгээр сард зохион байгуулсан. Цаашид ийм олон уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Нийгэм, эдийн засгийн ерөнхий бодлого нь хөгжлийн тэргүүлэх чигийг заана

Түүнчлэн нийгэм, эдийн засгийн бодлогууд хөгжлийн төлөвлөлтийг чиглүүлсээр ирсэн. Хөгжлийн төлөвлөлт хийхдээ эдгээр бодлогыг заавал харгалзан үздэг. 1971 оны Эдийн засгийн шинэ бодлогыг (ЭЗШБ) авч үзье. 30 гаруй жилийн туршид ЭЗШБ нь үндсэн хоёр зорилгыг агуулж байсан: энэ нь ядуурлыг арилгах болон эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд арьс өнгө, яс үндэстний ялгаваргүй байхаар нийгэмд бүтцийн өөрчлөлт хийх явдал байв.

ЭЗШБ-ын хугацаа 1990 онд дуусч, түүний үндсэн зорилгыг шинээр боловсруулсан Үндэсний хөгжлийн бодлогод (1991-2000) тусгасан. Энэхүү шинэ бодлогын гол зорилго нь томоохон бүх салбар, бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх, нийгэм-эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн.

Харин Үндэсний хөгжлийн алсын хараат бодлогын (УХАБ) (2001-2010) гол зорилго нь бэрхшээлийг даван туулах, өрсөлдөх чадвартай үндэстэн байгуулахад чиглэсэн. Дараа нь, уг бодлого улс орноо өндөр орлоготой үндэстэн болгон хувиргах гол зорилго бүхий Эдийн засгийн шинэ загвар болж шинэчлэгдсэн билээ.

Хамгийн сүүлийн буюу 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөг боловсруулах явцдаа Засгийн газар Үндэсний хөгжлийн стратегийг (2016-2020) баталж, хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү стратеги нь хүмүүн капитал буюу хүний хүчин зүйлийн эдийн засаг; хөрөнгө оруулалтаар дамжуулан эдийн засгийн өсөлтийг идэвхжүүлэх буюу капиталын эдийн засаг гэсэн үндсэн хоёр зорилтыг дэвшүүлсэн.

Дунд хугацааны бодлого төлөвлөлт: Эдийн засгийн шинэ загвар

2010 онд баталсан Эдийн засгийн шинэ загвар (ЭЗШЗ) нь өндөр орлого, хэн нэгнийг орхигдуулахгүй хүртээмжтэй байх, тогтвортой байх гэсэн гурван тулгууртай. Эдгээр нь нийгэм-эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой. Мөн хөгжлийн үр шимийг бүх нийтээр ижил тэгш хүртэх нөхцөл бий болгох, хөгжлийн төлөө явахдаа ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээ шаардлагыг алдагдуулахгүй байх гэсэн агуулгатай. Ялангуяа гурав дахь тулгуур асуудал нь Малайз улсын тогтвортой хөгжлийн төлөвлөлтийн агуулга, хүрээг илүү өргөжүүлж өгсөн⁴. Үүний нэг жишээ нь 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний 5 дугаар стратеги зорилт "Тогтвортой, бэрхшээлийг даван туулах чадвартай улс орон байхын төлөө ногоон өсөлтийг дэмжих" юм. **Шигтгээ 2**-ыг үзнэ үү.

Шигтгээ 2: Стратеги тулгуур зорилт 5: Тогтвортой, бэрхшээлийг даван туулах чадвартай улс орон лс байхын төлөө ногоон өсөлтийг дэмжих (11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020, х.1-10)

Ногоон өсөлт гэдэг нь нөөцийг үр ашигтай хэрэглэдэг, цэвэр, бэрхшээлийг даван туулах чадвар бүхий өсөлт юм. Энэ нь "эхлээд өсчихөөд, дараа нь цэвэрлэе" гэсэн уламжлалт, өртөг зардал ихтэй загвараас татгалзаж, үйл ажиллагааныхаа эхнээс тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан хөгжих амлалт, эрмэлзэл юм. Ногоон өсөлтийг ийнхүү эргэж буцалтгүй, тууштай хэрэгжүүлэх амлалт авснаар Малайз улсын үзэсгэлэнт байгаль, байгалийн нөөц баялаг хамгаалагдан өнөө болон хойч үеийнхэндээ уламжлагдан үлдэх болно.

Малайз улсын Ногоон өсөлтийн стратеги нь эдийн засгийн өсөлтийн чанарыг сайжруулж, хүнс, ус, эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлж, хүрээлэн буй орчны эрсдэл, экологийн доройтлоос сэргийлж, эцсийн дүнд хүмүүсийн аж байдал, амьдралын чанарыг сайжруулахад дэмжлэг болно. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлыг мэдэгдэхүйц бууруулж, хуурай болон эх газрын усны нөөцийг хамгаалах, далай тэнгисийн эрэг хавийн болон далайн экосистемийг хамгаалахад дорвитой үүрэг гүйцэтгэнэ. Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн дадал нэвтрүүлснээр эрчим хүчний хэмнэлттэй арга техник нэмэгдэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг барилга, тээвэр, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийн менежмент, байгалийн нөөцөө хамгаалан хадгалах, түүний дотор биологийн олон янз байдлыг хамгаалах зэргээр улс орныхоо хөгжил дэвшил, түүний үр өгөөжийг хамгаалах ажиллагааг эрчимжүүлнэ.

Хөгжлийн бүхий л төлөвлөгөө, бодлого нь Эдийн засгийн шинэ загварын дээрх тулгуур зорилтод хүрэхийг зорих ёстой. Эдгээр төлөвлөгөө нь нэг хүнд ногдох үндэсний орлогыг нэмэгдүүлэн, 2020 он гэхэд 15,000 ам.долларт хүргэхийг хичээх ёстой. Хөгжлийн үр шимийг бүх нийтээр адил тэгш хүртэх ёстой. Хамгийн чухал нь байгаль орчноо хамгаалсан, хойч үеийнхээ хэрэгцээг хангахуйц байхаар хөгжлийг тогтвортой байлгах ёстой.

Эдийн засгийн шинэ загварын хүрээнд дэвшүүлсэн санаачилгууд:

- Эдийн засгийн өсөлтийг бүтээх хувийн хэвшлийг сэргээн идэвхжүүлэх
- Чанартай, чадвартай ажиллах хүчийг хөгжүүлж, гадаад ажиллах хүчинд дулдуйдах байдлыг багасгах
- Өрсөлдөх чадвартай дотоодын эдийн засгийг бий болгох
- Төрийн албыг бэхжүүлэх
- Ил тод, зах зээлийн зарчимд суурилсан зориуд дэмжих арга хэмжээ авах
- Мэдлэгийн суурь болон дэд бүтцийг бий болгох
- Өсөлтийн эх үүсвэрийг өргөжүүлэн нэмэгдүүлэх,
- Өсөлтийн тогтвортой байдлыг хангах.

⁴ 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө (2011-2016), 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө (2016-2020) аль аль нь Эдийн засгийн шинэ загварын гол тулгуур хэсгээс гол санаагаа авч хөгжүүлсэн.

Урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө, тэргүүлэх чиглэл

Хувийн хэвшил эдийн засгийн өсөлтийг хөтлөхийн хамт төрийн алба түүнийг дэмжих орчин нөхцөл бүрдүүлж, нийгэм-эдийн засгийн зорилт хангагдсан байхад анхаарна. 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд 2016-2020 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 9.4%-иар өснө гэж тооцсон.

2020 он хүртэлх Алсын хараанд заасан хөгжлийн зорилтууд нь Хэтийн төлөвлөгөө, таван жилийн хөгжлийн төлөвлөгөө, жилийн төсөвт тусгалаа олж, түүгээр дамжин хэрэгжиж байна. Үе шат бүрт тэдгээр зорилт улам нарийвчлагдан, хэрэгжих, санхүүжилт авахад бэлэн болдог.

2020 он хүртэлх Алсын харааны олон зорилтыг гурван удаагийн Хэтийн төлөвлөгөөнд тусган, залгамжлан хэрэгжүүлж ирсэн. Хэтийн төлөвлөгөө нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг бөгөөд урт хугацаандаа уг зорилгуудыг хэрэгжүүлэх ерөнхий хүрээ, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж өгдөг. Тэдгээрт Алсын хараанд заасан хүрэх түвшингээс тухайн цаг үед ноогдох түвшинг зааж өгсөн байдаг.

Хамгийн эхний буюу Анхдугаар Хэтийн төлөвлөгөө (1971-1990) нь Алсын хараанаас цаг хугацааны хувьд өмнө батлагдсан ч түүний үзэл санаа шингэсэн байдаг. Эдийн засгийн шинэ бодлого (ЭЗШБ) нь (1971-1990) уг Анхдугаар Хэтийн төлөвлөгөөг дэмжсэн бодлого байв.

20 жилийн хугацааг хамарсан Анхдугаар Хэтийн төлөвлөгөө нь даяаршлын эрин үеийн төлөвлөлтөд ач холбогдол багатай байсан байж болох юм. Иймээс дараагийн хоёр Хэтийн төлөвлөгөөг 10, 10 жилийн хугацаатай гаргасан. 2 дугаар Хэтийн төлөвлөгөө нь 2020 он хүртэлх Алсын хараанд заасан зорилгыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг тодорхойлон, нийгэм-эдийн засгийн хөгжлөөр дамжуулан, эдийн засгийг аль болох хүртээмжтэй болгох зорилт тавьсан. Мөн Эдийн засгийн шинэ бодлого (ЭЗШБ)-оос хэрэгжээгүй үлдсэн зорилтуудыг тусгасан Үндэсний хөгжлийн бодлогыг (ҮХБ) (1991-2000) шинээр боловсруулсан нь 2 дугаар Хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлогын гол хэрэгсэл болсон байна.

3 дугаар Хэтийн төлөвлөгөө нь улс орноо 2001-2010 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг байв. Уг баримт бичиг нь Үндэсний хөгжлийн бодлогыг (ҮХБ) орлож гарсан ч тэрхүү бодлогын ядуурлыг арилгах, орлогын тэгш хуваарилалт, үндэсний эв нэгдэл, улс төрийн тогтвортой байдлыг хангах зэрэг зорилгыг үргэлжлүүлэх зарчим баримталсан. Бэрхшээлийг даван түүлах, өрсөлдөх чадвартай нийгэм байгуулахыг зорихын зэрэгцээ 2020 хүртэлх Алсын харааны зорилго болох Малайз улсыг хөгжингүй орон болтол хувирган өөрчлөх зорилт тавьсан. Ядуурлыг арилгах, орлогын тэгш хуваарилалтыг бий болгохын зэрэгцээ хүний нөөцийн хөгжил, шинжлэх ухаан, технологи, судалгаа шинжилгээний ажил, дэд бүтцийн хөгжил, санхүүжилтийн асуудалд түүхүү ач холбогдол өгсөн. Мөн урт хугацааны өсөлтийг хангахын тулд байгаль орчинд ээлтэй хөгжлийг хөхиүлэн дэмжихийг эрмэлзсэн.

3 дугаар Хэтийн төлөвлөгөөний хугацаа дуусмагц 2010 оноос Эдийн засгийн шинэ загварыг (ЭЗШЗ) хэрэгжүүлж эхэлсэн. Энэ загвар нь таван жилийн хөгжлийн төлөвлөгөө, жилийн төсвийг боловсруулахад удирдамж, чиглэл болж өгсөн. Энэхүү загварын тулгуур гурван асуудал болох өндөр орлого, хэн нэгнийг орхигдуулахгүй хүртээмжтэй байх, тогтвортой байх зэрэг нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын эдийн засгийн хөгжил (өндөр орлого), нийгмийн хөгжил (хүртээмжтэй өсөлт) болон байгаль орчны хамгаалал (тогтвортой хөгжил) гэсэн асуудал харилцан уялдаатай байгаа юм.

Таван жилийн төлөвлөгөө нь Хэтийн төлөвлөгөөний өргөн хүрээг нарийвчлан, хэрэгжихэд бэлэн, санхүүжилт бүхий тодорхой төлөвлөгөө болгон хувиргадаг. 3 дугаар Хэтийн төлөвлөгөөний тогтвортой өсөлттэй холбоотой хэсгийг **Хавсралт 4**-т жишээ болгон үзүүлэв.

Хэтийн төлөвлөгөөг Таван жилийн хөгжлийн төлөвлөгөө болгон буулгах нь

Малайз улс хөгжлийн төлөвлөлтөндөө ямар их анхаарал хандуулж, нухацтай ханддагийг 5 жилийн төлөвлөгөө, жилийн төсвөө хэрхэн боловсруулж байгаагаас харж болно.

Нийт 4 удаагийн 5 жилийн төлөвлөгөөний чиглэл болж өгсөн Анхдугаар Хэтийн төлөвлөгөөнөөс бусад нь 10 жилийн хугацаатай гарсан. Тиймээс 2,3 дугаар Хэтийн төлөвлөгөө нь хүчин төгөлдөр үйлчлэх хугацаандаа тус бүр 2 удаагийн таван жилийн төлөвлөгөөний сүүр болж өгчээ.

Таван жилийн хөгжлийн төлөвлөгөө нь Хэтийн төлөвлөгөөг амьдралд хэрэгжүүлэх арга хэрэгсэл бөгөөд сүүлийн үед Эдийн засгийн шинэ загварыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл ч болж байна. Дээрх баримт бичгүүд нь хөгжлийг чиглүүлэх, МХЗ-ыг хэрэгжүүлэх гол баримт бичиг болсон билээ. Дараа дараачийн хөгжлийн төлөвлөгөө нь ТХЗ-ыг хөгжлийн төлөвлөлтөнд нэгтгэн хэрэгжүүлэх гол механизм байх юм.

Төлөвлөгөө боловсруулахдаа дараах зүйлийг хангах зорилготой ажилладаг. Үүнд:

- Улс орны дунд хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлийг тогтоох. Малайзын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд заасан стратегийн тулгуур зургаан зорилт, хүрсэн байх ёстой гол үр дүн буюу түвшин нь бодлогын тэргүүлэх чиглэлийг илэрхийлнэ.
- Эдийн засгийн өсөлт, макро эдийн засгийн үзүүлэлтийн хүрэх түвшинг тооцоолон тодорхойлох (**Шигтгээ 3**). Таван жилийн төлөвлөгөөнд тухайн төлөвлөгөөт хугацааны төгсгөлд хүрсэн байх нийгэм-эдийн засгийн үзүүлэлтийг мөн зааж өгдөг.
- Стратегийн тулгуур зорилт, хүрсэн байх ёстой үр дүнг удирдлага болгон, жил бүрийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, төсвийн хуваарилалтыг тодорхойлох. Жилийн төсөвт орсон төслүүд нь таван жилийн төлөвлөгөөний стратегийн тулгуур зорилтод хамааралгүй бол тэдгээрийг санхүүжүүлдэггүй. 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө нь стратегийн тулгуур зургаан зорилттой. Үүнд:
 - Стратегийн тулгуур зорилт 1: Тэгш шударга нийгмийг байгуулах үүднээс хэн нэгнийг орхигдуулахгүй байх.
 - Стратегийн тулгуур зорилт 2: Бүх нийтийн аж байдлыг сайжруулна.
 - Стратегийн тулгуур зорилт 3: Хүмүүн капитал буюу хүний нөөцийн хөгжлийг түргэсгэж хөгжингүй улс үндэстэн болно.
 - Стратегийн тулгуур зорилт 4: Тогтвортой, бэрхшээлийг даван туулах чадвартай улс орон байхын төлөө ногоон өсөлтийг дэмжих.
 - Стратегийн тулгуур зорилт 5: Эдийн засгаа өргөжүүлэн тэлэхэд шаардлагатай дэд бүтцийг бэхжүүлнэ.
 - Стратегийн тулгуур зорилт 6: Эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг хангах үүднээс өсөлтийг дахин инженерчлэх буюу шинэ арга барилаар хангана.
- Таван жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажил хоёр түвшинд явагдана – эхлээд 5 жилийн төлөвлөгөөний стратегийн тулгуур зорилтод үндэслэн салбарын яамдад ерөнхий төлөвлөгөө, төсвөө хэрхэн боловсруулах талаар ерөнхий чиглэл, зөвлөмж өгнө. Дараа нь, зөвхөн стратеги зорилттой нийцсэн төслүүд санхүүжилт авах тул тэдгээр тулгуур зорилтыг “шалгах хуудас” болгон ашиглана.
- Зорилтот салбаруудыг тодорхойлох. Энэ нь хувийн хэвшил хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө гаргахад чиглэл болж өгнө. 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний гол зорилтот салбар нь үйлдвэрлэл, үйлчилгээ юм.
- Хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд тулгарч болох бэрхшээлийг тодорхойлж, богино болон дунд хугацааны бодлого, арга замын шийдлийг гаргаж өгөх. Жишээлбэл, үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх жин буурч байгаа ч энэ салбар ажлын байр бий болгодог тул зорилтот салбар болдог. Гэхдээ тус салбарт өөрийн орны иргэдийг ажилд авахад асуудалтай байдгаас гадаад ажилчдыг олноор ажиллуулдаг нь нэг бэрхшээл юм. Засгийн газраас гадаад ажилчид авахад зарим хязгаарлалт тавихын хамт ажлын байрыг автоматжуулах зорилгоор зарим хөшүүрэг бий болгосон. Мөн Засгийн газраас 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний хүрээнд тус салбараас үйлдвэрлэлийг нь эрчимжүүлэх боломжтой 230 шинэ бүтээгдэхүүнийг тодорхойлсон.

Хаавсралт 2-т Малайзын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний (2016-2020) гол онцлог талыг товчлон үзүүлэв.

Шигтгээ 3: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд орсон нийгэм-эдийн засгийн зорилтуудаас

- Дотоодын эрэлт хэрэгцээ, гадаад сектороос оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсний үндсэн дээр Малайз улсын эдийн засгийг жилд дунджаар 5-6 хувиар өсгөх.
- Хувийн хэрэглээ ба хөрөнгө оруулалтаас өсөлтийг бий болгон, нэг хүнд ногдох үндэсний нийт орлогыг жилд дунджаар 7.9 хувиар өсгөх. Хувийн бодит хэрэглээг жилд дунджаар 6.4 хувиар өсгөх.
- Улсын салбарын хөгжилд зарцуулах зардлыг нэмэгдүүлснээр төсвийн хөрөнгө оруулалтыг жилд дунджаар 2.7 хувиар өсгөх.
- Хувийн хөрөнгө оруулалтыг жилд дунджаар 9.4 хувиар өсгөн, жилд дунджаар 291 тэрбум МР-д хүргэх.
- ДНБ-ний өсөлтөд олон хүчин зүйлт бүтээмжийн өсөлтөөс оруулах хувь нэмрийг 40 хувиар нэмэгдүүлснээр капиталын зардал 44 хувь, ажиллах хүчний зардлыг 16 хувиар бууруулах.
- Холбооны Засгийн газрын орлого 10 дугаар таван жилийн төлөвлөгөөнд 1.0 их наяд малайз ринггит байсан бол 11 дүгээр таван жилд 1.4 их наяд МР-д хүргэж өсгөх. Орлогыг жилд дунджаар 8 хувиар нэмэгдүүлэх бөгөөд газрын тосны орлого 2015 онд 22 хувь байсан бол 2020 он гэхэд 16 хувь хүртэл бууруулах.
- 10 дугаар таван жилийн төлөвлөгөөнд борлуулалт, үйлчилгээний татварын орлого жилд дунджаар 15.5 тэрбум МР байсан бол 11 дүгээр таван жилд түүнийг жилд дунджаар 31.4 тэрбум МР-д хүргэх.
- Үйл ажиллагааны зардал 10 дугаар таван жилд 1.0 их наяд МР байсан бол 11 дүгээр таван жилд 1.3 их наяд МР-д хүргэх. Хөгжлийн санхүүжилтийг 223.6 тэрбумаас 260 тэрбум МР хүртэл өсгөх.
- Засгийн газрын төсвийн алдагдлыг 3.2 хувиас 2020 гэхэд 0.6 хувь хүртэл бууруулах.
- Засгийн газрын нийт өрийн хэмжээ ДХБ-ний 53.3 хувь байгааг 2020 он гэхэд 43.5 хувь хүртэл бууруулах.
- Төлбөрийн тэнцлийн урсгал дансны үлдэгдэл эерэг хэвээр байх бөгөөд 2020 он гэхэд 46.5 тэрбум МР буюу Үндэсний нийт орлогын 2.6 хувьтай тэнцэхээр байх.
- 11 дүгээр таван жилд инфляцийн түвшин бага хэвээр байх ба жилд дунджаар 2.5-3 хувьтай байна.
- 2020 он гэхэд эдийн засагт бүтэн хөдөлмөр эрхлэлтээр тооцсон ажилгүйдлийн түвшинг 2.8 хувиас хэтрүүлэхгүй хадгална.
- Хөдөлмөр эрхлэлт жилд дунджаар 2.1 хувь буюу аажим өсч, 2020 он гэхэд 15 саяд хүрэх бөгөөд шинээр хоёр сая ажлын байр бий болно.
- Хөдөлмөрийн бүтээмж 2015 онд 77,100 МР байсан бол 2020 он гэхэд 92,300 МР болж нэмэгдэнэ.
- Нэг хүнд ногдох ҮНО 2020 он гэхэд 54,100 МР (15,690 ам.доллар) болж өснө.
- Өрхийн сарын дундаж орлогын хэмжээ 2014 онд 6,141 МР байсан бол 2020 онд 10,540 МР болж өснө.
- Ажиллагчдын цалингийн орлогын ДНБ-нд эзлэх хувь 2015 онд 35 хувь байсан бол 2020 он гэхэд 40 хувь болж өснө.
- Хүмүүсийн амьдралын түвшин хэрхэн сайжирч байгааг илэрхийлдэг Малайз улсын Аж байдлын индексийг жилд дунджаар 1.7 хувиар өсгөнө.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих нь

Төлөвлөгөөний биелэлтийн дунд хугацаанд тавих хяналт нь:

- Макро эдийн засгийн зорилтууд биелж буй явц, хуваарь
- Макро эдийн засгийн болон салбарын бодлого, стратегийг хамардаг.

Төлөвлөгөөний биелэлтийн дунд хугацааны хяналтыг Таван жилийн төлөвлөгөөний хоёр дахь жилийн төгсгөлд хийдэг. Тус хяналтыг хийснээр нөхцөл байдалд өөрчлөлт гарсан бол дунд хугацааны бодлогын тохируулга хийнэ. Гэхдээ газрын тосны үнийн уналтаас шалтгаалан төсвийн орлого буурах гэх мэтээр эдийн засагт гэнэтийн үзэгдэл, цочрол бий болох үед жилийн төсөвт, ялангуяа хөгжлийн санхүүжилтийг хуваарилалтад тодотгол хийнэ.

Ийм дахин хуваарилалт буюу төсвийн тодотголыг 1997-98 оны Азийн санхүүгийн хямралын үед болон 2016 оны 1 дүгээр сард хийж байсан. Уг тодотголыг засгийн газрын орлого буурч, эдийн засгийн өсөлт удааширч, газрын тосны үнэ буурсан нөхцөлд улсын хөгжлийн болон үйл ажиллагааны зардлыг бодит байдалд нийцүүлэн оновчтой болгох зорилгоор хийсэн. 2016 оны 1 дүгээр сард төсвийн тодотгол хийх болсон шалтгаан нь 2016 оны төсөв батлах үе буюу 2015 оны 10 дугаар сард газрын тосны үнэ нэг баррель

нь 48 ам.долларт хүрч байсан ч 2016 оны 1 дүгээр сард 30 ам.доллар болж буурсан явдал юм. Дэлхийн эдийн засгийн хямрал, түүхий нефтийн үнийн бууралт тус улсын үндэсний орлого 7-9 тэрбум доллараар буурахад хүргэсэн.

Иймээс төсвийн гүйцэтгэлээ 3.1%-д барихын тулд төсвийн зарим зардлаа танах шаардлагатай болсон. Улмаар Засгийн газар нэг баррель газрын тосны үнэ 30-35 ам.долларын хооронд хэлбэлзэнэ хэмээн тооцож, 2016 оны ДНБ-ний өсөлтийг 4-5% гэж тооцсон байсныг 4–4.5% болгон өөрчилсөн.

Хөгжлийн санхүүжилтийн төсвийг ийнхүү бууруулан тодотгол хийхдээ хэрэгжиж буй төслүүдийн батлагдсан дүнг өөрчлөхгүй байхад анхаарсан. Ийм таналтыг ихэвчлэн шинээр эхлэх төсөл дээр хийдэг. Засгийн газрын санхүүгийн байдал сайжирсан тохиолдолд тэргүүлэх чиглэлдээ нийцүүлэн, танагдсан төслүүдэд санхүүжилт олгох боломжтой байдаг.

Үндэсний шинэтгэлийн хөтөлбөр

Таван жилийн хөгжлийн төлөвлөгөөнөөс гадна Үндэсний шинэтгэлийн хөтөлбөрийг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хөтөлбөр нь улс орны хөгжлийн үр шимийг бүх нийтээр ижил тэгш хүртэх боломж бий болгохын тулд тогтвортой хөгжих, хэн нэгнийг орхигдуулахгүй хүртээмжтэй байх гэсэн тулгуурт суурилсан. Тус хөтөлбөр нь байгаль орчны тогтвортой байдлын талаарх зарим арга хэмжээг тусгасан Засгийн газрын шинэтгэлийн хөтөлбөр (ЗГШХ) болон Эдийн засгийн шинэтгэлийн хөтөлбөрөөс (ЭЗШХ) бүрдэж байна.⁵

Засгийн газрын шинэтгэлийн хөтөлбөрт (ЗГШХ) үндэсний хэмжээнд хүрсэн байх долоон гол үр дүнг (key result areas) заасан. Үүнд ядуурлыг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөөгийн дэд бүтцийг хөгжүүлэх, сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, авилгыг бууруулах, хотын тээвэр, амьжиргааны өртөг зэрэг юм.

Үндэсний хэмжээнд хүрсэн байх ёстой гол үр дүнг тодорхойлохдоо засгийн газраас шийдвэрлэвэл зохих ямар асуудал иргэдэд тулгарч байгааг тогтоох зорилгоор иргэд, Засгийн газрын гишүүдийн дунд явуулсан хэд хэдэн судалгааны үр дүнг харгалзан үзжээ. Иргэдэд ямар асуудал хамгийн тулгамдсан, чухал гэж байгаа талаарх судалгааг Засгийн газрын гишүүдийн дунд нэргүй, цахим хэлбэрээр явуулсан. Улмаар эдгээр судалгааны дүнг хооронд нь харьцуулан, дээрх долоон асуудал буюу хүрсэн байх ёстой үр дүнг тодорхойлсон. Ингээд үндэсний хэмжээнд хүрсэн байх ёстой гол үр дүнг (ҮГҮД) хангахын тулд ямар ажил хийж, ямар санаачилга гаргах шаардлагатайг тодорхойлох үүднээс Засгийн газрын гишүүдийн түвшинд хэд хэдэн семинар хийжээ.

Үндэсний хэмжээнд хүрсэн байх ёстой гол үр дүнг (ҮГҮД) хэрэгжүүлэх гол механизм нь байгууллага хоорондын хамтын ажиллагаа бөгөөд гол үр дүн тус бүрээр хэрэгжилтийг тэргүүлэн хариуцах нэг сайд томилогддог. Ингээд тухайн сайдын хүрсэн байх ёстой үр дүнгийн түвшинг жил, жилээр гаргах бөгөөд сайд нар сар бүр Ерөнхий сайдад хэрэгжилтийн явцаа тайлагнах үүрэг хүлээнэ. Эдгээр ажил, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг яамдын жилийн төсвөөс гаргадаг.

Харин Эдийн засгийн шинэтгэлийн хөтөлбөрийг (ЭЗШХ) улс орноо 2020 он гэхэд хөгжингүй орны статуст хүргэх зорилгоор 2010 оны 9 дүгээр сард боловсруулжээ. ЭЗШХ нь сүүлийн үед батлагдсан хөгжлийн төлөвлөгөөнүүдэд дурдсан хэрэгжүүлэх арга замыг бодит үйл хэрэг болгоход дэмжлэг үзүүлнэ. Уг хөтөлбөрийн хүрсэн байх ёстой гол үр дүн нь 444 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татах замаар нэг хүнд ногдох үндэсний нийт орлогыг (ҮНО) 15,000 ам.долларт хүргэх, ингэснээр 3.3 сая ажлын байр шинээр бий болгох явдал юм. ЭЗШХ-ийн 2020 он хүртэлх зорилтод хүрэхийн тулд үндэсний нийт орлогыг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг эдийн засгийн 12 гол чиглэлийг хөгжүүлж байна. Үүнд: газрын тос, байгалийн хий ба эрчим хүч, далдуу модны тос, резин/хаймар бүтээгдэхүүн, санхүүгийн үйлчилгээ,

⁵ http://etp.pemandu.gov.my/Invest_In_Malaysia-@-Malaysia's_Transformation.aspx. Үндэсний шинэтгэлийн хөтөлбөрийг (ҮШХ) 2050 он хүртэлх Шинэтгэлийн хөтөлбөртэй (ШХ 50) андуурч болохгүй. Энэ нь 2020 хүртэлх Алсын харааг хэрэгжүүлэх хугацаа дуусмагц залгамжлан авах бодлогын баримт бичиг юм.

бизнесийн үйлчилгээ, аялал жуулчлал, цахим техник ба цахилгаан хэрэгсэл, бөөний болон жижиглэн худалдаа, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, харилцаа холбооны контент ба дэд бүтэц, хөдөө аж ахуй, Куала Лумпур/Клангийн хөндийг хөгжүүлэх гэсэн чиглэл багтжээ.

Эдгээр салбарыг тодорхойлохдоо төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон зөвлөлдөх уулзалтаар хэлэлцэж сонгосон байна. Түүнээс гадна 2020 он гэхэд Малайз улсаа өндөр орлоготой, хөгжингүй улс болгох зорилгоо хэрхэн яаж хэрэгжүүлэхээ тодорхойлох зорилгоор төр, хувийн хэвшлийн 425 төлөөлөгч, түүний дотор 211 компанийг урьж, шийдвэр гаргахад бодитой оролцуулсан. ЭЗШХ эхэлснээс хойш иймэрхүү лаборатор зөвлөлдөх уулзалтаар дамжуулан, нэмэлт Гарааны төслүүдийг мөн тодорхойлсон.

Тэдгээр төлөөлөгч эдийн засгийн дээрх 12 гол чиглэлийг тодорхойлохын тулд 2010 оны дундуур хоёр сарын турш санаа бодлоо уралдуулах лабораторт ажилласан. Үр дүнд нь дээрх 12 гол чиглэлд хамаарах 131 Гарааны төсөл, 60 гаруй бизнесийн боломжийг тодорхойлжээ. Эдгээр төслийг гарааны гэж нэрлэдэгийн учир нь томоохон хөтөлбөрийг зөвхөн эхлүүлэх зорилготой, бүрэн циклийг хамраагүй төслүүд юм. Мөн Эдийн засгийн гол чиглэлийн өсөлтийг өдөөх зорилго бүхий өндөр үр нөлөөтэй төслүүд байдаг. Зарим нь томоохон хэмжээний дэд бүтцийн хөрөнгө оруулалт бол зарим нь малайзчуудын амьжиргаанд шууд нөлөөлөхүйц төсөл байна.

Эдгээр төслийн дийлэнхийг хувийн хэвшлийнхэн манлайлан хэрэгжүүлж байна. Эдийн засгийн шинэтгэлийн хөтөлбөрт (ЭЗШХ) Гарааны төсөл тус бүрийн гүйцэтгэх үүргийг маш тодорхой зааж өгсөн байдаг. Тухайлбал, Их Куала Лумпур/Кланг хөндийн хөтөлбөр нь есөн Гарааны төсөлтэй, тэдгээрийг хэрэгжүүлснээр тус хотыг 2020 он гэхэд эдийн засгийн идэвхтэй хөгжил бүхий, амьдрахад хамгийн таатай хотуудын нэг болох зорилт тавьсан. Тэдгээр Гарааны төслийг дурьдвал:

1. Тэргүүлэх чиглэлийн салбар дотроо дэлхийн эрчимтэй хөгжиж буй топ 100 компаний сонирхлыг өөрийн орон руу татах,
2. Дотоод, гадаадын авъяас чадварыг зохистой хослуулах,
3. Сингапуртай өндөр хурдны төмөр замын сүлжээгээр холбогдох,
4. Хотын нийтээр түргэн зорчих систем бий болгох,
5. Кланг голын сав газрыг Их Куала Лумпур/Клангийн хөндийн соёлын өв, худалдааны төв болгон сэргээн хөгжүүлэх
6. Их Куала Лумпур/Клангийн хөндийг ногоон бүс болгон, иргэн бүрт хангалттай хүрэлцэхүйц ногоон орчин бүрдүүлэх,
7. Хүмүүсийн очих дуртай, үзэх юмтай газрууд бий болгох, явган хүний замын цогц сүлжээ бий болгох
8. Хатуу хог хаягдлыг үр ашигтай удирдах экосистем хөгжүүлэх зэрэг болно.

ЭЗШХ эхлэх үед Гарааны төслүүд жилд дунджаар 500 тэрбум МР-ийн (малайз рингит) орлого бий болгож, 2020 он гэхэд 2.2 сая ажлын байр шинээр бий болно гэж тооцож байв. Нийт санхүүжилтийн 92% нь хувийн хэвшлээс гарна. Эдийн засгийн гол чиглэл тус бүрийн Гарааны төслүүд нь эдийн засагт цаашдаа нэмүү өртгийн гинж үүсгэх зорилго бүхий өсөлтийн шинэ талбар, бизнесийн шинэ боломжийг агуулж байдаг.

ЭЗШХ-ийн агуулгыг гаргахад чухал ач холбогдолтой байсан лабораторын аргын янз бүрийн хувилбарыг одоо төрийн албаныхан ард иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд тулгарч буй бэрхшээлийг хамтран шийдвэрлэх зорилгоор холбогдох талуудтай чин үнэнээсээ ярилцаж, хэлэлцэхэд ашиглаж байна.

Түүнчлэн ЭЗШХ нь шинэчлэлийн зургаан санаачилгаар дамжуулан, Малайзын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэж байна. Шинэчлэлийн санаачилга гэдэг нь Малайзын компаниудын дэлхийд өрсөлдөх чадвартай болгохын тулд худалдааны орчинг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого юм. Үүнд төрийн санхүүгийн системийн шинэчлэл; төрийн үйлчилгээний хүргэлт; өрсөлдөөн, стандарт болон либералчлал; тэгш бус байдлыг багасгах; бизнесийн болон хүмүүн капиталын хөгжилд төрөөс гүйцэтгэх үүрэг гэсэн 6 санаачилга багтсан.

Эдгээрийг ихэвчлэн хувийн хэвшил санхүүжүүлж байна. Засгийн газрын үүрэг нь хурдасгах, өдөөх зорилго бүхий зарим хөтөлбөр, санаачлагыг санхүүжүүлэх; уг ажлыг хэрэгжүүлэхэд бодлогын орчин нь ээлтэй

байх; нийтлэг зорилгодоо хүрэхэд хөрөнгө хүчээ чиглүүлэхийг хувийн хэвшилд уриалж, дэмжих зэргээр хязгаарлагдана.

2010 онд ЭЗШХ-ийг хэрэгжүүлж эхэлснээс хойш нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (ҮНО) 42.5%-иар буюу 2009 онд 7,059 ам.доллар байсан бол 2014 онд 10,426 ам.доллар болж өссөн. Хувийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2007-2010 онд 4.7% байсан бол 2010-2014 онд 15.3% болж, жилийн дундаж өсөлт гурав дахин нэмэгдсэн. Зөвхөн 2014 онд хувийн хөрөнгө оруулалт 228 тэрбум МР болж, тавьсан зорилтоо 8.6%-иар (148.4 тэрбум МР) давуулан биелүүлжээ. Үндэсний эдийн засгийн гол чиглэл, салбарууд 2010-2014 онд нийт 1.5 сая өндөр үнэлэмжтэй ажлын байр шинээр бий болгосон. Эдийн засгийн гол чиглэлд багтсан үйлчилгээний салбарууд болох санхүүгийн үйлчилгээ, бөөний болон жижиглэн худалдаа, аялал жуулчлал, бизнесийн үйлчилгээ, боловсрол, харилцаа холбооны контент ба дэд бүтэц гэсэн чиглэл тэргүүлж буй үйлчилгээний салбар нь 2014 онд ДНБ-ий 55%-ийг бүрдүүлэн, 2020 он гэхэд хүрсэн байх ёстой ЭЗШХ-ийн зорилтот түвшин болох 65%-д тун дөхөж очоод байна.

Хувийн хэрэглээ 2010 онд 6.9% байсан бол хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл эрүүлжиж, орлого тогтвортой өссөнөөр 2013 онд 7.6% болж өссөн. Ингэснээр хувийн хэрэглээ ДНБ-ий 51%-тай тэнцэх болсноор 2020 он гэхэд ДНБ-ий 60%-тай тэнцэнэ гэсэн зорилтот түвшин бодитой хэрэгжих боломжтой болоод байна.

Төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлийн хяналтын газар (ТБГХГ-PEMANDU) нь хувийн хэвшил болон түүнд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудын тайланг тогтмол хүлээн авах замаар төслүүдийн хэрэгжилтийн явцыг байнга хянаж байдаг. Ингэснээр ТБГХГ нь ЭЗШХ-ийн зорилт, хүрсэн байх ёстой зорилтот түвшинтэй харьцуулахад юу хийгдээд байгааг мэдэж байдаг.

Стратеги шинэчлэлийн санаачилгад дурдагдаагүй ч Малайз улсын Засгийн газар хөгжлийн ерөнхий зорилго, газрын тос, байгалийн хий, эрчим хүч зэрэг үндэсний Эдийн засгийн гол салбарыг хөгжүүлэх хүрээнд цөмийн болон нарны эрчим хүч, усан цахилгаан станц зэрэг эрчим хүчний бусад эх үүсвэр ашиглахыг дэмжин, эрчим хүчний эх үүсвэрийг олшруулах төлөвлөгөөтэй байна.

2. Төлөвлөлтийн тогтолцоо

Тогтвортой хөгжлийн зорилгуудыг (ТХЗ) таван жилийн төлөвлөгөө болгон хувиргахад төлөвлөлтийн маш нарийн, өргөн хүрээтэй тогтолцоо шаардлагатай. Энэ хэсэгт таван жилийн төлөвлөгөө, жилийн төсвийг боловсруулахад ямар байгууллага, ямар үүрэгтэй оролцдогийг авч үзнэ. Ингэхдээ төлөвлөлтийн тогтолцооны дээрээс доош болон доороос дээш чиглэсэн урсгал, үйл явцыг тодотгон харуулна.

Таван жилийн төлөвлөгөөг хөгжлийн төлөвлөлтийн журмын дагуу боловсруулдаг бол жилийн төсөвлөлтийн тогтолцоо нь тухайн жилийн хөгжлийн үр дүн (таван жилийн төлөвлөгөөг жил жилээр задлан нарийвчилсан), үйл ажиллагааны төсөв, зардлыг тодорхойлно. Малайз улс 1960-аад оноос хойш хөгжлийн болон үйл ажиллагааны төсөв гэсэн давхар төсөвлөлтийн журам баримталж ирсэн. Хөгжингүй орнуудаас ялгаатай нь Малайз улс хөрөнгийн буюу хөрөнгө оруулалтын төсөв ба үйл ажиллагааны төсвийг тус тусад нь хийдэг. Энэ нь хөгжлийн зардал, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг онцлон харуулах зорилготой юм.

1966 оны Хөгжлийн сангийн тухай хуулиар Засгийн газарт зээл авах боломж олгосон. Гэхдээ энэ зээлийг зөвхөн хөгжлийн зардлыг санхүүжүүлэхэд л ашиглаж болно.

Хөгжлийн төлөвлөлтийн гол хөдөлгөгч хүч нь Ерөнхий сайдын албаны дэргэдэх Эдийн засгийн төлөвлөлтийн газар (ЭЗТГ), харин жилийн үйл ажиллагааны төсвийг хариуцсан гол байгууллага нь Сангийн яам. Гэхдээ таван жилийн төлөвлөгөө, тухайн жилийн хөгжлийн төсвийг боловсруулахад хоёр байгууллага аль аль нь идэвхтэй оролцдог.

Ерөнхийдөө төлөвлөлтийн тогтолцоо нь 30 гаруй жилийн туршид тогтвортой байсан.⁶ Энэхүү үйл явц нь сүүлийн үед улам бүр автоматчилагдаж байна. Яамд, агентлаг, төрийн байгууллагуудаас таван жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн санал, гүйцэтгэлээ цахим хэлбэрээр илгээхийг шаарддаг.

Өмнө дурдсанчлан, хөгжлийн бодлого нь Эдийн засгийн шинэ хөтөлбөрөөс (ЭЗШХ) өнөөгийн Үндэсний шинэтгэлийн бодлого болон хувиран залгамжлагдаж байна.

Төлөвлөлтийн тус тогтолцоо ийнхүү тогтвортой удаан үргэлжилж чадсан нь таван жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явц маш нарийн, чамбай, бат бөх үндэслэлтэй хийгдэж ирснийг гэрчлэн харуулж байгаа юм. Төлөвлөлтийн тус тогтолцоог ийнхүү нарийн, чамбай гэж үздэгийн учир нь төлөвлөгөө боловсруулах бүхий л үйл явцад Сангийн яам, Эдийн засгийн төлөвлөлтийн газар (ЭЗТГ), Төрийн үйлчилгээний алба, Төв банк, Статистикийн газар зэрэг төрийн төв байгууллага, орон нутгийн захиргаа, хувийн хэвшлийнхэн идэвхтэй оролцдогтой холбоотой. Төлөвлөгөө боловсруулахад ийнхүү хамтран оролцоноороо яам, агентлаг, орон нутгийн захиргаа уг төлөвлөгөөг өөрийн юм гэж үзэж, эзний ёсоор хэрэгжүүлэх нөхцөл бүрддэг.

Оролцоог ингэж хангахын тулд төлөвлөлтийн үйл явцыг Эдийн засгийн төлөвлөлтийн газар (ЭЗТГ) сайтар уялдуулж, зохион байгуулж өгдөг. ЭЗТГ нь холбооны, мужийн болон орон нутгийн гэсэн засгийн газрын бүх түвшинд буй төлөвлөлтийн туршлага, мэдлэгийг дайчлан ашигладаг. Мөн төр, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн байгууллага хоорондын төлөвлөлтийн хэсэг бүлгүүд нь таван жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцон, чадвар, туршлагаа нэмэрлэдэг.

Хамгийн чухал нь тус төлөвлөгөөг Парламент хэлэлцэж, тогтоол баталдаг. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд төлөвлөгөө боловсруулахад мөн оролцоно. Засгийн газрын ерөнхий нарийн бичгийн дарга нь төрийн албаны ерөнхий захирагч болохын хувьд Хөгжлийн төлөвлөлтийн үндэсний хороо гэдэг өндөр түвшний хороог удирддаг. Уг хороо нь таван жилийн төлөвлөгөөний төслийг хянаж Ерөнхий сайд, кабинетэд зөвлөмжөө хүргүүлдэг. Түүнчлэн Ерөнхий сайд эдийн засгийн гол салбар хариуцсан сайд нараас бүрдсэн Сайд нарын зөвлөлийг удирдан, төлөвлөлтийн баримт бичгүүдийг хянаж үзнэ. Ерөнхий сайд мөн хөгжлийн бодлого, төслийн хэрэгжилтийг хянах үүрэг бүхий өндөр түвшний уялдаа зохицуулалтын хороог удирддаг.

Төлөвлөлтийн тус тогтолцоо нь мөн батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилт явагдаж байгаа эсэхэд тогтмол, маш нарийн хяналт тавьж, үнэлгээ хийж байдаг, үүнд биет болон санхүүгийн гүйцэтгэл, мөн хүрсэн үр дүн, түвшинг хянан. Ерөнхий сайдын албаны дэргэхэд Хэрэгжилт зохицуулах газар (ХЗГ) нь энэ ажлыг хийнэ. Яам, агентлагууд таван жилийн төлөвлөгөөнд орсон төсөл бүрийн сарын явцын тайланг цахим хэлбэрээр тогтмол тайлагнах үүрэгтэй.

Ингээд бүхэлд нь аваад үзвэл, төлөвлөлтийн үйл явц нь өөрөө бодлогын уялдаа холбоог хангаж байдаг. Далайцтай, нарийн чамбай төлөвлөх явцад бодлогын тэргүүлэх чиглэл улам хурц тодорхой болж, иргэдэд ямар хэрэгцээ байгаа тухай ойлголт сайжирж, гүнзгийрдэг. Ингэснээр засгийн газраас иргэдийн хэрэгцээг хангахад хөгжлийн арга хэмжээгээ чиглүүлэх, заасан үр дүнд төлөвлөсний дагуу хүрэх чадавх сайжирсан. Төлөвлөлтийн дээрээс доош болон доороос чиглэсэн урсгал нь дээд түвшний стратеги сэтгэлгээ болон яам, агентлаг, мужын захиргаадын зардлын хэрэгцээг үүлзүүлж, нэгтгэж өгдөг. Төслийн гүйцэтгэлийн явцын хяналт, шалгалтыг ч уялдаа, зохицуулалттай хийдэг.

3. Төлөвлөлтийн үйл явц ба холбогдох байгууллага

Энэ хэсэгт таван жилийн төлөвлөгөөний төлөвлөлт болон жилийн хөгжлийн төсвийн төлөвлөгөө зэрэг богино хугацааны төлөвлөлтийн талаар өгүүлнэ. Түүнчлэн төв болон чиг үүргийн яам, агентлагууд, мужийн захиргаадын гүйцэтгэх үүргийн талаар авч үзнэ. Төлөвлөлт нь дээрээс доош чиглэсэн макро

⁶ Үз. Мажид Хусейн болон Ж.А Завиер (1992). Малайз улсын туршлага АНДЭЗНХА-НҮБХХ (1992). Засгийн газрын зардлын хяналт, менежмент: Азийн орнуудын туршлага, сорилт. Хөгжлийн асуудлаарх товхимол № 13, х.247-287.

төлөвлөлт, доороос дээш чиглэсэн яам, агентлаг, мужийн захиргааны түвшинд хийгддэг микро буюу богино хугацааны төлөвлөлтөөс бүрддэг.

Дээрээс доош чиглэсэн макро төлөвлөлт


Дунд хугацааны төлөвлөлтөөр таван жилийн төлөвлөгөөг боловсруулдаг, энэ нь цаашдаа төрийн байгууллагуудад хоёр жилээр эргэлдэх төлөвлөгөө (rolling) боловсруулах дээрээс доош чиглэсэн заавар чиглэл болж өгдөг. Үүнд тухайн төлөвлөгөөт хугацаанд хамаарах стратеги тулгуур, хэрэгжүүлэх арга зам ба хүрсэн байх ёстой үр дүн, макро эдийн засгийн хангах ёстой үзүүлэлтүүд, зардлын дээд хязгаар зэргийг тодорхойлох ажил багтана.

Зураг 2-т үзүүлсэнчлэн, ТХЗ-ыг үндэсний хөгжлийн төлөвлөлтөнд нэгтгэн тусгах асуудлыг хариусан байгууллага нь Эдийн засгийн төлөвлөлтийн газар (ЭЗТГ) юм. Ерөнхий сайдын албаны дэргэд байршдаг тул ЭЗТГ-ын улс орны хөгжлийн төлөвлөлтийг удирдан чиглүүлэх эрх мэдэл нь өндөр.

Төлөвлөлт нь интерактив буюу байнга эргэж харилцан, засвар өөрчлөлт оруулах замаар хийгддэг. ЭЗТГ нь дээд түвшинд кабинеттэй, доод түвшинд яам, мужийн болон орон нутгийн захиргаадтай харьцдаг.

Төлөвлөлтийн тогтолцооны дээд хэсэгт ЭЗТГ, Сангийн яам, Төв банк, Статистикийн төв газар ажиллана. Макро төлөвлөлт нь төлөвлөлтийн заасан хугацаанаас 2 жилийн өмнө эхэлдэг. Эдгээр байгууллага хамтран таван жилийн төлөвлөгөөний макро-эдийн засгийн хүрсэн байх ёстой үзүүлэлтүүдийг тогтооно.

Зураг 2: Дээрээс доош буюу макро төлөвлөлтийн үйл явц



Сангийн яамнаас засгийн газрын орлогын нөхцөл байдал, тухайн дэвшүүлж буй төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн боломжийн талаарх саналаа бэлтгэнэ. Тэдгээр прогноз буюу ирээдүйн таамаг тооцоолол нь газрын тосны орлого, хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын татвар, гаалийн болон онцгой татвар,

бусад татвар (үүнд 2015 оноос ноогдуулж эхэлсэн бараа, үйлчилгээний татвар гэх мэт), замын татвар, лиценз, тусгай зөвшөөрөл гэх мэт орлогын бусад эх үүсвэрт үндэслэн хийгдэнэ. Ийм тооцооллыг төлөвлөгөөт хугацааг бүхэлд нь хамруулан хийх бөгөөд холбогдох бодлого, түүхий эдийн болон газрын тосны үнэд гарч болзошгүй хэлбэлзэл зэргийг харгалзана.

Төв банк нь төлөвлөгөөт хугацааны түршид Малайз улсын өсөлтөд нөлөөлж болзошгүй дэлхийн чиг хандлагыг тооцоолдог бол Статистикийн газар нь тухайн төлөвлөгөөнд шаардагдах бүхий л тоо мэдээллээр хангана.

Макро эдийн засгийн өсөлтийн зорилтот түвшинг эдийн засгийн өсөлтийн хувь, нэг хүнд ногдох орлого, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хөрөнгө оруулалт ба хэрэглээний харьцаа, төлбөрийн тэнцэл, инфляци зэргийг хамруулан тодорхойлно. Мөн одоо хэрэгжиж буй төлөвлөгөөний дунд хугацааны үнэлгээ, ялангуяа төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тулгарч буй бэрхшээл зэргийг харгалзан үзэж байж дээрх үзүүлэлтүүдээр хүрэх зорилтот түвшинг гаргана. Түүнчлэн дотоодын болон дэлхийн эдийн засгийн одоогийн нөхцөл байдал ба ирээдүйн төлвийг үнэлж харгалзан үзнэ.

Улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэл нь дээр дурдсан зорилтот түвшинг тодорхойлоход мөн хэрэг болно. Хөгжлийн тэргүүлэх чиглэл нь улс төрийн манлайлал эрмэлзлэл, үндэсний бодлого, хөгжлийн сүүлийн үеийн төлөвлөгөө зэргээс урган гардаг.

Дараа нь, дээрх байгууллагууд эдийн засгийн өсөлтийн зорилтот түвшин нь улсын секторын хөгжлийн төсөв, зардалд ямар нөлөө үзүүлэхийг үнэлнэ.

Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах удирдамж

Дараа нь, таван жилийн төлөвлөгөө бэлтгэх удирдамжийг яам, агентлаг, мужийн захиргаадад хүргүүлдэг. Малайз улсын 10 дугаар таван жилийн төлөвлөгөөг (2011-2015) боловсруулж эхэлснээс хойш тус удирдамжид төлөвлөлтийн хүрээг мөн зааж өгдөг болжээ. Ийм хүрээ нь яам, агентлаг, мужийн төсвийн төслийг үндэсний стратеги зорилт, чиглэл, салбар, хүрсэн байх ёстой гол үр дүн, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, гүйцэтгэлийн санаачилгуудтай уялдуулах боломж олгоно (**Зураг 2**).

Малайз улсын 10 дугаар таван жилийн төлөвлөгөөнөөс өмнө, тухайн таван жилийн төлөвлөгөөт хугацаа эхлэхээс 2 жилийн өмнө удирдамж гарган, яам, агентлаг, мужийн захиргаадаас нийт төлөвлөгөөт хугацааг хамарсан төсвийн саналаа ирүүлэхийг хүсдэг байсан. Дараа нь, жилийн төсөв боловсруулах ажлын хүрээнд уг таван жилийн төлөвлөгөөг жилийн төсөвт хуваадаг байв. Харин 10 дугаар таван жилийн төлөвлөгөөнөөс хойшхи удирдамжид зааснаар яам, агентлаг, мужийн захиргаад төлөвлөгөөт хугацааг бүхэлд нь хамарсан нийт төслийн төсвийг хоёр жилээр (rolling) тооцож ирүүлдэг болсон. Ерөнхийдөө, тус Удирдамж нь гурван үндсэн зорилготой. Үүнд:

1. Шинээр хэрэгжиж эхлэх гэж буй төлөвлөгөөнд Засгийн газраас дэвшүүлсэн стратеги тулгуур, хэрэгжүүлэх арга замын талаар байгууллагуудад мэдээлэл өгөх,
2. Үндэсний хөгжлийн стратеги зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ирэх таван жилийн төлөвлөгөөний эхний хоёр жилд шаардагдах хөгжлийн төсвийн саналаа тооцож ирүүлэхийг хүсэх, яамдын санал нь стратеги тулгуур, салбарын стратегид хамаарсан, түүнд багтсан байх ёстой.
3. Яам, агентлагийн төсвийн төслийг боловсруулах ажлыг ерөнхий журам, удирдамжаар хангах. Төсвийн санал боловсруулахад 6 сарын хугацаа өгдөг.

Хөгжлийн төлөвлөлтийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг

Макро болон салбарын зорилтот түвшинг эцсийн байдлаар тохирохын тулд Байгууллага хоорондын төлөвлөлтийн хэсгүүд (БХТХ), тэдгээрийн Мэргэжлийн ажлын хэсгүүд (МАХ) болон фокус бүлгүүдтэй хэлэлцэж зөвшилцдөг. БХТХ-ийн боловсруулсан ажлыг МАХ-үүд гүнзгийрүүлэн, мэргэжлийн түвшинд хянаж үздэг бол фокус бүлгийн хэлэлцүүлгээр төлөвлөгөөнд тусгах стратеги, асуудлыг хэлэлцдэг. Улмаар

фокус бүлгээс гарсан саналуудыг холбогдох МАХ-д хүргүүлээд, зохих өөрчлөлт хийсний дараа БХТХ-үүдэд өгнө.

Байгууллага хоорондын төлөвлөлтийн хэсэг (БХТХ), Мэргэжлийн ажлын хэсэг (МАХ), фокус бүлгийн хэлэлцүүлэг зэрэг нь таван жилийн төлөвлөгөөг боловсруулах явцад хийгддэг зөвлөлдөх үйл явцын нэг хэсэг юм. Тэдгээрт гол төлөв холбогдох яамд, агентлаг, Төв банк, мужийн захиргаад, хувийн хэвшлийнхэн, мөн БХТХ-үүдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар ажилладаг ТББ-ын төлөөлөл ордог.

БХТХ-үүд Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн зөвлөлийн (ҮХТЗ) удирдлага дор ажиллах бөгөөд тэдгээр хэсгийн нарийн бичгийн албаны үүргийг Эдийн засгийн төлөвлөлтийн газар (ЭЗТГ) нь гүйцэтгэнэ. Малайзын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөг (2016-2020) боловсруулах явцад стратегийн зургаан тулгуур зорилтын хүрээнд тусгайлан байгуулсан 54 БХТХ ба МАХ, 140 фокус бүлэг (шаардлагатай тохиолдолд зохион байгуулж байсан) ажиллажээ. Стратеги тулгуур зорилтыг Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн зөвлөлийн зөвлөмжийн дагуу Кабинет шийднэ. ЭЗТГ мөн тэдгээр бүлэг, хэсгүүдийн нарийн бичгийн албаны үүргийг гүйцэтгэж байв (**Хавсралт 3**-аас эдгээр хэсгийн жагсаалт, хариуцсан ажлын хүрээг үзнэ үү)

БХТХ ерөнхийдөө дараах ажил үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Шинэ төлөвлөгөө боловсруулахдаа одоо байгаа ажлын гүйцэтгэлээс ямар сургамж авах ёстойг тодорхойлох,
2. Дэлхий нийтийн жишиг, туршлага дээр үндэслэн, илүү хүртээмжтэй өсөлт, тогтвортой хөгжил, мөн 5 жилийн төлөвлөгөөний зорилтот түвшин, хүрэх ёстой үр дүнг биелүүлэхэд шаардлагатай дунд, урт хугацааны стратегиуд, бодлого, хөтөлбөрийг тодорхойлж, ач холбогдлоор эрэмбэлэх. Хөтөлбөр, стратегид давхардал, өөр хоорондын зөрчил гарахгүй байхын тулд баримтлах бодлогыг тодорхойлох.
3. Олон улсын нөхцөл байдал, хөрөнгө нөөцийн бололцоо, хэрэгжилтэнд гарч болзошгүй саад бэрхшээл зэрэгтэй холбоотой авах арга хэмжээ, мэдээллийг судлан үнэлэх. Таван жилийн төлөвлөгөөний стратегийн 6 тулгуур зорилт бүрээр авах арга хэмжээг Мэргэжлийн ажлын хэсэг боловсруулж, БХТХ-үүдэд танилцуулж хэлэлцүүлэх.
4. Бодлого, стратеги, хөтөлбөрийн талаар зөвлөмж боловсруулж Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн зөвлөлд танилцуулах.

Харин Мэргэжлийн ажлын хэсгүүд (МАХ) дараах ажил үүрэг гүйцэтгэнэ:

1. БХТХ, дэд хэсгүүд тус тусын ажил үүргийн хүрээнд хамаарах одоо хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг судлан шинжлэх, одоо мөрдөгдөж буй төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад тулгарсан асуудал, бэрхшээлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх;
2. Уг дүн шинжилгээндээ үндэслэн баримтлах стратеги буюу арга замыг заасан баримт бичгийн төсөл боловсруулж, холбогдох БХТХ-т танилцуулж хэлэлцүүлэх,
3. Стратеги буюу арга замыг заасан баримт бичиг боловсруулахад зориулан холбогдох фокус бүлгүүдээс санал, мэдээлэл авах ажлыг зохион байгуулах.

Тухайн сэдэвт хамаарах хөгжлийн зорилгын эрэмбийн талаар санал авах зорилгоор эрдэмтэд, хувийн хэвшил, ТББ, иргэний нийгэмтэй тогтмол зөвлөлдөх явцад гарсан мэдээллийг нэгтгэх үүрэг бүхий Фокус бүлгүүдийн ярилцлага зохион байгуулагддаг (11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө бэлтгэх явцад нийт 140 тийм бүлэг ажилласан).⁷

Үүний зэрэгцээ, ЭЗТГ нь стратегийн тулгуур зорилт бүрээр 1-2 өдрийн семинар зохион байгуулж байсан. Яамд, холбогдох хувийн хэвшлийнхэн, ТББ-уудын төлөөлөл түүнд идэвхтэй оролцож иржээ.

⁷ Малайз улсын 8 дугаар 5 жилийн (2001-2005) төлөвлөгөөг бэлтгэх явцад дараах асуудлаар нийт 25 БХТХ байгуулагдан ажилласан: макро-эдийн засаг, хүний нөөц, ядуурлыг арилгах, аж үйлдвэрийн хөгжил, шинжлэх ухаан, технологи, тээвэр, ахуйн үйлчилгээ, нийгмийн хөгжил гэх мэт.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн Банк, ОУВС зэрэг олон улсын байгууллагаас ч мөн төлөвлөгөөний төсөлд санал авч байв. БХТХ, МАХ, фокус бүлгүүд болон хэлэлцүүлэг зөвлөгөөн нь хөгжлийн төлөвлөлтийн тогтолцооны институтлагдсан бүрдэл хэсэг юм. Ийм механизмыг хөгжлийн төлөвлөгөө боловсруулах бүртээ ашиглаж хэвшсэн, ялангуяа сүүлийн таван удаагийн төлөвлөлтийн явцад чанд баримталсан. Энэ нь төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх арга замын талаар олон нийт, хувийн хэвшил, иргэний нийгмийн санал, зөвлөгөөг авах талбар болж өгдөг. Мөн засгийн газрын бодлого, дэлхийн зах зээл, дотоодын эдийн засгийн эрүүл нөхцөл байдал, нийгмийн янз бүрийн бүлэгт үзүүлэх бодлого, хөтөлбөрийн үр нөлөө зэрэг олон асуудлаар байр суурь, санал зөвлөгөөг сонсох боломж олгодог. Ингэж зөвлөлддөгийн ачаар уг төлөвлөлт хүндээ чиглэсэн, хүн төвтэй болж өгдөг.

Доороос дээш буюу дунд хугацааны төлөвлөлт

БХТХ, МАХ, Фокус бүлгүүдээс гадна ЭЗТГ нь яам, агентлаг, мужийн захиргаагаас төлөвлөгөөт хугацааны туршид хэрэгжүүлэх төслийн ерөнхий саналыг хүлээж авдаг. Эдгээр төслийн саналд дараах зүйлийг хамруулсан байх шаардлагатай. Үүнд:

- Одоо хэрэгжиж буй төлөвлөгөөнд орсон, цаашид үргэлжлэх төслүүд,
- Шинэ төслүүд
- Төлөвлөгөөт хугацааны туршид шаардагдах зардлын тооцоо
- Хөгжлийн төлөвлөлтөд болон төслийг газар дээр нь хэрэгжүүлэхэд тулгарч болзошгүй асуудал, бэрхшээл,

ЭЗТГ нь төсвийн төслүүд, тэдгээрийн зардлын тооцоог нэгтгэнэ. Бүх байгууллагаас ирсэн мэдээллийг нэгтгэснээр макро эдийн засгийн үзүүлэлтийн хүрэх ёстой түвшин, таван жилийн төлөвлөгөөний зардлын дээд хязгаарт зохих нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл болно.

Ингээд БХТХ-үүдтэй зөвшилцсөний дараа Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн зөвлөлд (ҮХТЗ) дараах асуудлыг танилцуулж хэлэлцүүлнэ:

- Хөгжлийн тулгуур зорилтууд, стратегиуд, хүрэх ёстой үр дүн
- Төлөвлөгөөнд тусгах макро-эдийн засгийн үзүүлэлтүүдийн хүрэх ёстой түвшин
- Санал болгож буй хөтөлбөр, төслүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам

Засгийн газрын ерөнхий нарийн бичгийн дарга нь мөн кабинетын нарийн бичгийн даргаар ажилладаг бөгөөд тэрээр ҮХТЗ-ийг удирддаг. Уг зөвлөлд эдийн засгийн гол яамдын нарийн бичгийн дарга нар орно. Үүнд сангийн яам, гадаад худалдаа ба аж үйлдвэрийн яам, дотоод худалдаа ба хэрэглэгчдийн асуудал, тээвэр, боловсрол, хөдөөгийн хөгжил, ажил үйлчилгээ, байгалийн нөөц ба байгаль орчин, эрчим хүч, бараа бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн яам зэрэг багтана. Түүнчлэн уг зөвлөлд ЭЗТГ, Хэрэгжилт зохицуулалтын газар (ХЗГ), Төр хувийн хэвшлийн түншлэлийн газар, Төр, төрийн үйлчилгээний газар зэрэг байгууллагын төлөөлөл, дээр нь Төв банкны захирагч ордог.

ҮХТЗ бол төрийн бодлого, үндэсний хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, уялдааг хангах үүрэг бүхий удирдах дээд байгууллага юм. ҮХТЗ нь хөрөнгө нөөц хуваарилах асуудлаар зөвлөмж гаргах үүрэгтэй. Түүнчлэн үндэсний хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина.

ҮХТЗ төлөвлөгөөний төслийг зөвшөөрсний дараа Ерөнхий сайд, түүний удирддаг эдийн засгийн гол яамдын сайд нараас бүрдсэн Тусгай хороо нарийвчлан хянаад, Ерөнхий сайдын тэргүүлдэг кабинетын бүрэн бүрэлдхүүнд хүргүүлнэ. Төлөвлөгөөний төслийг кабинет дэмжсэний дараа Парламент хэлэлцэж батална. Парламент бол үндэсний хөгжлийн төлөвлөлтийн шийдвэр гаргах хамгийн дээд байгууллага юм. Төлөвлөгөөг Парламент тогтоолоор батална.

Хөгжлийн төлөвлөлтийн энэхүү нягт чамбай, шат дараатай шалган хянах үйл явц нь уг бодлого, стратегид иргэдийн хэрэгцээ шаардлагыг оновчтой, бодитой тусгасан байх, нийт бүс нутагт тогтвортой хөгжлийн үзэл санаан дор тэнцвэртэй хөгжих баталгаа болдог ажээ.

Доороос дээш чиглэсэн богино хугацааны төлөвлөлт: хоёр жилийн төлөвлөгөө, жилийн хөгжлийн төсөв

Малайзын 10 дугаар таван жилийн төлөвлөгөөнөөс (2011-2016) хойш яамдад төлөвлөгөөг хоёр жилээр боловсруулах шаардлага тавьдаг болсон. Энэ нь төлөвлөгөөнд санхүүжилтийн боломж, үндэсний тэргүүлэх чиглэлийг харгалзан хөтөлбөр, төслүүдээ ач холбогдлын эрэмбийг дахин авч үзэх боломж олгодог. Энэ тогтолцоо 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд (2016-2020) хэвээр үргэлжилж байна.

Тухайлбал, Таван жилийн төлөвлөгөөний эхний хоёр жил буюу 2016, 2017 оны нарийвчилсан төсөв нь үр төлөвлөгөөнд заасан стратегийн 6 тулгуур зорилт, голлон анхаарах чиглэл, арга зам, хүрэх ёстой гол үр дүнд хүрэхэд шууд чиглэсэн байх ёстой. Яам, мужийн захиргаад өмнөх төлөвлөгөөний биелэлт, мөн төлөвлөгөө боловсруулах Удирдамжид захирагдан, түүнийг баримтлах ёстой.

ЭЗТГ нь Төрийн сантай хамтран төлөвлөгөөт хугацааны болон дунд хугацааны төсвийн орлогын тооцооллыг үндэслэн, тухайн хоёр жил дотроо жил тутмын зардлын дээд хязгаар, яамдын төсвийн дээд хэмжээг тогтоож өгнө.⁸ Өмнө нь Засгийн газар төсвийн орлогынхоо 40%-ийг газрын тосноос бүрдүүлдэг, газрын тосноос ихээхэн хамааралтай байв. Тиймээс газрын тосны үнэ төсвийн төлөвлөгөөний дээд хязгаарыг тогтоох гол хүчин зүйл болж байв. Харин одоо газрын тосны орлого засгийн газрын нийт орлогын дөнгөж 14 хувийг бүрдүүлдэг болсон. Тиймээс бүтээгдэхүүн, үйлчилгээний татвар гэх мэт санхүүжилтийн бусад эх үүсвэрийг харгалзан жилийн үйл ажиллагааны болон хөгжлийн төсвийн хуваарилалтыг тогтоож байна.⁹

Яам, агентлаг, мужийн захиргаадад төсвийн зардлын дээд хязгаарыг мэдээлдэг. Ингэснээр тэд төлөвлөгөөт хугацаанд хэрэгжүүлэх төслүүдээс хоёр жилийн хөгжлийн төсөвт орох төслийн төсвийг боловсруулах бололцоотой болдог. Яамд нь муж, орон нутгийн захиргаатай харилцаж, тухайн мужийн нутаг дэвсгэр дээр өөрийн хэрэгжүүлэх төслийнхөө талаар санал солилцох үүрэг хүлээдэг бөгөөд үүнийг Мужийн Эдийн засгийн төлөвлөлтийн газар, Мужийн төлөвлөлтийн зөвлөл зэрэг механизмаар дамжуулан хийдэг.

4. Төлөвлөлтийн хүрээ

Яам, агентлагууд нь төлөвлөлтийн Удирдамжид заасан дунд, урт хугацааны тэргүүлэх чиглэл, макро төлөвлөлтийн хүрээнд нийцүүлэн хоёр жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслөө боловсруулдаг (Зураг 3). Үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчмын дагуу, яам, агентлаг нь тухайн холбогдох стратегийн тулгуур зорилт, стратегид нийцүүлэн, хоёр жилийн төлөвлөгөөнд орох төслийн жагсаалт, түүнд шаардагдах зардлын тооцоог боловсруулах шаардлага, зааврыг төлөвлөлтийн Удирдамжид зааж өгсөн байдаг.¹⁰ Стратегийн тулгуур зорилт, стратегид үл хамаарах төсөл байвал төсвийн хяналтын эхний үе шатнаас хасагддаг.

Зураг 3-т Малайзын засгийн газрын аппарат, тогтолцоон дотроо хөгжлийн зорилгоо дээрээс нь доош бүүлган задлан тодорхойлж буй хүрээг харуулав. Энэ хүрээ нь төлөвлөлтийн үйл явцад эдийн засаг, нийгэм, байгаль орчны гэсэн хөгжлийн гол гурван чиглэл хэрхэн нэгтгэгдэж байгааг харуулна. Улмаар энэ хүрээ нь хоёр жилийн төлөвлөгөө бэлтгэх суурь болдог.

⁸ Малайз улсын 11 дүгээр 5 жилийн төлөвлөгөөний хүрээнд хоёр жилийн төлөвлөгөөг 2016-2017, 2018-2019 хийх бөгөөд 2020 оныг дангаар нь төлөвлөнө.

⁹ 10 дугаар 5 жилийн төлөвлөгөөнөөс өмнө зардлын дээд хязгаарыг төлөвлөгөөний нийт хугацаанд хүрэх зорилт, стратегид тохируулан, мөн үнийн хэлбэлзэл, төлбөрийн тэнцэл, ханган нийлүүлэлтэд сөрөг нөлөө учруулахгүйгээр бодож тогтоож байсан. Одоо мөрдөж буй 5 жилийн төлөвлөгөөнд ч нийт төлөвлөгөөт хугацааны зардлын дээд хэмжээг тогтоосон. Гэхдээ өмнөх төлөвлөгөөнөөс ялгаатай нь хөтөлбөр бүрээр хөрөнгийн хуваарилалтыг урьдчилж хийгээгүй. Хөгжлийн төслийн төсвийн хуваарилалтыг хоёр жилийн төлөвлөгөөнд заасан хүрээнд багтаан жилийн төсөв дээр хийж байна.

¹⁰ Эдгээр нь МХЗ гэх мэт Малайз улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хүрээнд авсан амлалттай тохирч байгаа.


Зураг 3-т үзүүлсэнчлэн 2020 он хүртэлх Алсын хараа уг хүрээний дээд цэгт байрлана¹¹. Стратегийн дараах зургаан тулгуур зорилт нь тус улсын ТХЗ-ыг арай нарийвчлан илэрхийлж өгч байна. Эдгээр стратегийн тулгуур зорилтууд цааш хүрэх ёстой гол үр дүн буюу тэргүүлэх чиглэлд хуваагдана. Эдгээр чиглэл нь байгууллагууд хөгжлийн төсвөө хийхэд арай дөхөм, нарийвчилсан удирдамж болж өгнө. Стратегийн тулгуур зургаан зорилт, тэдгээр нь дотроо задран Хүрэх ёстой гол үр дүн болж тодорхойлогдсоныг дор үзүүлэв:

Зураг 3: Төлөвлөлтөд хөгжлийн зорилгуудыг нэгтгэн тусгах нь

2020 он хүртэлх Алсын хараа

Малайз улсын Үндэсний хөгжлийн стратеги (2014-2020)

- Хүний төлөөх эдийн засаг
- Хөрөнгө бүтээх эдийн засаг



МТЖТ: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө (2016-2020)

Эх сурвалж: ЭЗТГ, 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө боловсруулах удирдамж

(Товчилсон үгс: ХГҮД – Хүрэх ёстой гол үр дүн, ГШҮ – Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт)

- **Стратегийн тулгуур зорилт 1: Тэгш шударга нийгэм байгуулах зорилгоор хүртээмжтэй өсөлтийг дэмжих**

ХГҮД (голлон анхаарах ёстой чиглэл) 1: Эмзэг бүлгийн айл өрхийг (доод 40%) дунд орлоготой хэсгийн эгнээнд оруулах

¹¹ Алсын хараа 2020 ба Үндэсний хөгжлийн стратеги нь стратегийн 6 тулгуурт багтсан. Тухайлбал, 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний “Өсөлтийг хүний төлөө” гэсэн гол сэдэв нь эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчныг хамгаалах 2Е3Е хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг шингээсэн. Мөн улс үндэстний гол баялаг бол хүн, тиймээс хөгжлийн үр шимийг хүртэх ёстой гэдгийг дахин тунхагласан. Энэ сэдэв нь мөн ТХЗ-ын “хэн нэгнийг орхигдуулахгүй байх” гэсэн сэдэв, хөгжлийн 17 зорилготой таарч байгаа юм. 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний зорилго 2015 оны ТХЗ-оос өмнө батлагдсан. ТХЗ тус Таван жилийн төлөвлөгөөнд хэрхэн туссан талаар Хавсралт 1, 2-оос харна уу.

ХГҮД 2: Бүтээмжит, хөгжингүй нийгэм байгуулах үүднээс олон нийтийг мэдэлжүүлэх,
ХГҮД 3: Орон нутгийн иргэдийн аж байдлыг өөд татахын тулд хөдөө орон нутагт эрс өөрчлөлт хийх,
ХГҮД 4: Газарзүйн тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс бүс нутгийн хөгжлийн өсөлтийг түргэсгэх,
ХГҮД 5: Баялгийн өмчлөлийн нэмэгдүүлэх үүднээс Бумипутера Эдийн засгийн бүлийн боломжийг нэмэгдүүлэх.

- **Стратегийн тулгуур зорилт 2: Бүх нийтийн аж байдлыг сайжруулах:**

ХГҮД 1: Эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох
ХГҮД 2: Ядуу, бага, дунд орлоготой өрхүүдийг зохих стандартыг хангасан, чанартай, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах
ХГҮД 3: Аюулгүй амьдрах орчин нөхцөл бүрдүүлэх
ХГҮД 4: Осол эндэгдлийг бууруулах зорилгоор зам тээврийн аюулгүй байдал, түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж
ХГҮД 5: Нийгмийн эв нэгдэл, хамтач байдлыг дэмжих үүднээс Нэг Малайз үзэл санааг төлөвлүүлэх,
ХГҮД 6: Эрүүл амьдрал, эв нэгдлийг бэхжүүлэх үүднээс бүх төрлийн спортыг хөгжүүлэх.

- **Стратегийн тулгуур зорилт 3: Хүний нөөцийг хөгжүүлж хөгжингүй улс үндэстэн болох**

ХГҮД 1: Эдийн засгийн өсөлтөө түргэсгэхийн тулд хөдөлмөрийн зах зээлийн үр ашгийг дээшлүүлэх
ХГҮД 2: Аж үйлдвэрийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор МСҮТ-дэд шинэчлэлт хийх,
ХГҮД 3: Ур чадварыг дээшлүүлэх зорилгоор насан туршийн боловсролыг бэхжүүлэх,
ХГҮД 4: Төгсөгчид болон байгууллагын мэргэшлийн түвшинг дээшлүүлэх зорилгоор боловсролын чанарыг сайжруулах.

- **Стратегийн тулгуур зорилт 4: Тогтвортой, бэрхшээлийг даван туулах чадвартай улс орон байхын төлөө ногоон өсөлтийг дэмжих,**

ХГҮД 1: Ногоон өсөлтийг дэмжих таатай орчинг бэхжүүлэх
ХГҮД 2: Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх
ХГҮД 3: Өнөө болон хойч үеийнхэндээ зориулан байгалийн нөөцөө хамгаалах
ХГҮД 4: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, байгалийн гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэх.

- **Стратегийн тулгуур зорилт 5: Дэд бүтцийг бэхжүүлэх эдийн засгаа өргөжүүлэн тэлэх**

ХГҮД 1: Хэрэгцээнд суурилсан тээврийн нэгдсэн систем бий болгох
ХГҮД 2: Логистикийн өсөлт хөгжил, худалдааг хөнгөвчлөх ажиллагааг дэмжих
ХГҮД 3: Дижитал дэд бүтцийн хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулах
ХГҮД 4: Усны үйлчилгээний салбарын хүрээг шинэ хүрээ рүү шилжих үйл явцыг үргэлжлүүлэх
ХГҮД 5: Эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор эрчим хүчний тогтвортой ашиглалт, хэрэглээг хөхиүлэн дэмжих

- **Стратегийн тулгуур зорилт 6: Эдийн засгийн хөгжил цэцэглэлд хүрэхийн тулд илүү өндөр өсөлтийг дахин инженерчлэх**

ХГҮД 1: Үйлчилгээ хүргэлтэд шинэчлэлт хийх
ХГҮД 2: Үйлдвэрлэлийг эрчимжүүлэх
ХГҮД 3: Хөдөө аж ахуйн салбарыг орчин үеийн болгох
ХГҮД 4: Барилгын салбарт шилжилт хийх
ХГҮД 5: Эрчимтэй хөгжил бүхий ЖДҮ-ийг нэмэгдүүлэх
ХГҮД 6: Инновацийг баялаг болгон хувиргах
ХГҮД 7: Өрсөлдөх чадавх бүхий хот, бүс нутгийн эдийн засгийн коридорт хөрөнгө оруулах

Хүрсэн байх ёстой гол дүр дүн (ХГҮД) буюу чиглэл тус бүрийн хувьд үндэсний түвшинд хүрсэн байх ёстой зорилтот түвшинг, түүнийг хэрэгжүүлэх арга зам буюу стратегийн хамт нарийвчлан тодорхойлдог. Нийгэм, эдийн засгийн зорилгод хүрэх гол арга зам гэдэгт мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх, хүний нөөцийн хөгжилд онцлон анхаарах, эдийн засгийн гол салбаруудаа үр ашигтай үйлдвэрлэл, нэмүү өртөг илүү шингээн ажилладаг болгон хувиргах шилжилтийг түргэсгэх зэрэг багтсан. (**Шигтгээ 2**-т Эмзэг бүлгийн өрхийг дунд орлоготой өрхийн түвшинд хүргэхэд чиглэсэн ХГҮД-г хэрэгжүүлэх арга замын жишээг үзүүлэв)

Үндэсний түвшний хүрсэн байх ёстой үр дүн нь яамд хөтөлбөр, төсөл, тэдгээрийн үр дүн, хэрэгжүүлэх арга зам, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг (ГШҮ) боловсруулахдаа баримтлах гол үндэслэл болдог.

Дараах хүснэгтэд Малайзын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд заасан стратегийн тулгуур зорилтыг яамдын хөтөлбөр, үйл ажиллагаатай хэрхэн үялдуулсныг Эдийн засгийн хөгжил цэцэглэлд хүрэхийн тулд илүү өндөр өсөлтийг дахин инженерчлэх гэсэн Стратегийн тулгуур зорилт 6-г Хөдөө аж ахуйн яамны жишээгээр харуулав.

Стратегийн тулгуур зорилт 6: Эдийн засгийн хөгжил цэцэглэлд хүрэхийн тулд илүү өндөр өсөлтийг дахин инженерчлэх	
Тэргүүлэх чиглэл (ХГҮД) С	Хөдөө аж ахуйн салбарыг орчин үеийн болгох
Гарах үр дүн	Хүнсний хангамжийг баталгаажих, фермер, загасчид, жижиг худалдаачдын орлогыг нэмэгдсэн байна.
Хөдөө аж ахуйн яам	
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (ГШҮ)	Сарын дундаж орлогыг наад зах нь 2500 малайз ринггит-д хүрэх
Арга зам	Зах зээлд гарах боломжийг дээшлүүлж, логистикийн дэмжлэгийг сайжруулах
Арга хэмжээ/ Санаачилга	<ol style="list-style-type: none"> 1. Агро-зах зэрэг маркетингийн цэгийн тоог олшруулж, газрын гэрээ хэлэлцээртэй холбоотой асуудлыг сайжруулан шийдвэрлэх 2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг цуглуулах, түгээх, зах зээлд гаргахад шаардагдах логистикийн дэмжлэгийг сайжруулах
Үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Доод үнийг барихад дэмжлэг үзүүлэх 2. Ханган нийлүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх 3. Маркетерууд буюу бүтээгдэхүүнийг зах зээлд хариуцан гаргагч талуудад дэмжлэг үзүүлэх 4. Зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах дэд бүтцэд дэмжлэг үзүүлэх 5. Гурван дугуйт мотоцикл худалдан авах

Шигтгээ 4: Тэгш шударга нийгэм байгуулах зорилгоор хүртээмжтэй өсөлтийг дэмжих гэсэн Стратегийн тулгуур зорилт 1-ийн Хүрэх ёстой гол үр дүн (ХГҮД) (Тэргүүлэх чиглэл) 1 (Эмзэг бүлгийн өрхийг (Д40) дунд орлоготой хэсгийн эгнээнд хүргэх)-ийн стратеги, гол үр дүнгийн тойм (2016-2020 оны Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2020, х.3-16)

Стратеги 1: Бага орлоготой хэсгийн Д40 (Доод 40%) орлого, аж байдлыг сайжруулах; үүнд дундаж давхаргыг өргөжүүлэх; сургууль завсардалтыг бууруулах; дээд боловсрол, үр чадварын сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлэх; орчин үеийн технологи нэвтрүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлэх; мэдээлэл, харилцааны технологийг нэвтрүүлэх ажлыг сайжруулах; бизнес эрхлэлтэд үзүүлэх цогц дэмжлэгийг нэмэгдүүлэх; хамт олны болон олон нийтэд түшиглэсэн аж ахуйн нэгжийг хөгжүүлэх; Д40-д хамрагддаг өрхийн олонхи амьдардаг бүсүүдэд хөрөнгө оруулахыг тусгайлан урамшуулах; хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр дамжуулан баялгийг өмчлөлийг нэмэгдүүлэх зэрэг арга замаар дамжуулан хүрнэ.

Стратеги 2: Амьжиргааны өртөг өсөн нэмэгдэж буй асуудлыг шийдвэрлэх; үүнийг үнэ тогтворжуулах дүрэм журмын хэрэгжилт, хяналтыг сайжруулах; төлбөрийн чадварт хийцсэн орон сууцны хангалтыг дээшлүүлэх; эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх; нийгмийн халамжийн нэгдмэл, цогц хөтөлбөр нэвтрүүлэх; санхүүгийн болон өрийн удирдлагын хөтөлбөрүүдийг өргөжүүлэх зэрэг арга замаар дамжуулан хэрэгжүүлнэ.

Стратеги 3: Д40-д хамрагдах өрхөд зориулсан хөтөлбөрийн гүйцэтгэлийг сайжруулах, үүнд Д40-д хамрагдах өрхүүдэд үзүүлэх дэмжлэгийг цэгцтэй болгох, Ядуурлын шугамын орлогын хэмжүүрийг Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ)-тэй хамт авч үзэх зэрэг аргаар хүрнэ.

Малайзын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөг боловсруулах үндэс суурь болсон Үндэсний хөгжлийн стратеги нь хүний төлөөх эдийн засгийг (хүний сайн сайхан аж байдлыг дэмжих) болон баялаг бүтээгч эдийн засгийг (өндөр орлого бий болгох) дэмжих гэсэн хоёр үндсэн агуулгатай. Иймээс өндөр үр нөлөөтэй, бага өртөгтэй төслүүдийг жилийн хөгжлийн төсвийн санхүүжилтэд чухалчлан авч үздэг. Өндөр

үр нөлөөг зөвхөн зардлын хэмнэлт дээр тулгуурлан үнэлдэггүй харин ард иргэдийн хэрэгцээ шаардлагыг хир хангаж байгаагаар төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх талаас нь хардаг.

Цэнхэр-далай аргыг ашиглан хэрэгжүүлэх төслөө тодорхойлох нь

Малайзын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд өндөр нөлөөтэй, бага зардлаар шууд хэрэгжүүлэх боломжтой төслийн талаар онцгойлон заасан тул тэдгээрийг сонгон тодорхойлохдоо Чан Ким, Рене Мауборгне нарын "Цэнхэр далайн стратеги" (2016) хэмээх номондоо боловсруулсан цэнхэр далайн аргыг ашигласан. Энэ номд өндөр нөлөөтэй, харьцангуй бага зардлаар хялбар хэрэгжүүлж болох төслүүдийг илрүүлж, тодорхойлох шинэлэг аргын талаар өгүүлсэн. Уг аргыг Үндэсний цэнхэр далайн стратеги (ҮЦДС) хэмээх нэртэйгээр 2009 онд засгийн газрын тусгай бодлого болон баталсан. Энэ аргын талаар дор тайлбарлав.

ҮЦДС нь төрийн үйлчилгээний суурь зорилго болох бодит, жинхэнэ үнэ цэнийг бий болгоход чиглэдэг. Public value буюу нийтэд хүртээлтэй үнэ цэнэ хэзээ бий болдог вэ гэхээр төрийн санхүүжилттэй төсөл, үйлчилгээнээс бий болсон ашиг тус нь түүнийг хэрэгжүүлэхэд гарсан зардлаас давсан үед бий болно.

Ийм шинэлэг төслийг илрүүлэн тодорхойлохын тулд Чан Ким, Рене Мауборгне нарын аргаас авсан 4 гол асуултыг асууна. Энэ бол цэнхэр далайн буюу хувийн хэвшил дэх шинэлэг шийдлийг олж тогтоох гол хэсэг юм. Үүнд:

- Засгийн газраас уламжлал ёсоор үзүүлж ирсэн үйлчилгээтэй холбоотой ямар хүчин зүйлийг хасах шаардлагатай вэ?
- Ямар хүчин зүйлийг засгийн газрын тогтоосон стандартаас дээшлүүлэх шаардлагатай вэ?
- Яамр хүчин зүйлийг засгийн газрын тогтоосон стандартаас доошлуулан бууруулах шаардлагатай вэ?
- Засгийн газраас үйлчилгээг хүргэхдээ урьд өмнө нь бодож байгаагүй ямар хүчин зүйлийг шинээр бий болгох шаардлагатай вэ?

Ийм аргаар тодорхойлсон төслүүд өндөр орлого, нийтийн сайн сайхан байдлыг бий болгох үйл явцыг хурдасгана хэмээн найдаж байна. Учир нь өсөлт ба инновац хоёр өөр хоорондоо эерэг хамааралтай байдаг. Энэ аргыг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2015 он гэхэд 80 гаруй төрийн байгууллага 100 орчим төслийн санал боловсруулаад байв.

Цэнхэр далай төслийн нэг жишээ бол цагдаа, зэвсэгт хүчнийхэн хамтран гэмт хэрэгтэй тэмцэх төсөл боловсруулсан явдал юм. Цагдаагийнхан одоо ажилтнуудаа богино хугацаанд сургахын тулд зэвсэгт хүчний сургалтын байр, тоног төхөөрөмжийг ашиглаж байна. Түүнчлэн хоёр байгууллага аль аль нь гудамжны эргүүл зохион байгуулж байна. Төрийн байгууллага хоорондын ийм хамтын ажиллагаа нь урьд өмнө төрийн албанд байсан тус тусдаа, өөр өөрийн урдах ажлыг хийдэг сэтгэлгээг өөрчилсөн. Хамтын ажиллагааны өөр ийм жишээг хот, хөдөөгийн эрс шинэчлэлийн төвүүд дэх нэг цэгийн үйлчилгээнээс харж болно.

Жилийн төсвийн төлөвлөлт

Таван жилийн төлөвлөгөөний эхний жилийн төсвийг таван жилийн төлөвлөгөөнөөс, ялангуяа эхний хоёр жилийн төлөвлөгөөнөөс гаргана. Жилийн төсвийг төлөвлөхдөө ч тухайн жилийн орлогын тооцоо, засгийн газрын зээл авах чадавх, зээлийн олдоц зэргийг харгалзана. Эдгээрийг үндэслэн Сангийн яамнаас тухайн жилийн төсөв зохиох Удирдамжийг боловсруулах бөгөөд түүнд ирэх жилд засгийн газраас баримтлах тэргүүлэх чиглэлийг мөн зааж өгнө.

ЭЗТГ, Сангийн яам хамтран яам, агентлагийн төлөвлөгөөт жилийн хөгжлийн төсвийн төслийг хянадаг уламжлалтай. Энэ хяналт нь хөгжлийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд нийцэхгүй төслүүдийг хасахад хэрэг болно. Мөн ирсэн төслийн тоо, хэмжээ ч ихэнхдээ санхүүгийн боломжоос давсан байдаг.

ЭЗТГ-ын дээд удирдлагаас дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль орчин, байгалийн нөөц гэх мэт салбар тус бүрээр зардлын дээд хэмжээг тогтоож өгдөг. Энэ зардлын дээд хязгаар бол хэрэгжүүлэх төслөө

сонгоход нэг суурь болдог. Зардлын дээд хязгаар бол тухайн санхүүгийн жилийн хөгжлийн нийт төсвийн доторх хуваарилалт юм.

Төсвийг хянахдаа төслийн сонголт хийх, тухайн төслийн зардлыг тогтоохдоо дараах асуултыг асууна. Үүнд тухайн хөтөлбөр, төсөл нь:

- Бүс нутгийн тэнцвэртэй хөгжил гэх мэт төрийн бодлоготой нийцэж байгаа эсэх. Ингээд сул хөгжилтэй муж, бүс нутагт хэрэгжих төсөлд хөгжингүй муж, бүс нутгаас илүү жин өгнө.
- Яаралтай эсэх,
- Санхүүгийн хувьд амьдрах чадвартай эсэх,
- Өмнөх төлөвлөгөөний үргэлжлэл эсэх,
- Кабинет эсвэл сайд дэмжсэн эсэх,
- Үндэсний стратегийн тулгуур зорилт, тэргүүлэх чиглэл, салбарын стратеги, гүйцэтгэлийн үзүүлэлт зэргийг хангах замаар эдийн засагт хүсч буй нөлөө үзүүлэх эсэх,
- Хариуцсан байгууллагын төсөл хэрэгжүүлэх чадавх, төсөл хэрэгжилтийнхээ аль үе шатанд байгаа¹²
- Байгаль орчинд эерэг нөлөөтэй гэсэн үнэлгээ бүхий төслүүд.

ЭЗТГ мөн дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

- Салбар, бүс нутаг, мужийн төсвийн хуваарилалтын тэнцвэр¹³
- Салбарын зардлын хязгаар
- Үндэсний шинэтгэлийн хөтөлбөрт заасан хүрэх ёстой гол үр дүн, эдийн засгийн тэргүүлэх салбар мөн эсэх
- Аж үйлдвэрийн мастер төлөвлөгөө, боловсролын төлөвлөгөө, логистик төлөвлөгөө, дэд бүтцийн мастер төлөвлөгөө гэх мэт бусад мастер төлөвлөгөө.

2017 оны төсвийн хяналт, хуваарилалтаас эхлэн төсөл хөтөлбөрийг сонгохдоо 2030 он хүртэлх ТХЗ-ыг нэг үндэслэл болгон, зориуд харгалзан үздэг болсон. Түүнчлэн, ЭЗТГ янз бүрийн стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна. (Эдгээр нь илүү нарийвчлалтай мэдээлэл өгдөг бөгөөд хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох суурь болдог). Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд ТХЗ-ыг мөн тусгана. Түүний эхлэл болгон 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний 3 дугаар бүлэгт заасан “Тэгш шударга нийгмийг байгуулах үүднээс хэн нэгнийг орхигдуулахгүй байх” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг туршилт болгон боловсруулж байна.

ТХЗ нь Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний дунд хугацааны биелэлт гаргах, цааш цаашдын төлөвлөгөөнд чухал байр суурь эзэлнэ. Тус төлөвлөгөөний зорилго, МХЗ давхцсан нь зориуд уялдуулсан зүйл байгаагүй ч МХЗ нь улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг бататгахад нөлөө үзүүлсэн.

Яамдын төсвийг хянахын өмнө ЭЗТГ-ын салбар хариуцсан мэргэжилтнүүдэд ЭЗТГ-ын удирдлагаас баталсан салбарын төсвийн дээд хязгаарыг мэдээлдэг.¹⁴ ЭЗТГ-ын мэргэжилтнүүд хариуцсан яамдаасаа ирсэн төсвийн төслийг хянан, төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлнэ.

¹² 2016 оны хөгжлийн төсвийн хянах үед гарсан (11 дүгээр 5 жилийн төлөвлөгөөний эхний жил) өмнө байгаагүй нэг онцлог нь стратегийн тулгуур 6 зорилт тус бүрээр олон семинар (зарим нь бүр долоо хоног үргэлжилсэн) хийсэн явдал юм. Эдгээр семинар дээр засгийн газар бодлогын тэргүүлэх чиглэлээ тайлбарлаж, зарим яамд хамтарсан төслийн саналаа сайд нараар болон ЭЗТГ-ын тэргүүлдэг засгийн газрын төв байгууллагуудын төлөөлөл бүхий тусгай бүлгээр хэлэлцүүлсэн. Дэд бүтцийн төсөл хэлэлцэхэд Нийтийн зориулалттай ажил, тохижилт хариуцсан газар, Ус суваг, усалгааны газрыг мөн тус бүлэгт оролцуулж байсан. Гол нь төслийн давхардал, хийдэл гаргахгүй байх талаар ихээхэн анхаарсан. Тус бүлэг нь бүх төсөл, хөтөлбөрийн саналыг нэг бүрчлэн судалж, шаардлагатай тохиолдолд холбогдох яам, агентлагийн тайлбар, үндэслэлийг сонсож байсан. Хөгжлийн төсвийг хянадаг энэ тогтолцоог одоо хэрэглэхээ больсон. 2017 оны төсвийн циклээс эхлээд өмнө мөрдөж байсан тогтолцоогоо сэргээж, ЭЗТГ, Төрийн сан хамтран холбогдох яам, агентлагтай нэг бүрчлэн үүлдэг хэлбэр рүүгээ эргэн орсон.

¹³ ЭЗТГ-ын захирал асан ингэж хэлсэн байдаг “Тэргүүлэх чиглэлээ тогтооно гэдэг бол засгийн газрын хамгийн хүнд үүргийн нэг юм. Учир нь хөгжилд оролцогч бүх өрсөлдөгч тал өөрсдийн тэргүүлэх чиглэлээ дээгүүр тавихыг оролддог ч улсад маань түүнийг санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал байдаг.”

¹⁴ Малайз улсын 11 дүгээр 5 жилийн төлөвлөгөөнд тэдгээр салбар нь тулгуур 6 зорилттой тохирч байгаа.

Төсвийг хянах явцад салбарын яам, мужийн захиргаад төсвийн саналынхаа үндэслэлийг тайлбарлана.¹⁵ Төсвийг хянаж дуусмагц ЭЗТГ-аас батлагдсан хөтөлбөр, төслүүдийг салбараар буюу Үндэсний хөгжлийн Стратегийн 6 тулгуур зорилтоор нэгтгэсэн жагсаалт гаргана. Салбараар ангилсан төслүүд нь холбогдох бүлэг яамдын батлагдсан төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн жагсаалтын нэгтгэл байна.


Салбарын зардлын энэхүү дээд хязгаар болон батлагдсан төслүүдийг ЭЗТГ-ын салбар хариуцсан газрын дарга нараас ЭЗТГ-ын дээд удирдлагатай хамтран дахин сайтар хянана. Яг энэ үе шатанд салбар хоорондын тэргүүлэх чиглэл, буулт буюу зөвшилцөл хаана хийх тухай шийдвэр гарна. Маш няхуур, чамбай, мөн өрсөлдөөнт хэлэлцүүлэг өрнөсний эцэст салбар бүрийн зардлын дээд хязгаар, батлагдсан төслүүдийн жагсаалт бэлэн болно. Тэргүүлэх чиглэлээс гадна тухайн төслийг хэр чанартай боловсруулсан бэ гэдэг нь тухайн төсөл эцсийн жагсаалтад орж, Кабинет, Парламентаар хэлэлцэгдэх эсэхэд нөлөөлдөг.

Төсвийг салбараар хуваарилах боловч төслийн жагсаалтыг мөн муж, орон нутгаар ангилан гаргадаг. Энэ нь бүс нутгийн тэнцвэртэй өсөлтийг хангахын тулд төслийн сонголт, төсвийн хуваарилалт хийхдээ сул хөгжилтэй муж, бүс нутагт зохих анхаарал хандуулсан эсэхийг хянахад тус болдог.

5. Хяналт шинжилгээ, үнэлгээ

Энэ хэсэгт бодлого, хөгжлийн стратеги, төслийг 2020 он хүртэлх Алсын хараатай нийцүүлэн хэрэгжүүлэхэд ямар тогтолцоо, механизм хэрхэн ажилладаг талаар өгүүлнэ. **Зураг 4**-т хэрэгжилтийн уялдааг хангах тогтолцоог харуулав.

Зураг 4: Хэрэгжилт зохицуулалтын тогтолцоо



Батлагдсан төлөвлөгөө, төслийг яам, агентлаг, муж, орон нутгийн захиргаа, бүсийн хөгжлийн байгууллагууд хариуцан хэрэгжүүлнэ. Эдгээр байгууллагын тусламжтайгаар Ерөнхий сайдын албаны дэргэдэх Хэрэгжилт зохицуулалтын газар (ХЗГ) нь хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд ЭЗТГ-аас баталсан төрөл бүрийн төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын голлон гүйцэтгэдэг (Зураг 3). ХЗГ нь гүйцэтгэлийн дараах хоёр үзүүлэлтийг үндэслэн сар тутмын хяналт тавина: төслийн биет

¹⁵ ЭЗТГ нь хөгжлийн зорилт, санал болгож буй хөтөлбөрийн үзэл санаа, зорилго зэргийг хянаж үзээд хөгжлийн ерөнхий зорилго, хүрээ, хөтөлбөрт шаардагдах зардлын тооцоог гаргана. Тухайлбал, шинэ эмнэлэг барих төсөл хэрэгжүүлэх тохиолдолд, тус бүсийн хүн амын тоо, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стратеги, үйлчилгээний төрөл, эмч мэргэжилтэн, тухайн барилга барих барилгын болон материалын стандарт гэх мэт олон асуудлыг судалж байж шийдвэр гаргадаг.

гүйцэтгэлийн хувь (баригдсан барилга байгууламж, чөлөөлөгдсөн газар гэх мэт); мөн хөтөлбөр, төслийн хуваарилагдсан төсвийн зарцуулалтын хувь.

Урт хугацааны хувьд, ЭЗТГ нь төсөл хэрэгжүүлснээр зорьсон үр дүн гарч, биелж байгаа эсэхэд үнэлгээ өгнө. ХЗГ нь дараах үндсэн үүрэгтэй:

- Хөтөлбөр, төслийг зорилго, зориулалтын дагуу хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих,
- Хөтөлбөр, төсөл сайн засаглалын зарчмын дагуу үр ашигтай, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд явцын хяналт тавих,
- Яамд төслөө хэрэгжүүлэхдээ холбогдох дүрэм журмын дагуу хөрөнгө санхүүгээ зөв зохистой, хэтрүүлэлгүй зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих,
- Төслийн хэрэгжилтээс гарах үр нөлөө, үр дүнг үнэлэх, үндэсний хөгжлийн зорилго биелсэн байх үүднээс гүйцэтгэлийг хангуулах.

Яам, мужийн захиргаадын хувьд, хэрэгжилтийн явцыг хянах, тайлагнах үүрэг бүхий Хэрэгжилтийг хангах Ажлын хороод ажиллана. Яамны Төрийн нарийн бичгийн дарга нар тус тусын Хэрэгжилтийг хангах Ажлын хороогоо даргална. Ажлын хороод харьяаллынхаа төслүүдийн хэрэгжилтийг зохицуулах, хянаж шалгах үүрэгтэй. Мөн хэрэгжилтийн явцыг ХЗГ-т тайлагнана, мөн төслийн нөлөөллийн үнэлгээг хийнэ.

Яам, агентлагийн ирүүлсэн төслийн явцын тайланг судалсны үндсэн дээр ХЗГ нь Засгийн газрын Ерөнхий нарийн бичгийн даргын удирддаг Хэрэгжилтийг хангах Үндэсний Ажлын хороонд тайлагнана. Тус Хороо нь, тухайлбал, дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Яам, агентлаг хөгжлийн төслүүдээ хэрэгжүүлсэн байх, мөн үндэсний бодлого, хөгжлийн төлөвлөгөөний зорилтуудтай нийцүүлсэн байхад анхаарч, мөрдүүлэх,
- Хөгжлийн төсөл хэрэгжүүлэх явцад гарч буй гол бэрхшээл, дутагдаж буй зүйлийг тодорхойлж арилгах,
- Төслийн хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээний шинэ журам, тогтолцоог бий болгох.

Ийнхүү хянан үзээд тус Ажлын хороо нь хэрэгжилтэнд гарч буй асуудал, бэрхшээлийг нэгтгэн, Хэрэгжилтийг хангах Үндэсний зөвлөлд танилцуулна. Ерөнхий сайдын тэргүүлдэг энэ Зөвлөл хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явц, тулгарч буй асуудлыг мөн хянаж үнэлнэ. Мөн байгаль орчныг хамгаалахтай холбоотой асуудлыг зохицуулна. Ерөнхий сайд мөн энэ Зөвлөлийн харьяа гүйцэтгэх хороог даргална. Гүйцэтгэх хороо нь холбогдох яам, агентлагтай тогтмол уулзаж, төслүүдийн ахиц, явц, гарч буй хүндрэл бэрхшээлийг нэгбүрчлэн авч үзнэ.

Төслийн явцын хяналт, үүнд биет гүйцэтгэл, санхүүжилт, гарч буй үр дүнг сүүлийн үеийн Төслийн хяналтын систем II (ТХС II) хэмээх программаар хийдэг. ТХС II-д бүх яам, газар, агентлаг цахимаар холбогдсон. Бүх яам, агентлаг, муж, дүүргийн захиргаа цахим системд холбогдсон бөгөөд өөр өөрсдийн хэрэгжүүлж буй төслийн мэдээллийг тогтмол шинэчлэн уг системд оруулдаг.

6. Орон нутгийн төлөвлөлт


Энэ хэсэгт дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

- Мужийн захиргааны бүтэц, зохион байгуулалт
- Холбооны болон мужийн төсөв, санхүүгийн харилцаа
- Мужуудын хөгжлийн санхүүжилт
- Мужийн төлөвлөлтийн байгууллага, үйл явц

Мужийн захиргааны бүтэц, зохион байгуулалт

Малайз улс нь Холбооны засгийн газар, муж (14), орон нутгийн засаг захиргаа (147) гэсэн засаг захиргааны гурван шатлалтай. Улс төр, төрийн захиргааны байгууллага нь холбооны түвшний бүтэц, зохион байгуулалттай адил төстэй байдаг. **Зураг 5**-д Малайз улсын газрын зургийг мужаар үзүүлэв.

Зураг 5: Малайз улс, мужаар



Муж бүр өөрийн хууль тогтоох байгууллагатай. Мужийн парламентыг Холбооны парламентын адил 5 жил тутам сонгуулиар сонгодог. Үндсэн хуулиар Холбооны засгийн газар болон мужууд тус бүртээ ямар асуудлыг хариуцан шийдвэрлэх ёстойг зааж өгсөн. Мжийн парламентын шийдвэрлэх асуудал нь Холбооны парламенттай харьцуулахад цөөн, ихэвчлэн газар, уул уурхай, шашны үйл ажиллагаатай холбоотой асуудал байдаг.

Мужийн Гүйцэтгэх зөвлөл буюу улс төрийн гүйцэтгэх байгууллага нь Холбооны Засгийн газартай төстэй чиг үүрэг гүйцэтгэнэ. Мужийн Зөвлөл буюу тухайн мужийн улс төрийн тэргүүн нь Тэргүүн сайд бөгөөд тухайн мужийнхаа Ерөнхий сайд гэсэн үг юм. **Зураг 6**-д ядуурлын түвшингээр жишээлэн мужуудын хөгжлийг харьцуулж үзүүлэв. Зураг 6-аас харахад Зүүн хойд хэсгийн Келантан, Борнео арлын, Сабах, Саравак мужийн хөгжил нэлээд доогуур байна.

Зураг 6: Ядуурлын түвшин, хувиар, мужаар, 1999 -2014

Муж	1999	2002	2004	2007	2009	2012	2014
Жохор	3.1	2.5	2.0	1.5	1.3	0.9	0.0
Кедах	14.2	9.7	7.0	3.1	5.3	1.7	0.3
Келантан	25.2	17.8	10.6	7.2	4.8	2.7	0.9
Мелака	2.9	1.8	1.8	1.8	0.5	0.1	0.1
Хойт Симбалаан	4.1	2.6	1.4	1.3	0.7	0.5	0.4
Паханг	9.8	9.4	4.0	1.7	2.1	1.3	0.7
Перак	6.8	6.2	4.9	3.4	3.5	1.5	0.7
Перлис	13.6	8.9	6.3	7.0	6.0	1.9	0.2
Пинанг	0.7	1.2	0.3	1.4	1.2	0.6	0.3
Сабах	23.4	16.0	23.0	16.0	19.7	8.1	4.0
Саравак	10.9	11.3	7.5	4.2	5.3	2.4	0.9
Селангор	1.9	1.1	1.0	0.7	0.7	0.4	0.2
Теренгану	22.7	14.9	15.4	6.5	4.0	1.7	0.6
Куала Лумпур	0.4	0.5	1.5	1.5	0.7	0.8	0.1
Лабуан	-	7.1	2.6	4.2	4.3	1.1	1.1

Эх сурвалж: ЭЗТГ; Статистикийн газар: Өрхийн орлого, зарлагын судалгаа, олон жилээр

Үндсэн хуулиар орлогын татвар, гааль, онцгой татварыг хураах эрх мэдлийг Холбооны засгийн газарт олгосон байдаг. Мөн хуримтлуулсан орлогыг хуваалцах механизмыг ч Үндсэн хуульд зааж өгсөн. Мужууд

холбооны засгийн газраас зарим төрлийн тэтгэлэг буюу санхүүгийн дэмжлэг авна, үүнд хүн амын тооноос хамаарах тэтгэлэг, мужийн зам засвар, үйлчилгээний тэтгэлэг, мөн сул хөгжилтэй мужуудад арай ахиу орлого хуваарилах зорилго бүхий тэнцвэржүүлэлтийн тэтгэлэг багтана.

Холбооны засгийн газар 2009-2013 онд цуглуулсан нийт орлогынхоо 2.4 орчим хувийг мужуудад хуваарилсан байдаг. Тухайлбал, Пенан муж бол Малайзын хойгийн хойд хэсэгт оршдог. Пенан муж 2017 оны төсвөө 311 сая ам.доллар байхаар төлөвлөсөн. Холбооны засгийн газраас Пенан мужид өмнө нь өгч байсан тэтгэлгээр баримжаалан тооцоолбол тус муж энэ онд 34 сая ам.долларын тэтгэлэг авна, энэ нь тус мужийн төсвийн 11 хувийг эзэлнэ.

Үүнээс гадна Холбооны засгийн газраас 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөн дэх стратегийн тулгуур б зорилтыг урагшлуулахад гол үүрэг гүйцэтгэж буй мужуудад хөгжлийн нэмэлт санхүүжилт олгодог. Мужууд Холбооны засгийн газрын зөвшөөрөлгүйгээр зээл авах боломжгүй. Учир нь Холбооны засгийн газар зээлийг батлан даадаг. Үндсэн хуульд заасанчлан Ерөнхий сайд мужийн Тэргүүн сайд нартай байнга зөвлөлдөн, тухайн мужийн санхүүгийн нөхцөл байдал, төв-орон нутгийн төсөв, санхүүгийн харилцааны асуудлыг Үндэсний санхүүгийн зөвлөлд танилцуулан хэлэлцүүлдэг. Энэ хурлын өмнө санхүү хариуцсан дарга нарын уулзалт болдог.

Мужийн засаг захиргааны бүтэц нь Холбооны засгийн газрынхтай төстэй. Дөрвөн муж л өөрийн гэсэн онцлог, хаалттай тогтолцоотой; мужийн төрийн албаны зөвлөлөөр дамжуулан зөвхөн тухайн мужийн иргэдээс албан хаагчдаа сонгон шалгаруулж авдаг. Холбооны засгийн газрын ажилтанг ажиллуулдаггүй. Харин бусад мужийн төрийн албанд Холбооны засгийн газрын ажилтнууд ажилладаг. Мужийн төрийн захиргааг Төрийн нарийн бичгийн дарга тэргүүлэн, мужийнхаа Тэргүүн сайдад тайлагнана.

Мужийн захиргаа нь дүүрэг эсвэл сумд хуваагдана. Дүүргийн дарга нар тухайн мужийн бусад байгууллагын нэгэн адил мужийн Төрийн нарийн бичгийн даргад тайлагнаж ажиллана. Дүүрэгт орлого босгох боломж бага, газрын түрээс, зөвшөөрлийн хураамж, төлбөртэй авто зогсоол зэргээс орлогоо олдог. Дүүргийн захиргааны гол чиг үүрэг нь газар зохион байгуулалт, нийгэм, эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлын асуудлыг хамарна.

Орон нутгийн засаг захиргаа бол засгийн газрын бүтцийн гурав дахь шатлал юм. Орон нутгийн захиргаа ихэвчлэн гудамжны гэрэлтүүлэг, мөн орон сууц, худалдаа үйлчилгээ эсвэл холимог зорилалтаар газар зохион байгуулах, түүн дээр барилга байгууламж барих төлөвлөгөөг батлах зэрэг асуудлыг хариуцна.

Орон нутгийн захиргааг Шийдвэр гаргах зөвлөл удирдана. Энэхүү зөвлөл нь орон нутгийн улс төрчид, нэр хүндтэй хүмүүсээс бүрддэг бөгөөд тэднийг Мужийн захиргаа томилно. Орон нутгийн захиргааг төрийн албаар мэргэшсэн Ерөнхийлөгч тэргүүлнэ.

Орон нутгийн захиргаа дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Барилга байгууламж, өмч хөрөнгийн татвар хураах,
- Тогтоол шийдвэр, дүрэм журам гаргах
- Худалдаа арилжаа хийх лиценз, зөвшөөрөл олгох,
- Газар зохион байгуулалтын төлөвлөлт (аж үйлдвэрлэл, орон сууц, холимог зориулалтын гэх мэт бүсчлэл тогтоох), бүтээн байгуулалт.

Хөдөөд, орон нутгийн захиргаа нь дүүргийн хилтэй ихэнхдээ давхцаж байдаг. Харин хот суурин газарт, орон нутгийн захиргааны нутаг дэвсгэр нэг дүүргийн хилээс давж, хажуугийн өөр дүүргийн нутагтай давхцдаг.

Орон нутгийн захиргаад голдуу өөрөө өөрсдийгөө санхүүжүүлдэг ч нутаг дэвсгэртээ төсөл хэрэгжүүлэхийн тулд муж, холбооны засгийн газраас шууд буцалтгүй тусламж авдаг.

Мужуудад зориулсан хөгжлийн санхүүжилт

Муж нь холбооны засгийн газрын төлөвлөлтийн бүхий л үйл явцын эд эс болж, улс орны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн санхүүжилт авч байдаг ч тэд дотооддоо холбооны засгийн газрынхаас ялгаатай өөрийн онцлог зохицуулалтыг бас мөрддөг.

Холбооны Засгийн газраас санхүүжилт авахын тулд мужууд таван жилийн төлөвлөгөөний хүрээнд бусад яамтай өрсөлдөнө. Тэд хөгжлийн төсвийн төсөл, хоёр жилийн төлөвлөгөө боловсруулах, тухайн жилийн хөгжлийн төсөв боловсруулах Удирдамжид заасны дагуу бүхий л журмыг даган мөрдөнө. Ирсэн төслийг ЭЗТГ, Сангийн яам хамтран жилийн төсвийг хянах ажлын хүрээнд нягтлан шүүнэ.

Үүнээс гадна мужийн холбогдох газрууд нутаг дэвсгэртээ Холбооны засгийн газрын төсөл хэрэгжүүлэх болбол түүнд шаардагдах санхүүжилтийг яамдаас авна. Ийм санхүүжилтийн тухайд, Холбооны засгийн газраас санхүүжилт авах ажлыг холбогдох салбарын яам нь хариуцан гүйцэтгэнэ.

Орон нутгийн төлөвлөлтийн байгууллагууд ба төлөвлөлтийн үйл явц

Энэ хэсэгт мужийн төлөвлөлтийн тогтолцооны талаар өгүүлнэ. Мужийн түвшин дэх хөгжлийн төлөвлөлт, төсвийн төсөл боловсруулах механизм нь Холбооны засгийн газрынхтай төстэй. Мужийн төлөвлөлт нь үндэсний төлөвлөлтөд нэгтгэгдэн ордог ч муж өөрийн хөгжлийн төлөвлөгөө, төсвийг тогтоон тодорхойлох бие даасан бүрэн эрхтэй.


Мужийн түвшинд Мужийн Эдийн засгийн төлөвлөлтийн газар (МЭЗТГ)¹⁶ нь мужийн хөгжлийн төлөвлөгөө, стратеги, хөтөлбөр, төслөө боловруулах үүрэг хүлээдэг. Мужийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа үндэсний хөгжлийн 5 жилийн төлөвлөгөө, орон зайн төлөвлөгөө, орон нутгийн төлөвлөгөөнд суурилна. Эдгээр төлөвлөгөөнд тухайн муж, орон нутгийн газар зохион байгуулалт, нийгэм-эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийн бодлогыг заасан байдаг.

Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил нь Засгийн газрын Ерөнхий нарийн бичгийн даргаас төлөвлөлтийн Удирдамж хүлээн авснаар эхэлнэ. Дээр өгүүлсэнчлэн, энэ Удирдамжийг тухайн Таван жилийн төлөвлөгөө хэрэгжиж эхлэхээс хоёр жилийн өмнө гаргадаг. Удирдамжийг Мужийн ЭЗТГ хүлээн аваад тухайн таван жилийн төлөвлөгөөний зорилго, стратегитай нийцсэн мужийнхаа голлон анхаарах салбар, чиглэлийг тодорхойлж, Гүйцэтгэх зөвлөлдөө танилцуулна. Дараа нь, Гүйцэтгэх зөвлөлийн шийдвэрт үндэслэн, мужийнхаа голлон анхаарах салбар, тэргүүлэх чиглэл, мужийн төлөвлөгөө боловсруулах Удирдамжийг мужийн холбогдох бүх байгууллага, дүүрэгт илгээж, таван жилийн төлөвлөгөө, мужийн тэргүүлэх чиглэлтэй нийцсэн төслийн саналаа боловсруулж ирүүлэхийг даалгана.

Мужийн захиргаа, байгууллагуудын санал болгосон бүх төслийг МЭЗТГ хүлээн авна. МЭЗТГ нь бүх төслийг шалгаж үнэлэх, зөвлөмж гаргах үүрэгтэй. ЭЗТГ-т бүс нутгийн тэргүүлэх чиглэл тодорхойлоход дөхөмтэй байлгах үүднээс Холбооны яамдын мужууд дахь салбараар дамжин хэрэгжих төслийг МЭЗТГ-тай заавал ярилцаж хэлэлцсэн байх ёстой. Энэ нь тэдгээр төсөл тухайн яам, ЭЗТГ-т очихоос өмнө тухайн мужийн тэргүүлэх чиглэлтэй үялдуулан нийцүүлэх механизм юм.

¹⁶ Зарим үед холбооны Засгийн газрын жижиг төслийн хувьд Мужийн хөгжлийн газар буюу Ерөнхий сайдын албаны дэргэдэх ХЗГ-ын салбар нь тухайн мужаасаа хэрэгжүүлэх холбооны төслүүдийн мужийн түвшний төлөвлөлтийг хийдэг.

Зураг 7: Мужийн хөгжлийн төлөвлөлт, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо



Мужийн төлөвлөлт, хэрэгжилтийн тогтолцоог **Зураг 7**-д үзүүлэв. МЭЗТГ-аас гаргасан Удирдамжийн дагуу дүүргийн төслийг хороо, тосгодын хөгжлийн хороодоос анхлан боловсруулна. Дүүргийн захиргаа хороо, тосгодоос ирсэн төслийн саналыг хянаж нэгтгээд МЭЗТГ-т хүргүүлдэг. МЭЗТГ нь бүх дүүрэг, байгууллагын хөгжлийн төслийн саналыг авч хянаж нэгтгээд Мужийн төлөвлөгөөний хороонд (энэ нь Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний хорооны мужийн түвшин дэх хувилбар юм) хүргүүлнэ. Мужийн төлөвлөгөөний хорооны зөвлөмжийн дагуу, хөгжлийн төслийн саналыг Мужийн Гүйцэтгэх зөвлөл батална.

ЭЗТГ-аас төсөв хянах үед хасагдсан төслийн дийлэнх нь зөвхөн тухайн муж, дүүрэгт илүү хамаатай төслүүд байдаг бөгөөд тийм төслийг мужийн төсвөөс санхүүжүүлэх ёстой байдаг.

Хяналт шинжилгээ, үнэлгээ

Муж, дүүргийн захиргаад бол төлөвлөгөө хэрэгжүүлэх үндэсний механизмын эрэг шураг юм. Зураг 7-д үзүүлсэнчлэн, Хэрэгжилтийг хангах Үндэсний зөвлөлтэй адил үүрэгтэй Хэрэгжилтийг хангах Мужийн зөвлөлүүд ажилладаг. Мужийн зөвлөлийг Тэргүүн сайд даргалж, Мужийн Ажлын хороодоос төслийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл авч, хяналт тавина (Хэрэгжилтийг хангах Үндэсний Ажлын хороо мөн ажилладаг). Эдгээр Ажлыг хороог тухайн мужийн Төрийн нарийн бичгийн дарга удирдана.

Мужууд дүүрэгт хуваагддаг, дүүргүүдэд мөн хэрэгжилтийг хангах Дүүргийн хороод ажиллана. Эдгээр хороодыг Дүүргийн дарга тэргүүлдэг, энэ хороод нь хэрэгжилтийг хангах Яамдын хороодын муж дахь хувилбар гэсэн үг. Хэрэгжилтийг хангах эдгээр бүх хорооны чиг үүрэг нь үндэсний түвшний хороотой адил төстэй.

Хэрэгжилтийг хангах Мужийн хороо нь хэрэгжилтийг хангах Мужийн зөвлөлд, мөн Хэрэгжилтийг зохицуулах газарт (ХЗГ) тайлагнана. ХЗГ нь эдгээр бүх тайланг яамдын тайлантай нэгтгэн, Үндэсний хөгжлийн Ажлын хороонд хүргүүлэх ба улмаар хэрэгжилтийг хангах Үндэсний зөвлөлд танилцуулна.

Үүнээс гадна, ХЗГ-ын салбар болох Мужийн хөгжлийн алба нь Холбооны засгийн газраас мужийн түвшинд хэрэгжүүлж буй төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ өгдөг.

7. Түншлэл ба оролцоо

Төлөвлөлтийн нэг салшгүй хэсэг нь төр, хувийн хэвшил, иргэний нийгэмтэй тогтмол, байнга хийдэг хэлэлцүүлэг зөвлөлдөх уулзалтууд юм. Ийм институтлагдсан зөвлөлдөх ажиллагаа нь Засгийн газартай харилцах үр дүнтэй талбар болдог. Эдгээр зөвлөлдөөний үеэр тулгарч буй асуудал, саад бэрхшээлийг шийдвэрлээд зогсохгүй олон асуудлаар санал авах боломж гардаг. Тухайлбал, засгийн газрын бодлого шийдвэр, дэлхийн зах зээл, дотоодын эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн янз бүрийн бүлэгт үзүүлэх бодлого, хөтөлбөрийн үр нөлөө зэргийг дурдаж болно.

Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог улам өргөжүүлэхийн тулд ЭЗТГ нь муж бүрт хүрч Таван жилийн төлөвлөгөөний зорилго, хөтөлбөрийг танилцуулах уулзалт өдөрлөг зохион байгуулдаг. Мөн таван жилийн төлөвлөгөөг тайлбарлаж, санал зөвлөгөө авах зорилгоор нэг, хоёр өдрийн үзэсгэлэнг мужуудад зохион байгуулдаг. Таван жилийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл, уг батлагдсан төлөвлөгөөний эхийг ЭЗТГ-ын цахим хуудаснаас үзэх боломжтой.

МХЗ-ыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэн авч үзэж байх үед иргэний нийгмийн оролцоо төдийлөн өргөн хүрээтэй, хангалттай байж чадаагүй. Үүнийг залруулахын ЭЗТГ-аас хөгжлийн төлөвлөлтөд ТХЗ-ыг нэгтгэн авч үзэхэд иргэний нийгмийг идэвхтэй оролцуулсан. Өнгөрсөн жилийн (2016) эхээр болон сүүлээр хоёр удаа семинар зохион байгуулж, иргэний нийгмийн байр суурийг сонсон, санал авсан.

Хувийн хэвшлийн байр суурь, саналыг БХТХ, МАХ, фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр нэлээд сайн оруулсан (х.17-18). Түүнчлэн засгийн газраас төлөвлөлтийн баримт бичигтээ үндэсний хөгжлийн төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн гүйцэтгэх үүргийг тодорхойлон, хувийн хэвшил бол эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр болж, эдийн засгийг идэвхжүүлэх бол засгийн газар жолоодох, дэмжих, түүнд үйлчлэх үүрэг гүйцэтгэнэ гэж заасан. Энэ хүрээнд засгийн газар дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Өрсөлдөх чадвартай хувийн хэвшил бий болгохын тулд үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх,
- Харилцан үр ашигтай түншлэл, хамтарсан үйлдвэр эрхлэхэд гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах,
- Баялаг бүтээхэд чиглэсэн Судалгаа-хөгжил, инновацийн үйл ажиллагааг өргөжүүлэх,
- Үндэсний хөгжлийн зорилгод хүрэхэд чиглүүлэн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.

Орон нутгийн түвшинд, муж, орон нутгийн төлөвлөгөөний төслийг хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл оролцсон зөвлөлдөх уулзалтаар хэлэлцүүлж, санал зөвлөгөө авсан. Энэ нь мужийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад мэдээлэл өгч, хувь нэмэр оруулсан. Ийм зөвлөлдөх уулзалтыг заавал зохион байгуулж байхыг 1976 оны Хот ба улсын төлөвлөлтийн хуулиар (2001 нэмэлт өөрчлөлт орсон) зааж өгсөн байдаг. Мөн дүүрэг, хороод, тосгоны түвшинд зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж, тухайн түвшинд хэрэгжүүлэх төсөлд иргэдийн санал зөвлөгөөг авдаг.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: 2030 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ МАЛАЙЗ УЛСЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТӨНД НЭГТГЭН ТУСГАХ НЬ

Энэ хэсэгт 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг Малайз улс хөгжлийн төлөвлөлтөндөө хэрхэн яаж нэгтгэн авч үзсэн талаар танилцуулна. Мөн хөгжлийн төлөвлөлт хийх явцад ТХЗ-ыг Таван жилийн хөгжлийн төлөвлөгөөнд хэрхэн шигтгэн тусгасан тухай өгүүлнэ.

ТХЗ/2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлал ба төлөвлөлт

Энэ хэсэгт тус улсаас тогтвортой хөгжлийг дэмжихийн төлөө гаргасан хүчин чармайлт, мөн хүрсэн ололт амжилт, гарсан сорилт бэрхшээлийн талаар өгүүлнэ.

МХЗ ба Тогтвортой хөгжил

Байгаль орчныг хамгаалах талаар Малайз улсын гаргасан эхэн үеийн хүчин чармайлтад гол байр эзэлдэг нэг ажил нь Байгаль орчны чанарын тухай хууль (БОЧХ) юм. 1974 онд батлагдсан энэ хуулиар бохирдлоос урьдчилан сэргийлэх, аль болох багасгах, бохирдлын түвшинг зохицуулах зорилго тавсан. 1975 онд 3 дугаар Таван жилийн төлөвлөгөөний хүрээнд Байгаль орчны газрыг (БОГ) Шинжлэх ухаан, технологи, байгаль орчны яаманд байгуулсан. Тус хуулийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхийн зэрэгцээ БОГ нь Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх гарын авлагыг боловсруулж 1987 гаргасан. Энэ гарын авлагад Малайз улсад шинээр хэрэгжих төсөл, бүтээн байгуулалтын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хэрхэн хийх тухай заавар өгсөн.

Тэр жилдээ Байгаль орчны чанарын тухай хуулийн (БОЧХ) хүрээнд Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх тухай тушаал гарсан нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэ нь ялангуяа том хэмжээний төслүүд (ойролцоогоор 50-с дээш га талбайг эзлэх) заавал Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ) хийлгэж байж, БОГ-аас хэрэгжүүлэх зөвшөөрөл авна гэсэн үг юм. Гэвч жижиг хэмжээний боловч байгаль орчинд хор хөнөөл учруулах эрсдэлтэй төсөл БОНУ хийлгэлгүй өнгөрдөг. Иймээс хөгжлийн бүх төсөл БОНУ хийлгэн батламж авсан байхаар журамлах шаардлагатай.

Өмнө дурдсанчлан, 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлал батлагдахаас өмнө Малайз улс 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөгөө (2016-2020) боловсруулчихсан байсан. Гэхдээ түүнд МХЗ-ыг харгалзан үзэж, уялдуулан тусгасан байсан. Харин МХЗ-ыг хэрэгжүүлэхэд зориулан тусгайлан хуваарилсан төсөв байгаагүй юм. МХЗ-ын хэрэгжилтийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсвөөс санхүүжүүлж байв.

Хэдий тийм ч МХЗ-ыг үндэсний болон орон нутгийн төлөвлөлтөд нэгтгэн тусгасан байсан. МХЗ нь Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөн дэх стратегийн тулгуур зорилт, салбарын стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход нэг чиг болж өгч байв (Хавсралт 1).

ТХЗ-ыг хөгжлийн төлөвлөлтдөө нэгтгэн авч үзэх зорилгоор тусгайлан гаргасан төлөвлөлтийн бүтцээс ялгаатай нь МХЗ-ыг хэрэгжүүлэхэд зориулсан тусгайлсан бүтэц байгаагүй билээ. Харин төлөвлөлтийн одоогийн бүтцэд тэдгээрийг заавал нэгтгэн авч үзэхээр зохион байгуулсан байна.

21 дүгээр зууны хөгжлийн зорилго

21 дүгээр зууны хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд Таван жилийн хөгжлийн төлөвлөгөөнд шигтгэн тусгах замаар тус улсад тогтвортой хөгжлийг цогцлоох зорилгоор Малайз улс дахь НҮБ-ын байгууллагууд Малайзын Засгийн газартай хамтран ажиллаж ирсэн. 21-р зууны Хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх санаачилгыг холбооны улсын, муж, орон нутгийн захиргаад, төрийн болон төрийн бус байгууллагууд идэвхтэй хэрэгжүүлж ирсэн. Эдгээр байгууллага тогтвортой хөгжлийн асуудлыг онцлон сурталчилж, байгаль орчныг хамгаалах талаар олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулахын тулд байгаль орчны боловсрол иргэдэд олгосон.

Орон сууц, орон нутгийн захиргааны яам нь ЭЗТГ-тай хамтран 21-р зууны Хөгжлийн зорилгыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг хариуцаж ажилласан нэг байгууллага юм. Орон нутагт уг ажлыг түршин хэрэгжүүлэхээр 4 газрыг сонгосон. Эдгээр түршилтын төслийг олон нийтийн оролцоотойгоор, доороос дээш чиглэсэн арга барилаар хэрэгжүүлэн, ялангуяа олон нийт, тосгоны иргэд, ТББ-уудыг үйл ажиллагаандаа татан оролцуулсан. Эдгээр түршилын төслийн зорилго нь нутгийн иргэдэд тогтвортой хөгжлийн асуудлыг ойлгуулах, улмаар байгаль орчноо хадгалах, хамгаалах боловсрол, мэдлэг олгох явдал байв.

Малайз улс дахь Даян дэлхийн Байгаль хамгаалах сан ТББ нь залуучуудын дунд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг сурталчлах зорилгоор Эко-сургууль хөтөлбөр хэрэгжүүлсэн.

ТХЗ/2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг төлөвлөлтөнд нэгтгэн тусгаж буй байдал

Малайз улс 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөгөө (2016-2020) боловсруулсны дараа 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлал батлагдсан тул энэ хоёр баримт бичгийг зориуд үялдуулсан зүйл байхгүй. Гэвч Засгийн газар нэгэнт уг үзэл баримтлалыг биелүүлэх амлалт авсан тул Таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд 2017 оны жилийн төсвийг боловсруулахдаа түүнийг төслийн тэргүүлэх чиглэл тогтоох нэг үндэслэл болгон ашигласан.

МХЗ-ыг тэргүүлэх чиглэл тогтооход зориуд харгалзан үзэж байсан, харин ТХЗ нь 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн чиг хандлага, цааш цаашдын төлөвлөгөө боловсруулахад ихээхэн нөлөө үзүүлэхээр байна. Тухайлбал, ТХЗ нь ЭЗТГ-ын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд орж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох гол үндэслэл болно. 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөн дэх “Тэгш шударга нийгмийг байгуулахын тулд хэн нэгнийг орхигдуулахгүй байх” гэсэн стратегийн тулгуур зорилтын хүрээнд эхлэл тавигдаад байна.

2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх засаглалын бүтэц, замын зураг

ТХЗ-ын семинар зохион байгуулагдаж, ТХЗ-ыг улсынхаа 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөн дэх зорилтуудтай хэрхэн яаж үялдуулах талаар тодорхой ажил хийгдэж эхлээд байна. Тэгш шударга нийгмийн байгуулахын тулд хэн нэгнийг орхигдуулахгүй байх Стратегийн тулгуур зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахын тулд холбогдох яамдын дунд 2016 оны эхээр болон сүүлээр хоёр удаа семинар зохион байгуулсан. Энэ үеэр яамдын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хамаатай ТХЗ-ыг нь тодорхой тусгуулах зорилгоор ЭЗТГ, Сангийн яамнаас НҮБ-ын ТХЗ-ын талаар яамдын ажилтнуудад тайлбарлаж, хэлэлцүүлсэн.

Хэрэгжүүлэх бүтэц

Кабинетын хурлаар ТХЗ-ыг хэрэгжүүлэх бүтцийг баталсан. Ерөнхий сайдын шууд удирдлага дор ТХЗ-ын Зөвлөл байгуулагдсан. Энэ зөвлөл нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх чиглэл, гол гол үе шатыг тодорхойлох үүрэгтэй. Зөвлөл НҮБ-ын Тогтвортой хөгжлийн асуудлаарх Дээд хэмжээний Улс төрийн чуулганд тайлагнана. **Зураг 8-д** хөгжлийн төлөвлөлтөнд ТХЗ-ыг нэгтгэн тусгаж хэрэгжүүлэх засаглалын бүтцийг үзүүлээ.

Зураг 8: Хөгжлийн төлөвлөлтөнд ТХЗ-ыг нэгтгэн тусгаж, хэрэгжүүлэх засаглалын бүтэц



ТХЗ-ын Үндэсний зөвлөлд ЭЗТГ-ын Ерөнхий захирлын тэргүүлдэг Удирдах хороо дэмжлэг үзүүлж ажиллана. Тус Удирдах хорооны үүрэг нь ТХЗ-ыг төлөвлөлтөндөө нэгтгэн тусгаж хэрэгжүүлэх ТХЗ-ын Замын зураг боловсруулж, зорилт тус бүрийн хүрэх ёстой түвшин аль шатандаа байгаад явцын хяналт тавин, тулгарч буй асуудлыг илрүүлэн, ТХЗ-ын Үндэсний зөвлөлд тайлагнах явдал юм.

Өмнө нь салбарын тэргүүлэх чиглэл, салбар хоорондын тэргүүлэх чиглэл, компромисс буюу харилцан буулт шийдвэр нь янз бүрийн салбарт хамаарах төслүүдийг батлах явцад гардаг байсан. Уг шийдвэрийг салбарын тэргүүнүүдийн үүлзалтаас гаргах бөгөөд тэр үүлзалт дээр салбарынхаа төслийг дэмжүүлэх өрсөлдөөн явагддаг байв. Энэ чухал хэлэлцүүлгийг ЭЗТГ-ын дээд удирдлага хөндлөнгийн байр сууринаас зохицуулан явуулдаг байв. Ийм аргаар тэргүүлэх чиглэл, харилцан буулт хийх шийдвэр гаргаж байсан нь тогтсон механизм байхгүй байсныг илэрхийлнэ. Тэргүүлэх чиглэл, харилцан буулт хийх зэргийг шийдвэрлэх томъёо, хүрээ гэж байхгүй. ЭЗТГ-ын төсөв хянагч мэргэжилтнүүд, дээд удирдлага нь хуримтлуулсан туршлага, мэдлэгтээ тулгуурлан, нэгтгэсэн шалгуур үзүүлэлтэд (х.26-27) үндэслэн, хөгжлийн тэргүүлэх чиглэл, харилцан буулт хийх тухай шийдвэр гаргана.

ЭЗТГ-ын Ерөнхий захирлын удирддаг ТХЗ-ын Удирдах хороо нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх засаглалын бүтцэд орж байгаа тул тэргүүлэх чиглэл, харилцан буулт хийх зохицуулалтыг ч энэ түвшинд шийддэг болох байх гэж үзэж байна. Учир нь 4 кластер бүхий Ажлын хороод (дор дурдсан) хөтөлбөр, төслийн талаарх зөвлөмжөө мөн Удирдах хороонд ирүүлнэ.

ТХЗ-ыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэн тусгаж хэрэгжүүлэх Замын зурагт дараах асуудлыг авч үзнэ. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн 17 зорилго тус бүрээр хүрэх ёстой түвшинг биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх арга зам, үр дүнг зураглан тодорхойлох,
- Байгууллагын бүтэц, мэдлэг чадварыг хэрхэн ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх шаардлагатайг судлан, цаашид засгийн газрын байгууллагуудын чадавх бэхжүүлэх ямар ажил хийх шаардлагатайг тодорхойлон баримтжуулах,
- Нөлөөллийн ажил, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах, үндэсний портал бий болгох гэх мэтээр ТХЗ-той холбоотой мэдээлэл, харилцааны хүрээг нарийвчлан тогтоох. 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалын талаар олон нийтэд ойлголт өгөх, мөн түүнийг хэрэгжүүлэхэд засгийн газар ямар үүрэг гүйцэтгэх шаардлагатай талаар үндэсний хэмжээний хоёр семинарыг 2016 оны 2, 11 дүгээр сард Мазайз улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан. Цаашид ийм семинар үргэлжлүүлэх хийхээр төлөвлөж байна.

ТХЗ-ыг хэрэгжүүлэх Замын зураг боловсруулах ажлыг дараах хуваарийн дагуу хийнэ. Үүнд:

1. Нэгдүгээр үе шатанд (2016-2020) 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөтэйгөө уялдуулан ТХЗ-ыг ач холбогдлоор нь эрэмбэлнэ. Ингэхдээ МХЗ-уудыг хэрэгжүүлэх явцад олсон амжилт, хүрсэн түвшинд суурилах бөгөөд одоо байгаа мэдээлэл, тэдгээрийн олдоц, хүртээмж ямар байгааг тогтооно. 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлал батлагдсантай холбогдуулан, 11 дүгээр таван жилийн төлөвлөгөөнд өөрчлөлт ороогүй, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх жил бүрийн хөгжлийн төсөв боловсруулах явцад ТХЗ-ын тэргүүлэх чиглэлийг харгалзан үзэж байна.

Нэгдүгээр үе шатны ажлын хүрээнд ЭЗТГ нь бүх яамдаас өөрт хамаарах ТХЗ, хүрэх ёстой түвшинг судалж, дараах мэдээллийг бэлтгэн ирүүлэхийг үүрэг болгосон. Үүнд:

- ТХЗ-ыг хэрэгжүүлэхээр одоо хийгдэж буй ажил. Яамд яг одоо ямар түвшинд байгаа, чухам юу хийсэн, юу хийгдээд явж байгаагаа тодорхойлох,
- ТХЗ-ын зорилтот түвшинд хүрэхэд хаана, ямар хоцрогдол, бэрхшээлтэй ямар асуудал байна (ямар ажил хийгдэлгүй орхигдож байгаа, ойрын ирээдүйд өөр юу хийх шаардлагатай байгаа гэх мэт)
- ТХЗ-ын зорилтот түвшинд 2030 онд гэхэд хүрсэн байхын тулд эдгээр хоцрогдол, бэрхшээлийг даван туулах зорилгоор 2020 он хүртэлх хугацаанд хийх ёстой ажил, арга зам, санаачилгын жагсаалт.

Ийм мэдээллийг хүлээн авмагц ЭЗТГ нь ТХЗ, шалгуур үзүүлэлт тус бүрээр нэгтгэнэ. Улмаар холбогдох стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн явцад гарч буй асуудлыг ажлын хороодоор хэлэлцүүлнэ. Хороод өөрт хамаарах ТХЗ-той холбоотой тэргүүлэх чиглэл, хаана тохируулга хийх талаар өөрийн түвшинд хэлэлцэж, арга хэмжээ авна.

2. Хоёрдугаар үе шатанд (2020-2025) 2020 оноос хойшхи зорилго, зорилтод анхаарлаа хандуулна.

3. Гуравдугаар үе шатанд (2025-2030) хэрэгжүүлж амжаагүй зорилгуудыг Малайз улсын хэрэгжүүлэн биелүүлэх чадавх, дэлхий нийтийн өмнө хүлээх үүргийн хүрээнд шийдвэрлэнэ.

ТХЗ-ыг хэрэгжүүлэх Замын зураг бэлтгэх ажлын зардлыг ЭЗТГ-ын жилийн төсвөөс гаргана. Энэ нь жилийн батлагдсан төсвөөс гадуур төсвийн нэмэлт хуваарилалт байхгүй гэсэн үг. Тиймээс ЭЗТГ байгууллагынхаа төсвийн хүрээнд уг Замын зургийг бэлтгэх зардлыг гаргах хэрэгтэй болно. Үүний нэгэн адил, ТХЗ-тай холбоотой төслийн санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан хөгжлийн төлөвлөгөөний төсөвтөө багтаан зохицуулах хэрэгтэй болоод байна. Зарим холбогдох төслийг хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр санхүүжүүлнэ. Харин эдгээр төслийн хэрэгжилтэнд ЭЗТГ-аас ТХЗ-ыг хэрэгжүүлэх засаглалын бүтцийн хүрээнд, Ажлын хороодоороо дамжуулан хяналт тавина.

Ажлын хороод

ТХЗ-ын Удирдах хорооны дэргэд Ажлын хороод байгуулагдсан. Тэдний ажлын даалгаварт ТХЗ зорилго тус бүрийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, холбогдох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, улмаар хийж буй ажлын явцаа Удирдах хороонд тогтмол тайлагнах зэрэг ажил орсон.

Дараах 5 Ажлын хороо байгуулж, ТХЗ-ыг хуваарилан хариуцуулсан. Үүнд:

1. Хүртээмж оролцооны асуудлаарх Ажлын хороо. Энэ хэсэг дараах зорилгыг хариуцана. Зорилго 1: Ядуурлыг арилгах; Зорилго 2: Өлсгөлөнг зогсоох; Зорилго 5: Жендэрийн тэгш байдал; Зорилго 10: Тэгш бус байдлыг багасгах
2. Аж байдлын асуудлаарх Ажлын хороо дараах зорилгыг хариуцана. Зорилго 3: Эрүүл мэнд, аж байдал; Зорилго 16: Энх тайван, шударга ёс, хүчирхэг институцууд
3. Хүмүүн капиталын Ажлын хороо дараах зорилгыг хариуцана. Зорилго 4: Чанартай боловсрол
4. Байгаль орчин, байгалийн нөөцийн Ажлын хороо дараах зорилгыг хариуцана. Зорилго 6: Үндны ус, ариун цэврийн байгууламж; Зорилго 7: Хямд төсөр, цэвэр эрчим хүч; Зорилго 12: Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл; Зорилго 13: Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах; Зорилго 14: Далай тэнгисийн нөөцийг хамгаалах; Зорилго 15: Хуурай газрын экосистемийг хамгаалах
5. Эдийн засгийн өсөлтийн Ажлын хороо дараах зорилгыг хариуцана. Зорилго 8: Зохистой ажлын байр, Эдийн засгийн өсөлт; Зорилго 9: Үйлдвэрлэл, инновац, дэд бүтэц; Зорилго 11: Ээлтэй хот, иргэдийн оролцоо; 17: ТХЗ-г хэрэгжүүлэхийн төлөөх түншлэл.

ТХЗ-ыг 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний стратегийн тулгуур зорилтуудтай хэрхэн нэгтгэж, хэрэгжүүлэх зураглал одоо хийгдэж байна. ЭЗТГ нь Ажлын хороодод шаардлагатай дэмжлэг үзүүлэн удирдах гол байгууллага нь байна. Эдгээр Ажлын хороодод төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл орно.

Хөгжлийн төлөвлөлтөд ТХЗ-ыг зориуд нэгтгэн тусгаж, хэрэгжүүлэх ажил эхлэлийн шатандаа байна. Цаашид салбар хоорондын зохицуулалтыг анхаарч шийдвэрлэх бөгөөд энэ нь 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх гол цөм юм. Тухайлбал, эрүүл мэнд, байгаль орчны асуудал өөр хоорондоо хамааралтай, тиймээс хэрэгжилтийг мөн уялдаатай авч үзнэ. Уг зохицуулалт, уялдааг ТХЗ-ыг хэрэгжүүлэх шат дараалсан тогтолцооны дээд түвшинд байрлаж, уг механизмыг удирдаж байгаа тул Удирдах зөвлөл, Удирдах хорооны түвшинд хийнэ.

Түүнчлэн, ЭЗТГ бол ТХЗ-ыг хэрэгжүүлэх бүтцийг хөдөлгөгч хүч, мөн Ажлын хороодын нарийн бичгийн албаны үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь ч Ажлын хороод хоорондын уялдаа, зохицуулалтыг хангахад дөхөм болж өгнө. Ер нь, төлөвлөлтийн одоогийн тогтолцоонд ЭЗТГ салбар хоорондын уялдаа, зохицуулалтыг хийж байгаа бөгөөд ингэхдээ салбар хоорондын тэргүүлэх чиглэл тогтоох хэлэлцүүлгээр дамжуулан гүйцэтгэж байгаа билээ.

Мөн ЭЗТГ-аас үндэсний шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, түүнд хүрсэн эсэхийг хянах мэдээллийн санг байгуулах бөгөөд энэ ажлыг мөн л Ажлын хороодоор дамжуулан гүйцэтгэнэ. Эдгээр мэдээллийн санг одоо хэрэглэж буй мэдээллийн сантай нэгтгэнэ.

Ажлын хороодоос гарах зөвлөмжийг 12 дугаар Таван жилийн төлөвлөгөө (2021-2025) боловсруулахад ашиглана. Уг төлөвлөгөөг боловсруулах ажил 2017 онд, одоо хэрэгжиж буй төлөвлөгөөний дунд хугацааны хяналттай зэрэгцэн эхэлнэ.

Нийгэм бүхлээрээ оролцохыг дэмжсэн арга барилыг баримтлан, ТХЗ-ыг хэрэгжүүлэх Удирдах зөвлөл, хороодод хувийн хэвшил, төр засаг, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулж байна.

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫГ НЭГТГЭН ТУСГАЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ГАРСАН СУРГАМЖ, ЗӨВЛӨМЖ

Тус улсын төлөвлөлтийн тогтолцоо, хэрэгжүүлэх арга механизм сүүлийн гуч гаруй жилийн турш хэрэглэгдэж байна. Энэ хооронд бодлого солигдон шинэчлэгдэж байсан ч гол агуулга, нийгэм-эдийн засгийн хөгжил, эдийн засгийн тэгш хүртээмж өсөлт зэрэг нь хэвээр үргэлжилж ирсэн. Төлөвлөлтийг үйл явцыг улс төрийн дээд удирдлага чиглүүлэн залж, хөгжлийн Алсын хараа, стратегийн тулгуур зорилт, таван жилийн төлөвлөгөөнд тусган, бодлого солигдох үед түүний залгамж чанарыг хадгалан авч ирсэн. Харин төрийн захиргааны удирдлага түүнийг үндэсний болон мужийн түвшинд бодит ажил болгон хувиргаж иржээ.

Төлөвлөлт нь макро, микро түвшний аль алинд нэгдмэл байдлаар явагддаг. Макро эдийн засгийн хүрээ (Зураг 2) нь яам, агентлаг, мужийн хөтөлбөр, төсөлд хөгжлийн төлөвлөлтийн зорилго заавал тусч, хэрэгжиж байхад зориулагдсан механизм болж өгдөг. Уг механизмын дагуу, зөвхөн үндэсний хөгжлийн зорилго, стратеги, гүйцэтгэлийн гол үзүүлэлтэд хүрэхэд хувь нэмэр оруулах төсөл л санхүүжилт авдаг.

Төлөвлөлтийн явцад макро түвшний хоёр жилийн төлөвлөгөөний төсвийн дээд хязгаарыг тухайн жилд хэрэгжих төслийн төсөвтэй тулган тэнцүүлнэ. Салбар хоорондын болон төсөл хоорондын харилцан буулт хийх тохируулгыг ЭЗТГ-ын удирдлага, салбарын сайд нарын бүрэлдхүүнтэй салбарын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Таван жилийн төлөвлөгөөний дунд хугацааны үнэлгээ нь төлөвлөгөөний үлдсэн хугацаанд юунд анхаарах шаардлагатай тухай мэдээлэл өгнө. Мөн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хэрэгжилт төлөвлөсний дагуу явагдаж байгаа эсэхийг хянах бас нэг механизм болж өгдөг.

Төлөвлөлтийн механизм удаан хугацаанд тогтвортой үйлчилж байгаагаас харахад ЭЗТГ, яамд тус тогтсон тогтолцооны дагуу төлөвлөлтөө хийх чадвартай болсон байна. Эдийн засгийн хурдацтай хөгжил нь төлөвлөлтийн механизм хүчтэй байсантай зарим талаар холбоотой. Тиймээс ч хөгжиж буй бусад улс оронд хэрэгтэй нэг жишиг болоод байна.

ХЗГ-аас явуулдаг төслийн хяналт, шинжилгээ нь засгийн газрын гүйцэтгэх чадавх, эдийн засгийн шингээх чадамжийн талаар хэрэгтэй мэдээлэл өгдөг. Мөн ХЗГ, яамдын зохион байгуулдаг төслөөс үзүүлсэн нөлөөний судалгаа нь стратеги, хөтөлбөрийнхээ үр ашгийг дээшлүүлэх, стратегийн тулгуур зорилтууд руу чиглүүлэхэд тусалдаг. Ийм судалгаа нь дараа дараагийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхдээ илүү сайн арга барил нэвтрүүлэхэд тус болдог.

Төлөвлөгөөнд 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг нэгтгэн тусгах ажил 2017 оны төсвийн төслийг боловсруулах үеэс эхэлсэн. Төлөвлөгөө нэгэнт хэрэгжээд эхэлчихсэн байсан тул үндсэндээ ТХЗ-ыг төлөвлөгөөндөө тааруулж оруулсан гэсэн үг. Ингэж нийцүүлэхэд хялбар байсан, учир нь тэргүүлэх чиглэл, зорилтууд ба ТХЗ олон талаар давхцаж байв. Гэхдээ л Малайз улс нэгэнт ТХЗ-ыг хэрэгжүүлэх амлалт авсан тул төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх явцдаа зарим тэргүүлэх чиглэлээ өөрчилнө.

ТХЗ-ын хэрэгжилтийг Ерөнхий сайдын тэргүүлсэн өндөр түвшний ТХЗ-ын Зөвлөл удирдаж байгаа тул хэрэгжүүлэх тогтолцоо ч эрх мэдэл өндөртэй, Ажлын хороодын санал, тус Зөвлөлийн шийдвэр хөгжлийн

төлөвлөлтийн бүхий л үйл явцад нэгтгэгдэх бүрэн боломжтой байдаг. Төлөвлөлтийн тогтолцоо, үйл явцыг ч Ерөнхий сайд дээд түвшинд нь удирдан чиглүүлж байдаг тул ийнхүү нэгтгэх боломжтой юм.

ЭЗТГ-ын Ерөнхий захирал нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх Удирдах хороог даргална. Ерөнхий захирал нь ийнхүү ЭЗТГ-ын дарга, тус Удирдах хорооны дарга хэмээх давхар үүрэг гүйцэтгэж байгаа тул төлөвлөлтөд ТХЗ-ыг бодитой тусгахад тохиромжтой.

ТХЗ-ыг хэрэгжүүлэх ажлын эхэн үеэс л ЭЗТГ нь төр, хувийн хэвшил, ТББ, иргэний нийгмийн төлөөллийг Ажлын хороодод оролцуулахыг эрмэлзэж байсан. ТББ-ууд ч холбогдох ТХЗ-ыг хэрэгжүүлэх чиглэлээр хийж байгаа ажлаа ЭЗТГ-т танилцуулан хамтран ажиллаж байна. Энэ нь нөгөө талаар иргэдийн хүсэл сонирхол, дуу хоолойг мэдэрч ажиллах боломж олгодог.

Хөгжлийн төлөвлөлтөд хөгжлийн зорилтуудыг нэгтгэн тусгах тусгай жор гэж мэдээж байхгүй. Улс орнууд нийгэм, эдийн засаг, санхүүгийн бүтэц, хөгжлийн түвшингээрээ ялгаатай. Тиймээс тэд өөрийн онцлог нөхцөл байдалд тохирсон бодлогын хариу арга хэмжээ авах ёстой. Малайз улс хөгжлийн төлөвлөлтөндөө ТХЗ-ыг нэгтгэн тусгахад гарсан сургамж, зарим зөвлөмжийг доор танилцуулав.

- Засгийн газар бол улс орныхоо хөгжлийн ирээдүйн чиглэлийг тогтоох хууль ёсны үүрэг хүлээж байдаг. Гэхдээ энэ нь эдийн засагт шууд гардан оролцож, хувийн хэвшлээ шахна гэсэн үг биш. Ийм хязгаар тавьж байж л нийтийн бараа буюу олон нийтэд бүгдэд нь хүртээлтэй үйлчилгээ, нийгмийн хамгаалал зэрэгт зориулан төсвийн хөрөнгийг хадгалах боломжтой болно. Засгийн газрын гол анхаарлаа хандуулах зүйл нь макро-эдийн засгийн ерөнхий хүрээ тогтоох, хувийн хэвшлээс нэмүү өртөг бий болгох, өндөр үр нөлөөтэй төслүүдэд хөрөнгө оруулалт түлхүү хийхийг урамшуулан дэмжсэн бодлого юм. Мөн бизнесийг дэмжсэн экосистем бий болгон, биет болон нийгмийн зохистой, үр ашигтай дэд бүтцээр хангах хэрэгтэй. Экспортын өсөлтийг дэмжихийн тулд олон улсын маркетингийн сүлжээнд сайн нэгдэн орох хэрэгтэй. Эхэндээ Малайз улсын Засгийн газар нь эдийн засгийн өсөлтийг хөдөлгөгч хүч байсан бол одоо хувийн хэвшилд голлон түшиглэж, өөрөө дэмжигчийн үүрэг гүйцэтгэж байна.
- Заримдаа хувийн хэвшил бүтцийн ийм өөрчлөлтийг удирдах чадвар сул байж болно. Энэ үед Засгийн газар удирдлага, санхүүжилтээр хангах шаардлагатай. Төсвийн бодлогоор, ялангуяа хувийн хэвшлийнхний эдийн засгийг хөтлөн авч явах чадавхаа дээшлүүлэхэд нь чиглэсэн хөшүүрэг бий болговол тустай. Зарим тохиолдолд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхдээ тогтвортой хөгжил рүү хандуулан дэмжих шаардлагатай.
- ТХЗ-ыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэхэд цогц бөгөөд нягт чамбай төлөвлөлтийн хүрээ шаардагдана. Уг хүрээ буюу тогтолцооны дээд үзүүрт үндэсний хөгжлийн Алсын хараа, ТХЗ-ыг агуулсан стратегийн тулгуур зорилтууд байна. Энэ Алсын хараа, стратегийн тулгуур зорилтуудыг доош яам, газрууд руу хуваарилан буулгахдаа ТХЗ-ыг гээгдүүлж болохгүй. Үе шат доошлох тусам стратегийн тулгуур зорилт нь нарийвчлагдан, гарах үр дүн нь тодорхой болж байх ёстой. Ялангуяа доод түвшиндээ хэрэгжүүлэх арга зам, үр дүнг хэрхэн хэмжихээ заасан байх ёстой.
- Үндэсний түвшний бодлогод байгаль орчныг хамгаалах тэргүүлэх чиглэл тодорхой тусч, тогтвортой хөгжлийг үндсэн зорилго болгон заадаг ч орон нутагт хэрэгжилт эхлэх үед тогтвортой хөгжлийн ойлголт саармагжиж, сулрах хандлага гардаг. Тиймээс яг газар дээрээ хэрэгжилт үр дүнтэй байхын тулд төв орон нутгийн засгийн газрын хооронд ажлын уялдаа, нийцэл сайн байх шаардлагатай. ТХЗ-ын хэрэгжилтийг төлөвлөсний дагуу хангах нэг арга бол орон нутагт ямар төсөл хэрэгжүүлэхийг сонгохдоо тэрхүү уялдаа, нийцэлд хатуу захируулах явдал юм.
- Төлөвлөлтийн энэ тогтолцоог хүчтэй байгууллагууд л хөдөлгөнө. Ерөнхий сайдад тайлагнадаг төлөвлөлтийн нэгж буюу улс төрийн удирдлага бол энэ тогтолцоог нэгдмэл ажиллуулах гол нөхцөл юм. Мөн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадвартай институцууд байх ёстой.
- Хөгжлийн төлөвлөлт үр дүнтэй байхын тулд тогтвортой хөгжлийг хангах хууль, бодлого нь залгамж чанартай байх ёстой. Ойлголт, нэр томъёо өөрчлөгдөж болох ч бодлогын зорилт өөрчлөгдөх нь ховор. Нэг бодлого хэрэгжиж дуусахад дараагийн бодлого нь өмнөх зорилгоо үгүйсгэдэг байж болохгүй. Өмнөх бодлогын зорилт нь шинэ бодлогод уламжлагдан хадгалагдаж, улам бүр бэхжиж байх ёстой. Жишээлбэл, 1971 оны Эдийн засгийн шинэ бодлогын хэрэгжих хугацаа 1990 онд дуусгавар болоход

Үндэсний хөгжлийн бодлого шинээр гарч, ядуурлыг арилгах, орлогын тэгш хуваарилалт бүхий эдийн засгийн хөгжлийг хангах гэсэн зорилтыг нь үргэлжлүүлэн хадгалж авч явсан.

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжид байнгын өөрчлөлт хийх шаардлага гарч байдаг. Британы ноёрхлын үеийн хуучирсан хууль тогтоомжийг шинэчилж, ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд зориулан өөрчлөх шаардлагатай.
- Малайз улсад холбооны болон мужийн түвшний аль алинд нь хууль тогтоох ажиллагаа явагддаг тул дүрэм, журам өөр хоорондоо зөрчилгүй, уялдаа, цэгцтэй байх шаардлагатай. Ингэж байж л Засгийн газар бүхэлдээ ТХЗ-ыг хэрэгжүүлэх нэгдмэл ойлголт, арга барилд хүрнэ. Ингэж уялдуулж цэгцлэхийн тулд холбооны түвшинд болон мужид олгосон хууль тогтоох чиг үүргийн хуваарилалтыг эргэн харах шаардлагатай. Тухайлбал, ойн нөөц, цэцэрлэгт хүрээлэн, мод бэлтгэл бол мужийн харъяалан шийддэг асуудал юм. Гэтэл ан амьтад, ойн менежментийг Холбооны засгийн газар хариуцдаг. Хууль тогтоомжийн зохицуулалт нэг мөр уялдаатай болж, системчлэгдсэнээр ТХЗ-ыг харилцан уялдаатай хэрэгжүүлж урагшлуулахад ихээхэн түс нэмэр болно.
- Орчин нөхцөл хувиран өөрчлөгдөж байдаг тул төрийн бодлого ч уян хатан, прагматик шинжтэй буюу практикт тулгарч буй асуудлыг шийдэхэд чиглэх ёстой. Иймээс Малайз улсад ч орчин нөхцөл өөрчлөгдөхийн хэрээр түүнд хариу арга хэмжээ авахын тулд төлөвлөлтөнд стратегийн шинэ тулгуур нэмэн баяжуулж ирсэн. Жишээлбэл, Малайз улсын төлөвлөлтөд хөдөө аж ахуйн бодлого тодорхой байр суурь эзэлж ирсэн ч тухайн төлөвлөгөөт хугацааны нөхцөл байдлыг харгалзан, гол анхаарал хандуулах чиглэл нь өөрчлөгдөж иржээ.

Өнгөрсөн жилүүдэд ядуурлыг бууруулахад анхаарлаа хандуулж байсан бол дараа нь ядууралтай тэмцэх стратегиас нэн ядуурлыг устгахад чиглэсэн стратеги болж өөрчлөгдсөн. Харин дараа нь нэгэнт нэн ядуурлыг устгаж чадсан тул одоо харьцангуй ядуурлыг бууруулахад анхаарлаа хандуулж, үүнийг ажлын байр бий болгох, нийгмийн халамжийн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлж байна. Мөн өсөлт, тэгш байдлын төлөөх зорилтод хүрэхийн тулд хүний нөөцийн хөгжилд анхаарлаа төвлөрүүлэх нь нэмэгдэж байна.

- Бодлогын ямар нэг алдаа гаргахгүйн тулд хүчин чармайлт гаргаж, оношоо зөв тогтоох нь нэн чухал. Дижитал эдийн засгийг хөгжүүлэх, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хангамж, нийтийн тээвэр, дэд бүтэц хөгжүүлэх зэрэг асуудлаар авах бодлогын хариу арга хэмжээ нь зохистой бөгөөд цогц байх хэрэгтэй. Нэг салбарт хөрөнгө оруулбал холбогдох бусад салбарт ч хөрөнгө оруулалт хийх ёстой бөгөөд ингэж байж капиталын төслүүд сайн ажиллах боломжтой болно. Тухайлбал, газрын үнэ хямд гээд алслагдсан газарт хямд өртөгтэй орон сууц, эмнэлэг барья гэж бодоход нийтийн тээвэрт хөрөнгө оруулалт хийж байж л тэнд хүн амьдрах, үйлчлүүлэх боломжтой болж, уг хөрөнгө оруулалт ач холбогдолтой болно.
- Аливаа бодлого нь эдийн засгаа тэтгэхэд чиглэж байх ёстой. Төсвийн алдагдлыг бууруулах бодлогын арга хэмжээ нь эдийн засгаа хэт агшаахгүй байх үүднээс тохируулгын арга хэмжээ авах ёстой. Хөгжлийн асуудлыг зөв оношилж чадвал эдийн засагтаа хүнд хохирол учруулахгүйгээр бүтцийн зохицуулалт хийж болно.
- Эдийн засаг өсөхийн хамт үндэсний орлого тэгш хуваарилагдаж байх ёстой. Ингэснээр өсөлт утга учиртай болохын зэрэгцээ улс төр, нийгмийн тогтвортой байдлыг хангадаг.
- ТХЗ-ыг Таван жилийн хөгжлийн төлөвлөгөөгөөр хэрэгжүүлэхэд нийгэм бүхэлдээ нэгдмэл байдлаар оролцох шаардлагатай. ТХЗ-ын төлөөх Малайзын Иргэний нийгмийн холбоо (ИНХ) нь хүний эрхэд тулгуурласан, байгаль орчны ИНБ-ууд, бодлогын судалгааны төв зэргийг нэгтгэсэн бөгөөд ТХЗ-ын талаарх нийгмийн байр суурь, үзэл бодлыг илэрхийлэн ажиллаж байна.
- Төр, хувийн хэвшлийн оролцоотой ийм хамтын арга хэмжээ нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах хязгаарлагдмал хөрөнгө, нөөцийг үр дүнтэй ашиглах боломж олгоно. Хөгжлийн төлөвлөлтөнд ТХЗ-ыг ийнхүү тусгахад улс төр, төрийн захиргааны манлайлал шаардагдана. МИНХ-той хамтран ажиллах албан ёсны механизмыг яам, агентлаг, мөн мужийн түвшинд бий болгох ёстой. Орон нутгийн түвшинд ч байгууллага хоорондын хамтын ажиллагаа илүү ойр, нягт болох шаардлагатай.
- Хөрөнгө оруулалтын төслүүдийг сонгоход улс төрийн оролцоо хэт их бол ТХЗ-ыг төлөвлөгөөнд нэгтгэн тусгах ажил үгүйсгэгдэж, төсвийн зарцуулалт үр дүнгүй болно.

- Улс орны түвшинд ТХЗ бүрийг хэрэгжүүлэх арга зам, хүрсэн байх ёстой түвшинг тодорхойлсон Замын зураг гаргах замаар хэрэгжихүйц болгон, ямар арга хэмжээ авахыг тодорхой заах шаардлагатай. Ингэснээр ТХЗ дотроо задран, хэмжигдэхүйц болж, хэрэгжилтэд нь хяналт тавьж, тайлагнах боломжтой болно. Одоо үйлчилж буй төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалтад ТХЗ-ын хэрэгжилтийг хариуцсан нэмэлт бүтцийг суулгаж өгөх шаардлагатай.
- ТХЗ-ын 169 зорилтыг биелүүлэхэд гарч буй ахицыг хэмжих, зохих бодлого, хөтөлбөр боловсруулахад үндэслэл болох тоо баримт хэрэгтэй. Малайз улсад, ялангуяа, муж, орон нутгийн түвшинд ядуурлыг арилгах, жендэр, үндэс угсаа болон байгаль орчны бодлогын арга хэмжээ авахад задаргаатай тоо мэдээлэл байнга дутагдалтай байж ирсэн. Малайз улс 2016 оны эцэс гэхэд гаргах шаардлагатай нийт 230 шалгуур үзүүлэлтийн 40 орчим хувийг бүрэн гаргасан, 30 орчим хувийг бүрэн бус гаргасан, цаашид сайжруулах шаардлагатай байгаа бол 13 хувийг нь шинээр боловсруулна. ТХЗ-ын хэрэгжилтийн бүрэн дүр зургийг илэрхийлэхийн тулд тоо мэдээлэл цуглуулах уламжлалт аргаас гадна шинэ арга, технологи ашиглах хэрэгтэй байна.
- 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд байгаа хөрөнгө нөөцөөрөө эсвэл түүнээс ч бага санхүүжилтээр илүү үр дүнд хүрэхийн тулд хөрөнгө нөөцөө үр дүнтэй зарцуулах шаардлагатай. Малайз улсын Цэнхэр-далай стратеги нь өндөр үр нөлөө бүхий төслүүдийг бага зардлаар хэрэгжүүлэх шинэлэг механизм бий болгохыг зорьж байна.
- Түүнчлэн 2030 он хүртэлх Хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, төслүүдийг тодорхойлохын тулд оролцогч талуудтай, тухайлбал, сайд, төр засгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцсон зөвлөлдөх уулзалтыг өргөн хүрээнд зохион байгуулж байх шаардлагатай. Хамтрах чадвартай байх эсэхээс хэрэгжилтийн чанар шалтгаална. ТХЗ-ын хэрэгжилтийг дэмжих, санал авах үүднээс холбогдох Ажлын хороод дотроо нягт хамтран ажиллах шаардлагатай.
- Ажлын хороодын хийх ажлыг зөвхөн уулзалт хэлэлцүүлгээр хязгаарлаж болохгүй. Тэд бүх салбарын (төр, хувийн хэвшил, иргэний нийгэм зэрэг) төлөөлөл тул санал өгөөд зогсохгүй байр сууриа хамгаалж мэтгэлцэх гэх мэтээр шийдвэр гаргахад бүтээлч, нөлөөтэй оролцож, хөгжлийн үйл явцыг хамтран манлайлж байгаагаа мэдэрч байх ёстой. Ийм ойр нягт түншлэл БХАХ, МАХ, фокус бүлгийн ажлаас илт харагдаж байдаг. 2030 он хүртэлх Хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагааны яг тийм экосистем бүрдүүлэх ёстой. ТХЗ-ын биелэлтийг хангах зөвлөлийн гишүүд өөр өөрсдийн байгууллагын ашиг сонирхлыг төлөөлөх бус хөгжлийг төлөвлөн удирдах нэгдмэл зорилготой хамтран ажиллах ёстой. Иймд төлөвлөлтөд хамтран оролцож буй янз бүрийн гишүүдийн хүлээх үүргийн талаар тодорхой удирдамж гаргах нь зүйтэй.
- Хэрэгжилтийн явцад гарч болзошгүй эрсдлийг сайтар хянаж байх хэрэгтэй. Үүнийг төлөвлөлтийн эхнээс л анхаарах ёстой. Жишээлбэл, бүрэн хэрэгжих өндөр магадлалтай төсөл л батлагддаг байх ёстой. Энэ магадлал нь газраа чөлөөлсөн эсэх, төсөл хэрэгжүүлэх технологи бэлэн эсэх, худалдан авалт нь төсөл батлагдмагц эхлэх боломжтой эсэх зэрэг олон зүйлээс хамаарна. Хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй бусад хүчин зүйлсийг төсөл батлах үедээ бүрэн тооцож байх шаардлагатай.
- Симуляци хийж үзэх, тодорхой хувилбарууд гаргаж үзэх нь ТХЗ-ыг хангахад шаардагдах санхүүжилтийн хэмжээг тооцоход хэрэг болно. Жишээлбэл, ногоон өсөлтийг маш идэвхтэй дэмжих бодлого баримталбал ДНБ-ий өсөлтөд ямар нөлөө үзүүлэх вэ гэх мэт. Иймэрхүү тооцоолол нь хаана ямар буулт, зөвшилцөл хийх буюу хасах, хаана хүчээ нэгтгэн нэмэх хэрэгтэйг тогтооход нэн чухал.
- Хөгжлийн төлөвлөлтөд ТХЗ-ыг нэгтгэн тусгах ажлын онцлогийг харгалзан, төрийн байгууллагуудын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чадварыг сайжруулах нь нэн чухал. Төв, орон нутгийн түвшинд төрийн байгууллагын чадвар сайжруулах ийм ажил нь тусгайлсан сургалт, семинар, төлөвлөлт хийх арга зүйн сургалт, баримт бичиг боловсруулах, харилцааны зэрэг үр чадвар эзэмшүүлэх зэрэг хэлбэртэй байж болно. Мөн төслийн менежмент, тэргүүлэх чиглэл, хугацааны дараалал тогтоох, хүчээ нэгтгэн хамтрах болон нотолгоонд суурилан буулт, зөвшилцөл хийх зэрэг асуудлаар чадавч бэхжүүлэх шаардлагатай. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадварыг мөн дээшлүүлэх шаардлагатай, ингэж байж ТХЗ-ын хэрэгжилт төлөвлөсний дагуу явагдаж байгаа эсэх, хүрэх ёстой үр дүндээ хүрч буй эсэх, мөн ямар нөлөө гарч байгааг тодорхойлох боломжтой болно.

Дүгнэлт

Малайз улсын тогтвортой өсөлт, хурдацтай хөгжлийн гол үндэс нь "сууриа зөв тавьсных" гэж дүгнэж болно. Үүнд хөгжлийн бодлого, хүрээг зохистой тогтоож өгсөн, эдийн засгийн менежмент сайн, хувийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж түүнийг өсөлтийн гол хөдөлгүүр болох нөхцөл бүрдүүлж өгсөн, хүний нөөцийг хөгжүүлж, биет болон институцийн дэд бүтцийг сайн хангасан зэргийг дурдаж болно. Энэ хүрсэн амжилт нь аль нэг бодлогын үр дүн биш харин янз бүрийн цаг хугацаанд хэрэгжиж байсан олон бодлогын хуримтлагдсан үр дүн юм.

Бүтцийн өөрчлөлт хийхэд, ялангуяа хуримтлал, хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогод нөлөөлөхөд Засгийн газар тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Хөгжлийн төлөвлөгчид үр дүнтэй ажилласан нь Малайз улсын хөгжлийн ололт амжилтын гол түлхүүр. Малайз улсын хөгжлийн төлөвлөлт нь хэлэлцэн зөвлөлдөх байдлаар явагддаг тул оролцогч бүх талын ашиг сонирхол тусгалаа олж, бүгд хамтдаа уг төлөвлөгөөг өөрийнхөө төлөвлөгөө гэж хандаж байсан. Энэ нь хөгжлийн төлөвлөгөөнд ТХЗ-ыг нэгтгэн тусгахад шийдвэрлэх нөхцөл байв.

ТХЗ-ыг хүлээн зөвшөөрөх улс төрийн хариу мэдрэмж сайн байлаа. Ерөнхий сайд ТХЗ-ын Удирдах зөвлөлийг тэргүүлэн, Кабинет ТХЗ-ыг хэрэгжүүлэх бүтцийг байгуулаад байна. Кабинет мөн Парламентад өргөн барих хөгжлийн төлөвлөгөөг батлахад оролцоно.

Одоогийн хэрэгжиж буй хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд ТХЗ-ын дийлэнх нь тусгагдсан байгаа тул цаашид хийгдэх бодлогын өөрчлөлт дунд зэрэг байна. Гэвч уг төлөвлөгөө хэрэгжих явцад ТХЗ-д анхаарал хандуулна. ЭЗТГ нь ТХЗ хэрэгжихэд хаана, юу орхигдож байгааг судлан, 12 дугаар Таван жилийн төлөвлөгөө (2021-2015) боловсруулах явцад түүнийг тусган шийдвэрлэнэ. 2017 оны 7 дугаар сард Малайз улс нь төлөвлөгөөнийхөө хэрэгжилтийн явцын тайланг гарган, ололт амжилт, хэрэгжээгүй үлдсэн ажлаа дүгнэн, хэрэгжилтэнд гарч буй доголдлыг арилгах ямар арга хэмжээ авч ажиллаж байгаагаа тайлагнана.

ТХЗ-ын хэрэгжилтийг хариуцах шинэ бүтэц бий болоод байна. Энэ нь хөгжлийн төлөвлөлтийн одоогийн үйл явцад нэмэлт дэмжлэг болно. Ийм шинэ бүтэц байгуулсан нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд зориуд анхаарч байгаагийн илрэл юм. Уг бүтэц нь ТХЗ-ыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэх, хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Цаашдаа ТХЗ нь хөгжлийн төлөвлөлтийн (жилийн төлөвлөгөө, Үндэсний шинэтгэлийн хөтөлбөр 2050, дунд хугацааны үнэлгээ гм) үндсэн, салшгүй нэг хэсэг болж ордог болно. Одоогийн байдлаар төсөв хянах явцад байгууллагуудын ирүүлсэн төсөл, хөтөлбөр нь ТХЗ-ыг биелүүлэхэд чиглэж байгаа эсэхийг авч үздэг болоод байгаа билээ.

Парламент нь олон түмний эрх ашгийг илэрхийлэн хамгаалагч болохын хувьд засаглалын бүтцэд чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Иймд Парламент дотроо ТХЗ-ын хороо байгуулж, ТХЗ-ыг биелүүлэхэд хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбар хоорондын харилцан буулт, зөвшилцөл, хүчээ нэгтгэх зэргийг удирдан чиглүүлэх шаардлагатай. Ийм хэлэлцүүлэг нь цааш цаашдын хөгжлийн төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусгаж, ТХЗ-ыг бататган суулгах ажлыг эрчимжүүлнэ.

Малайз улсын Үндэсний их сургууль, 2017 оны 3 дугаар сарын 20.

Хавсралт 1. Тогтвортой хөгжлийн зорилгууд: Малайзын хөгжлийн төлөвлөлтөд гарсан амжилт ба холбогдох зорилтууд

<p>Зорилго 1. Ядуурлын бүх хэлбэрийг устгах</p>	<p>Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө – Бүлэг 3 – Хүртээмжтэй өсөлтийг дэмжиж тэгш нийгмийг байгуулна</p> <p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөөгийн зам 2009 онд 45,905 км байсан бол 2014 онд 51,262 км болсон • Хөдөөгийн эрчим хүчний хэрэглээ 2009 онд 93% байсан бол 2014 онд 98% болж нэмэгдсэн • 5,737 тосгон “тосгоны утасгүй холбоо” хөтөлбөрт хамрагдсан • Таван бүсийн эдийн засгийн коридор хөтөлбөрт 175 тэрбум МР-ийн хөрөнгө оруулснаар 427,100 ажлын байр бий болсон • Малайзын Аманах Ихтиар, Бизнес эрхлэгчдэд зориулсан Үндэсний эдийн засгийн сангаас 8,6 тэрбум МР-ийн зээлийг 413,278 бизнес эрхлэгч хүртсэн <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> • Д40 хувьд хамрагдаж байсан өрхүүдийн амьжиргаа дээшилж байна • Илүү дэвшилтэт, хүртээмжтэй нийгмийг байгуулж байна • Суурь дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж сайжирч байна • Өсөлтийн хөдөлгүүр болох хөгжлийн коридорыг дэмжиж байна • Бумипутерагийн хүн амын эдийн засагт оролцох оролцоо өргөжиж байна <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <p>ХГҮД (хүрэх ёстой гол үр дүн, анхаарах ёстой чиглэл) 1: Эмзэг бүлгийн айл өрхийг (доод 40%) дунд орлоготой хэсгийн эгнээнд оруулах</p> <p>ХГҮД 2: Бүтээмжит, хөгжингүй нийгэм байгуулах үүднээс олон нийтийг мэдэлжүүлэх,</p> <p>ХГҮД 3: Орон нутгийн иргэдийн аж байдлыг өөд татахын тулд хөдөө орон нутагт эрс өөрчлөлт хийх,</p> <p>ХГҮД 4: Газарзүйн тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс бүс нутгийн хөгжлийн өсөлтийг түргэсгэх,</p> <p>ХГҮД 5: Баялгийн өмчлөлийн нэмэгдүүлэх үүднээс Бумипутера Эдийн засгийн бүлийн боломжийг нэмэгдүүлэх.</p>
<p>Зорилго 2. Өлсгөлөнг зогсоож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, тэжээллэг чанарыг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн тогтвортой өсөлтийг хөхиүлэн дэмжих</p>	<p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 8 - Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 2,4%-иар өсч ДНБ-ний үйлдвэрлэлд 455 тэрбум МР-ийн хувь нэмэр оруулсан <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 8 – Тэргүүлэх чиглэл С Хөдөө аж ахуйг орчин үеийн болгон шинэчлэх <ul style="list-style-type: none"> ○ С1: Фермер, загасчид, жижиг үйлдвэрлэгчдийн бүтээмж, орлогыг нэмэгдүүлэх, мэдээлэл харилцааны технологи, фермерийн технологийг нэвтрүүлэх явдлыг эрчимжүүлэх ○ С2: Залуу газар тариаланчдыг сургах, хөгжүүлэхийг дэмжих, ○ С3: Инститүцийн дэмжлэг, тархаан өргөжүүлэх үйлчилгээг бэхжүүлэх ○ С4: Газар тариалангийн хоршоолол, нийгэмлэгүүдийн чадавх бий болгох, өртгийн сүлжээг дэмжих ○ С5: Зах зээлийн хүртээмж, логистик үйлчилгээг сайжруулах, ○ С6: Газар тариалангийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ○ С7: Үр дүнгийн урамшуулал, гэрчилгээт хөтөлбөрийг эрчимжүүлэх
<p>Зорилго 3. Нийт хүн амыг эрүүл, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах</p>	<p>Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө – Бүлэг 4 Нийт хүн амыг сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах</p> <p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> • 2000-2012 онд Малайз улсын Аж байдлын индекс 25.4 пунктаар сайжирсан • Хүн амын дундаж наслалт 2010 онд 74.1 жил байсан бол 2014 онд 74.8 жил болсон тооцоотой байна. • 2010 онд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 6.7 байсан бол 2014 онд 6.5 болсон. • 2010 онд эмнэлэгийн ор 55,180 байсан бол 2014 онд 58,530 болж нэмэгдсэн. • Ядуу, бага, дунд орлоготой өрхөд зориулсан 102,200 орон сууц барьж дууссан. <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн чанартай үйлчилгээний хүртээмж сайжирч байна • Чанартай, төлбөрийн чадварт тохирсон орон сууцны хүртээмж нэмэгдэж байна • Гудамж талбай, олон нийтийн газруудад амгалан тайван зорчих нөхцөл бүрдүүлсэн • Нийгмийн хамтач, эв нэгдэлтэй байх нөхцөл бүрдүүлж байна

	<ul style="list-style-type: none"> • Соёл спортыг дэмжиж, сайн сайхан амьдрах нөхцөлөө бүрдүүлэх авъяас чадварыг дэмжиж байна. <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020 ХГҮД А: Эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох ХГҮД В: Ядуу, бага, дунд орлоготой өрхүүдийг зохих стандартыг хангасан, чанартай, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах ХГҮД С: Аюулгүй амьдрах орчин нөхцөл бүрдүүлэх ХГҮД D: Осол эндэгдлийг бууруулах зорилгоор зам тээврийн аюулгүй байдал, түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж ХГҮД E: Нийгмийн эв нэгдэл, хамтач байдлыг дэмжих үүднээс Нэг Малайз үзэл санааг төлөвлүүлэх, ХГҮД F: Эрүүл амьдрал, эв нэгдлийг бэхжүүлэх үүднээс бүх төрлийн спортыг хөгжүүлэх.</p>
<p>Зорилго 4. Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан турш сурч боловсрох боломж бүрдүүлэх</p>	<p>Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө – Бүлэг 5 – Хүний нөөцийн хөгжлийг түргэсгэх замаар хөгжингүй улс үндэстэн болох Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> • 2015 он гэхэд ажилгүйдлийн түвшин 2,9% хүртэл буурч, хүн амаа бүрэн хөдөлмөр эрхлэх нөхцөлөөр хангасан • 2015 оны сүүл гэхэд 1.8 сая ажлын байрыг шинээр бий болгосон. • Эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин 2010 онд 46.8% байсан бол 2015 оны эцэс гэхэд 55% хүртэл нэмэгдүүлсэн. • МСҮТ-ийн хөтөлбөрт 2010 онд 113,000 хүн хамрагдаж байсан бол 2013 онд 164,000 болтлоо нэмэгдсэн. <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> • Шинээр ажлын байр олноор бий болж, бүрэн хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдэж байна. • Хууль эрх зүйн орчин, институтүүдийг сайжруулж хөдөлмөрийн зах зээлд шинэтгэл хийж байна. • МСҮТ-ийн чанартай хөтөлбөрүүд бий болж 8 хүртээмж нь нэмэгдэж байна • Насан туршийн боловсрол олгох хөтөлбөрүүдээр дамжуулан ажиллах хүчний үр чадварыг дээшлүүлж байна • Боловсролын үйлчилгээг сайжруулж чанар, хүртээмжийг нь дээшлүүлж байна <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020 ХГҮД А: Эдийн засгийн өсөлтөө түргэсгэхийн тулд хөдөлмөрийн зах зээлийн үр ашгийг дээшлүүлэх ХГҮД В: Аж үйлдвэрийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор МСҮТ-дэд шинэчлэлт хийх, ХГҮД С: Ур чадварыг дээшлүүлэх зорилгоор насан туршийн боловсролыг бэхжүүлэх, ХГҮД D: Төгсөгчид болон байгууллагын мэргэшлийн түвшинг дээшлүүлэх зорилгоор боловсролын чанарыг сайжруулах.</p>
<p>Зорилго 5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх</p>	<p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 3 – Хүртээмжтэй өсөлтийг дэмжиж тэгш нийгмийг байгуулах - Эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин 2009 онд 46.4 хувь байсан бол 2015 оны эцэс гэхэд 55 хувь хүртэл нэмэгдсэн. <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 3 - Эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны болон үйлдвэрлэл эрхлэх түвшинг нэмэгдүүлэх <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 3 – Тэргүүлэх чиглэл В: Хүн ардаа эрх мэдэлжүүлж бүтээлч, цэцэглэн хөгжих нийгмийг <ul style="list-style-type: none"> ○ Стратеги В3: Хөгжилд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг өргөжүүлж, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх; • Бүлэг 5 – Тэргүүлэх чиглэл Хөдөлмөрийн зах зээлийн үр ашгийг сайжруулж эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх <ul style="list-style-type: none"> ○ Стратеги А2–Хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагааг нь өргөжүүлэн тэлж хөдөлмөрийн зах зээлийн үр дүн, үр ашгийг дээд хэмжээнд нь хүргэх <ul style="list-style-type: none"> ○ Эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцоог өсгөн нэмэгдүүлж, хүртээмжийг нь нэмэгдүүлэх,
<p>Зорилго 6. Нийт хүн амыг баталгаат үндны үс, сайжруулсан ариун цэврийн</p>	<p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 3- 2013 он гэхэд нийт хүн амын 95 хувь нь цэвэр болон цэвэршүүлсэн усаар хангагдсан. • Бүлэг 7-2015 он гэхэд хүн амыг 41 сая нэгж бохир ус зайлуулах ариун цэврийн байгууламжид холбосон <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p>

байгууламжаар хангах	<ul style="list-style-type: none"> Бүлэг 7- Усны үйлчилгээний үйлдвэрлэлд бүтцийн өөрчлөлт хийх үйлсээ үргэлжлүүлсэн <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <ul style="list-style-type: none"> Бүлэг 7- Тэргүүлэх чилэл D Усны үйлчилгээний шинэчлэгдсэн үйлдвэрлэлийн тогтолцоонд шилжинэ.
<p>Зорилго 7. Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой, орчин үеийн сэргээгдэх эрчим хүчээр хангах</p>	<p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> Бүлэг 6 - Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль 2011 онд батлагдаж сэргээгдэх эрчим хүч ашигласны төлбөрийн тарифын тогтолцоо шинэчлэгдэн хэрэгжиж байна. <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> Бүлэг 7 - Эрчим хүчний үр ашигтай эх үүсвэрийг бий болгож эрчим хүчээр тасралтгүй хангах <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <ul style="list-style-type: none"> Бүлэг 6 – Тэргүүлэх чиглэл B Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ, үйлвэрлэлийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх <ul style="list-style-type: none"> Стратеги B2: Эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний хувь хэмжээг нэмэгдүүлэх Бүлэг 7 – Тэргүүлэх чиглэл E: Өсөлтийг дэмжих тогтвортой эрчим хүчний эх үүсвэр ашиглахыг хөхиүлэн дэмжих <ul style="list-style-type: none"> E1: Эрчим хүчний салбарт оролцогч талуудын зохицуулалт, хамтын ажиллагааг бэхжүүлэх E2: Зах зээлд түшиглэсэн хандлагын хүрээнд газрын тос, байгалийн хийн дэд салбарын ханган нийлүүлэлтийг хамгаалах, найдвартай байх нөхцөлийг баталгаажуулах, E3: Газрын тос, байгалийн хийн дэд салбарын өсөлтийг дэмжих E4: Ханган нийлүүлэлтийг төрөлжүүлж цахилгаан эрчим хүчний дэд салбарын аюулгүй байдлыг хангах E5: Цахилгаан эрчим хүчний дэд салбарын тогтвортой, үр ашигтай, найдвартай байх нөхцөлийг бүрдүүлэх
<p>Зорилго 8. Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийт хүн амыг баталгаатай орлого, аюулгүй ажлын байраар хангах</p>	<p>Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө – Бүлэг 8 – Эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангаж улс орноо хөгжүүлэн цэцэглүүлэх</p> <p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> Үйлчилгээний салбар жилд дунджаар 6.3%-иар өсч ДНБ-ний үйлдвэрлэлд 2,550 тэрбум МР-ийн хувь нэмэр оруулсан Аж үйлдвэрлэлийн салбар жилд дунджаар 4.8% өсч, ДНБ-ний үйлдвэрлэлд 1,111 тэрбум МР-ийн хувь нэмэр оруулсан Хөдөө аж ахуйн салбар жилд дунджаар 2.4% өсч8 ДНБ-нд 455 тэрбум МР-ийн хувь нэмэр оруулсан Барилгын салбар жилд дунджаар 11.1% өсч, ДНБ-д 194 тэрбум МР-ийн хувь нэмэр оруулсан ЖДҮ-ийн салбар жилд дунджаар 7.5% өсч, ДНБ-д 1,606 тэрбум МР-ийн хувь нэмэр оруулсан <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> Салбаруудын амжилт үр дүн Либерарчлал болон эрх зүйн зохицуулалтын шинэчлэлт Шинэтгэл Бүсийн эдийн засгийн коридоруудын хөгжил <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <p>ХГҮД А: Үйлчилгээ хүргэлтэд шинэчлэлт хийх ХГҮД В: Үйлдвэрлэлийг эрчимжүүлэх ХГҮД С: Хөдөө аж ахуйн салбарыг орчин үеийн болгох ХГҮД D: Барилгын салбарт шинэчлэлт хийх ХГҮД E: Эрчимтэй хөгжил бүхий ЖДҮ-ийг нэмэгдүүлэх ХГҮД F: Инновацийг баялаг болгон хувиргах ХГҮД G: Өрсөлдөх чадавх бүхий хот, бүс нутгийн эдийн засгийн коридорт хөрөнгө оруулах</p> <p>Засгийн газрын бодлогууд</p> <ul style="list-style-type: none"> Цалингийн доод хэмжээг тогтоох тухай хууль Бүрэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого Ажиллагчдын үр чадварыг давтан сургах замаар сайжруулах Үйлдвэрлэлд дадлагажигчдыг бэлтгэх Техник мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих
<p>Зорилго 9. Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж</p>	<p>Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө – Бүлэг 7 –Дэд бүтцийг бэхжүүлэн хөгжүүлж эдийн засгаа тэлэх</p> <p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <p>2010-2015 онд 93100 км шинэ зам барьж автозамын сүлжээг 68 хувиар нэмэгдүүлсэн</p> <ul style="list-style-type: none"> 2010-2015 онд Үндэсний замын хөгжлийн индексийг 1.42-с 2.29 хүртэл өсгөсөн.

<p>үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг хөхиүлэн дэмжих</p>	<ul style="list-style-type: none"> • Селангорын Кланг Порт (№13), Жохорын Танжун Пелепас Порт (№19) зэрэг хоёр порт дэлхийн 20 том портын жагсаалтанд орсон. • 2010-2014 онд нисэх буудлуудаар үйлчлүүлэгсэдийн тоо 39 хувиар нэмэгдсэн. • 2014 онд KLIA2 нээлтээ хийсэн бөгөөд 3-р зам нь KLIA-д ашиглалтад орсон. • 2010-2014 онд хо суурингийн төмөр зам түрээслэгчдийн тоо 32 хувиар нэмэгдсэн. • Дэлхийн банкны тооцоогоор Логистикийн үйлчилгээний индекс 2013 онд 29 байсан бол 2014 онд 25 болж сайжирсан. <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> • Биет дэд бүтцийг сайжруулж хүртээмж, холбоог өргөжүүлэх • Хүнд ээлтэй нийтийн тээврийн тогтолцоог хөгжүүлж байна • Логистик, Тээвэр зуулчлалын үйлчилгээ сайжирч байна. • Өргөн зурвасыг хамрах хүрээг нэмэгдүүлж, Газрын дижитал телевизийн хэрэглээнд шилжих хөдөлгөөнийг эхлүүлсэн • Ундны усны үйлчилгээний үйлдвэрлэлд бүтцийн өөрчлөлт хийх ажлын өрнүүлсэн. • Эрчим хүчний үр ашигтай эх үүсвэрийг ашиглан үйлчилгээг тасралтгүй хангах <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <p>ХГҮД А: Үйлчилгээ хүргэлтэд шинэчлэлт хийх ХГҮД В: Үйлдвэрлэлийг эрчимжүүлэх ХГҮД С: Хөдөө аж ахуйн салбарыг орчин үеийн болгох ХГҮД D: Барилгын салбарт шиэнчлэлт хийх ХГҮД E: Эрчимтэй хөгжил бүхий ЖДҮ-ийг нэмэгдүүлэх ХГҮД F: Инновацийг баялаг болгон хувиргах ХГҮД G: Өрсөлдөх чадавх бүхий хот, бүс нутгийн эдийн засгийн коридорт хөрөнгө оруулах</p>
<p>Зорилго 10. Улс орнуудын дотоод дахь болон улс хоорондын тэгш бус байдлыг багасгах</p>	<p>Засгийн газрын шинэтгэлийн хөтөлбөр (Үндэсний шинэтгэлийн хөтөлбөрийн хэсэг)</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөөгийн хөгжил түүний дотор эрүүл мэнд, биет дэд бүтэц, хөдөөгийн цахилгаанжуулалт • Хүүхдийн боловсролын хүртээмжийг сайжруулах • Ядуурлыг арилгах • Бизнес эрхлэгчдийг дэмжих • Эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцоог дэмжих • Хувь хүний орлогын татвар (750 ам.доллараас доош орлогыг татвараас чөлөөлөх)
<p>Зорилго 11. Хот, суурин газруудын тэгш хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих</p>	<p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 4 - Гудамж талбай олон нийтийн дунд аюулгүй зорчих нөхцөл бүрдүүлэх <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 4 – Тэргүүлэх чиглэл С Хөгжин цэцэглэж буй олон түмнийг аюулгүй амьдрах нөхцөл бүрдүүлэх <ul style="list-style-type: none"> ○ С1 Хууль сахиулах байгууллага, хувийн хүмүүсийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөжүүлж, олон нийтэд аюулгүй байдлын мэдрэмж төлөвшүүлэх ○ С2 Дүрэм журмыг чангатгах, хууль сахиулах ажиллагааг бэхжүүлж хүчирхийллийг зогсоох ○ С3 Гэмт хэргийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж гэмт хэргээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх ○ С4 Нөхөн сэргээх, эмчлэх, үйлчилгээний дараах тусламжийг өргөжүүлэн сайжруулж хар тамхи зэрэг хорт зуршилд донтсон өвчтөнг дахин хорт зуршилд автах явдлыг бууруулах • Бүлэг 4 – Тэргүүлэх чиглэл D Зам тээврийн аюулгүй байдлыг хангах, түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж осол гэмтлийг бууруулах <ul style="list-style-type: none"> ○ D1 Замын аюулгүй байдлыг хангаж гэнэтийн ослыг бууруулах ○ D2 Түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж хүний амь насыг хамгаалах
<p>Зорилго 12. Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих</p>	<p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <ul style="list-style-type: none"> • Бүлэг 6 – Тэргүүлэх чиглэл В Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн үзэл баримтлалыг нутагшуулах <ul style="list-style-type: none"> ○ В1 Ногоон зах зээлийн бий болгох ○ В2 Эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэх ○ В3 Эрэлт хэрэгцээний менежментийг өргөжүүлэн тэлэх ○ В4 Нүүрсхүчлээс татгалзахыг хөхиүлэн дэмжих ○ В5 Хог хаягдлын менежментийг сайжруулах

<p>Зорилго 13. Уур амьсгалын өөрчлөлт, түүний үр нөлөөг багасгах арга хэмжээг яаралтай авах*</p> <p>Зорилго 14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах, нөөцийг тогтвортой хөгжилд зүй зохистой ашиглах</p> <p>Зорилго 15. Хуурай газрын экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн нөөцийн тогтвортой байдлыг хангах, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг буруулах, биологийн төрөл зүйлийг мөхөж устахаас сэргийлэх</p>	<p>Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө – Бүлэг 6 – Тогтвортой, эрсдэлийг сөрөх чадавхитай ногоон өсөлтийг дэмжих</p> <p>Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ололт амжилтаас</p> <ul style="list-style-type: none"> • 2013 он гэхэд ДНБ-д нөлөөлөх хүлэмжийн хийн ялгарлыг 2005 оныхоос 33 хувиар бууруулсан • 2010 2010 онд Өрхийн дахин хэрэглээний түвшин 5 хвь байсан бол 2015 онд 15 хувь болж өссөн. • 2013 онд түлш хэрэглээний стандартыг EURO 4M -р тогтоосон • 2011 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлагдсан, сэргээгдэх эрчим хүч ашиглалтын төлбөрийн тарифын механизм хэрэгжиж эхэлсэн. • Үерээс сэргийлэх 194 төсөл хэрэгжсэний үр дүнд нэг сая хүн үерийн ослоос хамгаалагдаж чадсан <p>Эргэн харахад: Малайз улсын 10 дугаар Таван жилийн төлөвлөгөө, 2011-2015: Ахиц дэвшил</p> <ul style="list-style-type: none"> • Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулж байна: Малайз улс нүүрсхүчлийн хэрэглээгээ бууруулж байна. • Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицож байна: Хүн амаа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хамгаалж байна. • Ард түмнийхээ экологийн хөрөнгийн хамгаалалтыг бэхжүүлж байна. <p>Цаашдын зорилт: Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө, 2016-2020</p> <p>ХГҮД А: Ногоон өсөлтийг дэмжих таатай орчинг бэхжүүлэх</p> <p>ХГҮД В: Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх</p> <p>ХГҮД С: Өнөө болон хойч үеийнхэндээ зориулан байгалийн нөөцөө хамгаалах</p> <p>ХГҮД D: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, байгалийн гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэх.</p>
<p>Зорилго 16. Амгалан тайван, бүх нийтийн оролцоог хангасан хуульт ёст нийгмийг цогцлоож, үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоо бүхий чадварлаг институцийг бүх шатанд бий болгох</p>	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэх Эдийн засгийн шинэ загвар (2010)-т хүртээмжтэй өсөлтийг дэмжихээр заасан, • Хүртээмжтэй өсөлтийг дэмжиж жилийн төсөвт тусгасан • Хууль, шүүхийн хараат бус болон шударга байдал • Төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төрийн албанд ажилд авахдаа хүн амын янз бүрийн бүлэг, олон янз байдлыг харгалзах
<p>Зорилго 17. Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг эрчимжүүлж, хэрэгжүүлэх арга механизм бүрдүүлэх</p>	<p>НҮБ-ын Хөгжийн хөтөлбөр, бусад олон улсын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллаж тогтвортой хөгжлийг дэмжин хэрэгжүүлэх,</p>

Хавсралт 2. Малайз улс 12 дугаар Таван жилийн төлөвлөгөөгөөрөө (2016-2020) тогтвортой хөгжлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ

11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний (2016-2020) зорилт, хөтөлбөр, төслүүд нь НҮБ-ын ТХЗ-уудтай ойролцоо (**Хавсралт 1**) тул тэдгээр нь тус Таван жилийн төлөвлөгөө төдийгүй ТХЗ-ыг ахиулж үргэлжлүүлнэ гэсэн үг. Гэхдээ НҮБ-ын ТХЗ батлагдахаас өмнө 2013 онд Малайз улс 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөгөө (2016-2020) боловсруулсан. Тиймээс 2017 оноос эхлэн жил, жилийн төсвийн төлөвлөгөөгөө боловсруулах, мөн 2019 онд хийгдэх Таван жилийн төлөвлөгөөний дүнд хугацааны биелэлтийг үнэлэх, 2030 он хүртэлх дараагийн төлөвлөгөө боловсруулахдаа ТХЗ-ыг үргэлжлүүлэн нэгтгэн авч үзнэ.

"Өсөлтийг хүний төлөө" сэдэвт 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд (2016-2020) эрс хурдацтай өөрчлөгдөн хувирч буй дэлхий ертөнцтэй хөл нийлүүлэн эдийн засгаа хөгжүүлэхэд чиглэсэн стратегийн тулгуур зургаан зорилтыг дэвшүүлсэн. Үүнд: i) Тэгш шударга нийгмийг байгуулах үүднээс хэн нэгнийг орхигдуулахгүй байх; ii) Бүх нийтийн аж байдлыг сайжруулах; iii) Хүмүүн капитал буюу хүний нөөцийн хөгжлийг түргэсгэж хөгжингүй улс үндэстэн болно; iv) Тогтвортой, бэрхшээлийг даван туулах чадвартай улс орон байхын төлөө ногоон өсөлтийг дэмжих; v) Эдийн засгаа өргөжүүлэн тэлэхэд шаардлагатай дэд бүтцийг бэхжүүлнэ; vi) Эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг хангах үүднээс өсөлтийг дахин инженерчлэх буюу шинэ арга барилаар хангана.

Хөгжлийн зорилгууд нь хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөх үндэс юм. Мөн 11 Таван жилийн төлөвлөгөөний хүрэх ёстой гол үр дүнг харуулна. Тухайлбал, Тэгш шударга нийгмийг байгуулах үүднээс хэн нэгнийг орхигдуулахгүй байх тулгуур зорилт 1 нь ядуурлыг арилгах ТХЗ 1, тэгш бус байдлыг бууруулах ТХЗ 10-тай дүйцэж байна. Мөн ногоон өсөлтийн талаарх тулгуур зорилт 4-ийн агуулга нь тогтвортой хот суурин, орон нутгийн хөгжлийг хангах, хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэл, үүр амьсгалын өөрчлөлтийн талаар явуулах үйл ажиллагаа, биологийн олон янз байдал, байгаль орчны талаарх ТХЗ-уудтай адил төстэй.¹⁷

11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө нь хүний хүчин зүйлд суурилсан эдийн засагт гол анхаарлаа хандуулснаараа Засгийн газар хөгжлийн үр шимийг хүмүүсийн амьдралыг тэтгэх, нэр төрийг нь дээдлэх, эдийн засагт оролцох нөхцөлөөр хангахад чиглүүлэх амлалт, үүргээ дахин бататгасан. Тус төлөвлөгөөнд 2020 он хүртэлх Алсын хараа, Эдийн засгийн шинэ загварт заасан, хүртээмжтэй өсөлт, тогтвортой хөгжлийн асуудлыг залгамжлан тусгасан.

Нийгмийн аль нэг бүлгийг орхигдуулахгүйн тулд Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд нийт хүн амдаа тэгш боломж олгоход чиглэсэн олон арга хэмжээ авахаар заасны дотор орлогын доод 40 хувьд (Д40) багтдаг өрхийг онцгойлон авч үзсэн. Үүнийг үр дүнд суурилсан дэмжлэг, бүтээмжтэй уялдуулсан тусламж, түүний дотор бизнес эрхлэлт, ур чадварын сургалт, технологи нэвтрүүлэх, хөрөнгийн өмчлөл, харилцаа холбоо болон суурь үйлчилгээг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийх зэрэг санаачилгаар дамжуулан хэрэгжүүлнэ. Энэ зорилгод хүрэхийн тулд дараах аргыг ашиглана. Үүнд: "орлогын доод 40 хувьд багтах өрхийг дундаж давхаргын эгнээнд хүргэх", "нутгийн иргэдийг мэдэлжүүлэх замаар эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх", "хөдөөгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэх үүднээс хөдөөд эрс шинэчлэлт хийх", "бүс нутгийн өсөлтийг түргэсгэх; алслагдсан Бумипутерагийн хүн ардын "эдийн засгийн нөхцөл боломжийг сайжруулах зэрэг болно.

2020 он гэхэд тус улс Д40 хэсэгт багтдаг өрхийн дундаж орлогыг хоёр дахин нэмэгдүүлж, 2014 онд 2537 МР байсныг 5,270 МР-д хүргэж, улмаар дундаж орлоготой давхаргад багтдаг болгоно. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин 2014 онд 53% байсан бол 2020 онд 59%-д хүрнэ. Хүмүүст чанартай эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүргэх, орон сууцаар хангах, хөрш зэргэлдээ болон олон нийтийн газруудад аюулгүй амьдрах, зорчих орчинг бий болгох зэргээр нийгийн бүх хэсгийн амьдралын түвшинг сайжруулна.

Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд нэг сая орчим орон сууц, үүнд, 653,000 шинэ орон сууц барих, 400,000 гаруйг нь засварлан шинэчлэх замаар зах зээлд нийлүүлэх зорилт тавьсан. Хөдөө орон

¹⁷ Өмнөх бүлэг хэсгүүдэд тогтвортой хөгжлийн зорилгыг хөгжлийн төлөвлөлтөд хэрхэн уялдуулан тусгаж байгаа талаар тодорхой өгүүлсэн.

нутагт биет дэд бүтэц болон мэдээлэл харилцаа холбоог хөгжүүлэх, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бий болгох замаар хүмүүсийн харилцаа холбоо, чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүний нөөцийг хөгжүүлэх нь үндэсний хөгжлийн хамгийн чухал нөөц боломж юм. Ийм учраас 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд боловсролын чанарыг сайжруулах, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг сайжруулах замаар хүмүүсийн ур чадварыг бэхжүүлэхэд онцгойлон анхаарсан.

Ирээдүй хойч үеийнхэндээ байгаль орчноо хамгаалан үлдээх болон уур амьсгалын өөрчлөлтийн эрс тэс нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөний Зорилт 4 нь хөгжлийн төлөөх ногоон өсөлтийн стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн. Энэ нь Малайз улсын байгаль орчин, түүний урт хугацааны тогтвортой байдлыг хангах талаар хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлийг илэрхийлж байгаа юм.

Хөдөө орон нутгийг хөгжүүлэхийн тулд 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд Сабах, Саравакийн бүс нутагт үс хангамж, ариутгах татуургын дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд 10 тэрбум МР, цахилгаан эрчим хүчээр хангах дэд бүтцийн төслүүдэд 3 тэрбум МР хуваарилсан. Бүс нутгийн хөгжилд зориулж нийтдээ 236 тэрбум МР хуваарилсан бөгөөд эдгээр нь Малайзийн зүүн, хойд, өмнөд хэсгийн таван бүс нутгийн хөгжлийн коридоруудад хэрэгжин, 470,000 ажлын байр шинээр бий болгоно.

Доорх зурагт Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөг боловсруулсан үе шатыг үзүүлэв.

Үйл ажиллагаа	2013		2014			2015	
	Ул4	Ул1	Ул2	Ул3	Ул4	Ул1	Ул2
Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөг бэлтгэх тухай ЗГ-ын ЕНБД-ын баталсан Удирда мж	10-р сар						
Стратегийн баримт бичгүүдийг боловсруулах							
Стратегийн баримт бичгүүдийг хянаж за свэрлах							
Макро хүрээг тодотгох							
БХТХ, МАХ							
Төсвийн төсөл боловсруулах Удирда мж							
Яамд, төрийн байгууллагуудад заавар хүргүүлэх							
Төлөвлөгөөний агуулгыг боловсруулах							
Төлөвлөгөөг хянаж за свэрлах							
Орчуулга							
ҮХТХ-нд Стратегийн баримт бичгүүдийг танилцуулах							
ҮХТХ-нд Төлөвлөгөөний төслийг танилцуулах							
Ерөнхий сайдын тусгай хороонд Төлөвлөгөөний төслийг танилцуулах							1 сар
Засгийн газарт Төлөвлөгөөний төслийг танилцуулах							2 сар
Хэвлэлт							3 сар
Парламентар Төлөвлөгөөний төслийг батлуулах							4/5 сар
МАХ-д Стратегийн баримт бичгүүдийг танилцуулах		2 сар					6 сар
БХТХ-ийн уулзалт		1 сар					

(Эх сурвалж: ЭЗТГ, 2016)

Хавсралт 3. Малайз улсын 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөө: БХТХ, МАХ, ФБ

Байгууллага хоорондын төлөвлөлтийн хэсэг (БХТХ)	Мэргэжлийн ажлын хэсэг (МАХ)	Фокус бүлэг (ФБ) (сэдэвчилсэн)
Хөдөө аж ахуй	Агрохүнс	<ul style="list-style-type: none"> • Бүтээмж • Хөрөнгө оруулалт • Өртөгийн сүлжээ • Хүний нөөц • Механикжуулалт • Инститүцийг бэхжүүлэх талаар
	Аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Бүтээмж • Өртөгийн сүлжээ • Хөрөнгө оруулалт • Судалгаа ба хөгжил, Инновац, Хүний нөөц
Ногоон өсөлт	Биологийн олон янз байдал, Байгаль орчны менежмент, уур амьсгалын өөрчлөлт	<ul style="list-style-type: none"> • Биологийн олон янз байдал • Уур амьсгалын өөрчлөлт • Хог хаягдал • Байгаль орчин
	Байгалийн нөөцийн менежмент	<ul style="list-style-type: none"> • Газрын менежмент, гео Geospatial • Усны цогц менежмент • Эрдэсийн менежмент
	Эрчим хүч Ногоон өсөлт Гамшгийн эрсдэлийн менежмент	<ul style="list-style-type: none"> • Байгалийн хий/газрын тос • Эрчим хүч/Цахилгаан • Сэргээгдэх эрчим хүч • Үр ашигтай эрчим хүч
Үйлчилгээ	Аялал жуулчлал, Соёл, Урлаг	<ul style="list-style-type: none"> • Эко аялал жуулчлал • Хүний нөөцийн хөгжил • Холбоо харилцаа
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн халамж үйлчилгээний Аялал • Клиникийн судалгаа шинжилгээ • Уламжлалт болон Нэмэлт эмчилгээ
	Худалдааны хуваарилалт Барилга Үйлчилгээ Мэргэжлийн үйлчилгээ Хувийн боловсрол Халаалын үйлдвэр Бүтээлч үйлдвэрлэл	
	Бүсийн хөгжил (коридор/муж)	<ul style="list-style-type: none"> • Малайзын Искандар • Хойт Бүсийн Коридор • Зүүн эрэгийн бүсийн коридор • Сабахын хөгжлийн коридор • Саравакийн Сэргээгдэх эрчим хүчний Эдийн засгийн коридор
Мэдээлэл Харилцаа Технологи	Мэдээлэл, харилцаа, технологийн салбар	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл, харилцаа, технологийн салбар • Дижитал боломж • Мэдээлэл, харилцаа, технологийн хүний нөөц • Уугуул иргэдийн технологи
Дэд бүтцийг бэхжүүлэх	Мэдээлэл Харилцаа Технологийн дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл Харилцаа Технологийн дэд бүтэц
	Нийтийн тээвэр, төмөр зам Боомт, Нисэх онгоцны буудлууд Авто зам Эрчим хүч, ус, дулаан Логистик, худалдаа зуучлал	

Хүний нөөцийн хөгжил	Боловсрол	<ul style="list-style-type: none"> • Коллежид суралцах, хөдөлмөр эрхлэх бэлэн байдал, Сурагчдыг сургах тогтолцоо, Бүтэц • Сургалтын чанар, сургуулийн манлайлалыг сайжруулах • Боловсролын чанар, яамны шинэтгэл • Зохицуулалт, засаглал
	Дээд боловсрол	<ul style="list-style-type: none"> • Дээд боловсролын институцийн чадавхийн судалгаа шинжилгээ • Дээд боловсролын байгууллагууд, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа • Судалгаа, хөгжил, Инновацийн чадамж • Дэлхийн хэмжээний дээд боловсрол • Бизнес эрхлэгчдийн боловсрол • Софт/зөөлөн хөтөлбөрүүдийн үр ашиг • Малайзын Техникийн их сургуулийн сүлжээ • Сургалтын шинэ хөтөлбөр • Дээд боловсролын санхүүжилт • Дээд боловсролын элсэлтийн жендэрийн асуудал • Сургуулийн түр чөлөө • Сургалтын хөтөлбөртэй эмнэлэгүүд • Мэдлэг дамжуулах хөтөлбөрүүд • Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалт • Коллежийн сургалтын чанар • Сайн засаглал • Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт
	Техник, мэргэжлийн боловсрол сургалт Насан туршийн боловсрол	<ul style="list-style-type: none"> • Бүтээлч чанар, Агуулга • Техник, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын чадамж • Сургагчийн чанар • Аж үйлдвэрийн хамтын ажиллагаа • Санхүүжилт, бизнесийн модел • Нөлөөлөл сурталчилгаа, судалгаа, хөгжил, мэдээлэл харилцаа • Хөдөлмөрийн зах зээл, аж үйлдвэрлэл • Хамт олны хөгжил
	Хөдөлмөрийн зах зээл	<ul style="list-style-type: none"> • Хүн ам, хүн ам зүй • Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо • Цалингийн бүтэц • Хөдөлмөрийн бүтээмж • Хөдөлмөрийн зах зээлийн журам дүрэм • Хөдөлмөр эрхлэлтийн хамгаалал • Ажлын байр бий болгох • Өндөр үр чадвар шаардсан хөдөлмөр • Гадаадын ажилчид • Төрийн албаны хөдөлмөр эрхлэлт • Албан бус хэвшил
Аж үйлдвэр, Шинжлэх ухаан, Технологи, Инновац, ЖДҮ-үүд	Аж үйлдвэр	<ul style="list-style-type: none"> • Төмөрлөгийн үйлдвэр • Цахилгаан болон электрон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл • Машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл • Тээврийн хэрэгсэлийн үйлдвэрлэл (Автомашин, Далайн хөлөг онгоц, Нисэх онгоц, Батлан хамгаалах тоног) • Нефт химийн үйлдвэр • Эмийн үйлдвэрлэл • Эмнэлэгийн хэрэгсэлийн үйлдвэрлэл • Хүнс боловруулах үлдвэрлэл • Ургамалын тосны үйлдвэрлэл • Резин бүтээгдэхүүн үйлдвэрлэл • Ноосон эдлэл, даавууны үйлдвэрлэл • Мод, модон эдлэлийн үйлдвэрлэл • Дахин үйлдвэрдэл
	Шинжлэх ухаан, Технологи, Инновац	<ul style="list-style-type: none"> • Шинжлэх ухаан, нийгмийн судалгаа ба хөгжил, арилжаа • Авъяасыг хөгжүүлэх, өргөжүүлэх • Үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, хурдасгах технологи • Засаглалын шинэтгэл • Олон улсын стратегийн харилцааг бэхжүүлэх
	ЖДҮ	<ul style="list-style-type: none"> • Хөдөө аж ахуй, газар тариалан суурилсан үйлдвэрлэл

		<ul style="list-style-type: none"> • Барилга, уул уурхай • Бизнес, мэргэжлийн үйлчилгээ • Бусад үйлчилгээ, стратегийн чиглэл • Худалдааны түгээлт • Аж үйлдвэр
Иргэдийнхээ аж байдлыг сайжруулах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх • Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ • Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг оновчтой болгох • Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагуудын төлөвлөлт, хөгжил • Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал • Халдварт, болон халдварт бус өвчлөлийг бууруулах • Хүнсний аюулгүй байдал, чанар, байгаль орны эрүүл ахуй • Орон нутгийн иргэдийн хөгжлийг бэхжүүлэх • Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хөгжил, сургалт • Төлөвлөлт, хөгжлийн мэдээллийн технологи
	Нийтийн аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Аюулгүй байдал • Батлан хамгаалал
	Орон сууц Спорт Орон нутгийн засаг захиргааны үйлчилгээ Үндэсний эв нэгдэл	
Хүртээмжтэй өсөлтийг дэмжих	Хүртээмж	<ul style="list-style-type: none"> • Д40%, Хотын ядуурал • Д40%, Хөдөөгийн ядуурал • Эмзэг байдал Дунд40% • Тусгай хэрэгцээтэй хэсэг буюу цөөнхийн асуудал • Нийгмийн хамгаалал
	Бумипутера	<ul style="list-style-type: none"> • Хүний нөөц • Хувьцаа эзэмших, санхүүгийн бус хөрөнгө • Бизнес эрхлэгчид • Төрийн үйлчилгээг хүргэх тогтолцоо
	Хүн амын хэсэг бүлгийн хөгжил	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүд • Гэр бүл • Хүүхэд • Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс • Өндөр настанууд, бэлэвсэн эмэгтэйчүүд, эрчүүд • Бүтээлч халамж • Нийгмийн үйлчилгээ • Залуучууд
	Хот, хөдөөгийн шинэчлэл	<ul style="list-style-type: none"> • Хот суурийнгийн аж байдал • Хот суурийнгийн хүн амын тархалтын хөгжил • Хөдөөгийн эдийн засаг • Дэд бүтэц, тоног төхөөрөмж, хэрэгсэл • Стратегийн чиглэл, бүсийн хөгжлийн үүрэг • Хүний нөөц, хүн амын хэсэг бүлгийн хөгжил • Соёл, урлаг, өв
Төрийн үйлчилгээний шинэчлэл	Төрийн үйлчилгээг хүнлэг энэрэнгүй болгох, засаглалыг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Төрийн үйлчилгээг оновчтой болгож бэхжүүлэх нь • Төрийн үйлчилгээг хүргэх • Хариуцлагатай, шударга ёст байдал • Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт шинжилгээ • Хувийн хэвшлийн засаглал
Макро-эдийн засаг	Бүтээмж, өрсөлдөх чадвар	

Хавсралт 4. 3 дугаар Хэтийн төлөвлөгөөний хэсгээс (2001-2010), х.1, 6-8

I. УДИРТГАЛ

1.01 3 дугаар Хэтийн төлөвлөгөө нь 2020 хүртэлх Алсын хараанд заасан зорилгыг хэрэгжүүлэх 2 дахь арван жилийг хамрах бөгөөд бэрхшээлийг даван туулах, өрсөлдөх чадвар бүхий улс үндэстэн болохыг гол зорилгоо болгоно. Энэ хугацаанд хөгжлийн чанарыг дээшлүүлэх, тогтвортой өндөр өсөлтийг бий болгох замаар бүх нийтийн хөгжил цэцэглэлтийг хангах хүчин чармайлт гаргана. Үндэсний эв нэгдэл нь хөгжлийн үндсэн гол зорилго хэвээр үлдэж, олон үндэстэнтэй Малайз улс нь үндэстнүүдийнхээ хэл, соёл, шашин шүтлэгийг хүндэтгэн үзэж эв нэгдэлтэй, харилцан хүндлэлтэй, эрч хүчтэй нийгмийг хөгжүүлэхэд анхаарах болно. Малайзчуудын амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлогод тэргүүлэх ач холбогдол өгсөн хэвээр байх болно.

1.02 Тус баримт бичгийг боловсруулахдаа 2 дугаар Хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад гарсан ахиц дэвшил, сургамж, мөн 1997-1998 онд тохиолдсон Азийн санхүүгийн хямралын сургамжийг судалж үзсэн болно. Бодлого, стратегидаа улс орныхоо давуу талд түшиглэн тулгарч буй бэрхшээл сорилтыг шийдвэрлэх, дэлхий дахинаа бий болж буй өрсөлдөөнт сорилтуудыг даван туулах зорилго тавьж байна. Өнгөрсөн хугацаанд баримталж байсан чиг хандлагаа уламжлуулан хадгалж Засгийн газар нь нэгдмэл цогц байдлаар эдийн засгийн хөгжлөө дэмжих бөгөөд ингэснээр өсөлтөө тогтвортой хадгалж, үндэстнүүдийнхээ эв нэгдлийг хөхиүлэн дэмжиж, улмаар улс үндсээрээ улам нягтран хамтрах болно. Эдийн засгийн үндэсний 2 дугаар Зөвлөлдөх зөвлөлийн тайланд туссан хүн амын янз бүрийн бүлгүүдийн төлөөллөөс ирүүлсэн олон талын үзэл бодол, санал зөвлөгөө оюуны хувь нэмэр оруулсныг энэхүү баримт бичигт мөн тусгасан.

1.03 3 дугаар Хэтийн төлөвлөгөөг Үндэсний Алсын хараат бодлогод үндэслэн боловсруулсан. Үндэсний эв нэгдлийг чухалчилсан энэ бодлого нь бүрэн дүүрэн, шударга түншлэлд тулгуурлан эв нэгдэлтэй, хамтач, цэцэглэн хөгжсөн Малайзыг байгуулах зорилготой. Мөн ядуурлыг бууруулах, нийгэмд бүтцийн өөрчлөлт хийхэд чиглэсэн эдийн засгийн өсөлтийг хөхиүлэн дэмжинэ. Нийгэм, эдийн засаг, бүс нутгийн тэнцвэргүй байдлыг бууруулна. Материаллаг аж байдлыг сайжруулах, 1 дүгээр бүлэгт дурьдсан Тогтвортой, бэрхшээлийг даван туулах чадвартай эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн хөгжил болон хүмүүсийнхээ хөгжлийн талаарх итгэл бишрэлд эерэг нөлөө үзүүлэх, түүнчлэн улс орныхоо хөгжлийг урт удаан хугацаанд тогтвортой байх нөхцөлийг хангахад чиглэсэн хөгжлийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.

III. ҮНДЭСНИЙ АЛСЫН ХАРААТ БОДЛОГОД ТУССАН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

1.10 Тус бодлого нь өмнөх жилүүдэд хэрэгжүүлж ирсэн хөгжлийн төлөвлөгөөнүүдэд заасан хүчин чармайлт дээр суурилж боловсруулагдсан бөгөөд Малайз улсаа 2020 он гэхэд хөгжингүй улс үндэстэн болгон хувиргах үндсийг бэхжүүлэх зорилготой. Өрсөлдөх чадвартай, эрч хүчтэй, хүчирхэг, бэрхшээлийг даван туулах чадвартай эдийн засагтай байхаас гадна Малайз улс нь эв нэгдэлтэй, өндөр ёс суртахуун, ёс зүйтэй, ардчилсан, либерал, харилцан хүндлэлтэй, халамжтай, шударга, тэгш эрхтэй, дэвшилтэт, цэцэглэн хөгжсөн орон болохыг зорьж байна.

1.11 Үндэсний алсын хараат бодлого нь хүн амаа арьс өнгөнөөс нь үл хамааран ядуурлаас ангижруулах, нийгмийн бүтцийн өөрчлөлт хийх зэрэг Эдийн засгийн шинэ бодлогын (ЭЗШБ) гол гол стратегийн зорилтыг агуулж байгаа бол Үндэсний хөгжлийн бодлого (ҮХБ) нь тэнцвэртэй хөгжлийг онцгойлон зорьж хөгжлийн стратегийн шинэ зорилтуудыг тодорхойлсон. Дотоод болон гадаадад өрнөж буй хөгжлийн үйл явц нь бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, хөгжлийн бусад оролцогч тал бүгд сэтгэлгээндээ өөрчлөлт оруулах шаардлага гарч байна. Түүнчлэн илүү суралцах шаардлагатайг, хэрэггүй зүйлийг суралцах шаардлагагүйг, дахин суралцах хэрэгцээ гарч байгааг, хөгжлийнхөө зорилгод хүрэхийн тулд илүү үр ашигтай байхын тулд шинэлэг арга хэрэгсэл ашиглах, арга барилаа өөрчлөхийг шаардаж байна. Төрийн алба илүү идэвхтэй, үр ашигтай байх шаардлагатай зэрэгцээ хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авах хэрэгтэй.

1.12 Бодлогын шинэлэг зорилтууд:

- Малайз улсаа мэдлэгт суурилсан орон болгож хөгжүүлэх

- Дотоодын хөрөнгө оруулалтыг бэхжүүлж, өөрийн уугуул чадавхийг хөгжүүлэх замаар дотоодын хөрөнгө оруулалтаа суурилсан өсөлтийг болгох, стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (ГШХО) үргэлжлүүлэн татах;
- Мэдлэгт суурилсан хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжлийн эрч хүчийг нэмэгдүүлэх;
- Алслагдмал газар нутагт оршин суугчид, Сабах, Саравакт амьдардаг Оранг Асли, Бумипутерагийн үндэстний цөөнхийг ядуурлаас ангижруулах, мөн орлогоороо доод 30 хувьд хамрагддаг хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх, амьдралын чанарыг нь сайжруулах,
- Бумипутерагийнхний нийгмийн оролцоог үр дүнтэй болгох, 2010 он гэхэд баялаг эзэмшигчдийн хувийг дор хаяж 30 хувьд хүргэх;
- Эдийн засгийн тэргүүлэх салбаруудад Бумипутерагийнхний оролцоог нэмэгдүүлэх;
- Хүний нөөцийн хөгжлийг шинэ түвшинд хүргэх замаар мэдлэгт суурилсан нийгмийг дэмжих.

1.13 Энэхүү бодлого нь өмнөө тулгарч буй сорилт бэрхшээлийг даван туулах, шийдвэрлэх үндэсний чадавх, чадамжийг бэхжүүлэхэд чиглэсэн. Мөн бэрхшээлийн даван туулах, өрсөлдөх чадвартай үндэстэн байгуулах, эв нэгдэл, улс төрийн тогтвортой байдлыг хангах тэгш эрхт нийгмийг байгуулах зорилготой. Эдийн засгийн бүхий л үйл ажиллагааны үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар Малайз улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. Үүнээс гадна Малайз улсын эв нэгдэл, тогтвортой байдлыг хангахын тулд хүн амын хэсэг бүлэг бүрийн болон үндэстэн угсаатнууд, мөн бүс нутгууд дахь эдийн засгийн ялгаатай байдлыг арилгана. Хувийн хэвшил нь эдийн засгийн өсөлтийг манлайлагч байж, төрийн алба нь нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх зорилтыг хангахад шаардлагатай бүхий л нөхцөлийг бүрдүүлэхийг зорино.

1.14 Стратегийн гол зорилтууд:

- Улс орондоо эв нэгдэлтэй эх оронч үзлийг төлөвшүүлэх, улс төр нь тогтвортой, харилцан хүндэтгэлтэй, халамжтай, үнэт зүйлсээ эрхэмлэн дээдэлдэг нийгмийг байгуулах, амьдралын чанарыг дээшлүүлэх, эдийн засгийн найдвартай өсөлтийг дэмжих;
- Ядуурлыг арилгах, үндэстэн хооронд болон үндэстний дунд, бүс нутгийн хооронд оршин байгаа тэнцвэргүй байдлыг багасгах замаар тэгш шударга нийгмийг цогцлоох,
- Эдийн засгийн өсөлтийн эх сурвалжууд, санхүүгийн болон үндэстэн хоорондын институцүүд, макро-эдийн засгийн менежментийг бэхжүүлэх замаар өндөр өсөлтийг тогтворжуулах,
- Даяаршил, либералчлалд тулгарч буй сорилтыг сөрж даван туулах замаар өрсөлдөх чадвараа сайжруулах;
- Эдийн засгийн бүх салбарт нэмүү өртөг бий болгох чадварыг нэмэгдүүлэх, үндэснийхээ оюуны хүчийг оновчтой ашиглах замаар мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх нь стратегийн гол шугам байх болно;
- Мэргэжлийн чадвартай, бүтээмжтэй, мэдлэгтэй ажиллах хүчийг бий болгох замаар хүний нөөцийн хөгжлийг бэхжүүлэх;
- Байгаль орчиндоо ээлтэй тогтвортой хөгжлийг хангаж урт хугацааны турш дахь өсөлтийг бататгах, эрсдэлийг сөрөх чадвартай улс үндэстэнг бүтээн байгуулах ...